Link to the Pioneer Spirit

kcg.edu

The Kyoto College of Graduate Studies for Informatics

京都情報大学院大学

U R L:http://www.kcg.edu/
E-mail:admissions@kcg.edu

Лавлах хаяг: Киотогийн мэдээлэл технологийн эрдмийн зэрэг олгох их сургууль Элсэлтийн төв

〒606-8225 7 Tanakamonzen-cho, Sakyo-ku, Kyoto, Japan
TEL：075-681-6334 (+81-75-681-6334)
FAX：075-671-1382 (+81-75-671-1382)

モンゴル語 202111

Япон улсдаа хамгийн анхны мэдээлэл технологийн нарийн мэргэжлийн сургууль

Киотогийн мэдээлэл технологийн эрдмийн зэрэг олгох их сургууль

(KCGI : The Kyoto College of Graduate Studies for Informatics)

Япон улсын Киото хотод
Хамгийн дэвшилтэт мэдээллийн технологит суралцагаая

No.1 & the Only One ! 京都情報大学院大学 kcg.edu

Мэдээлэл технологийн салбарын өндөр түвшний боловсон хүчинг бэлтгэхийн тулд

Сүүлийн жилүүдэд шинжлэх ухаан, технологийн дэвшил, техник технологийн шинэчлэл, нийгэм эдийн засгийн огцом өөрчлөлт (олон төрөлжсөн, нарийн нийлмэл, өндөр түвшний, глобалчлагдсан, IoT-ын эрин үе ирсэн)-с үүдэн, нийгэм, олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн мэдээлэл технологийн салбарын өндөр түвшний мэргэжлийн боловсон хүчинг бэлтгэн гаргах шаардлага нэмэгдэж байна.

Гэвч, мэдээлэл, менежмент хоёроос бусад мэргэжлийн хүрээг хамруулсан мэдээллийн технологийн салбарын технологийн сургалтын хувьд, өнөөг хүртэл мэдээллийн технологийн өндөр түвшний мэргэжилтэн бэлтгэх их сургууль, эрдмийн зэрэг олгох сургалт огт байгаагүй.

Энэхүү нөхцөл байдлыг өөрчлөхийн тулд, Киотогийн мэдээлэл технологийн эрдмийн зэрэг олгох их сургууль нь 2004 оны 4 сард Япон улсдаа хамгийн анхны мэдээлэл технологийн мэргэжлийн боловсон хүчин бэлтгэх цорын ганц сургууль болон үүд хаалгаа нээсэн. Тус сургууль нь 57 жилийн түүхэн замналдаа, аж үйлдвэрийн салбарын хэрэгцээнд нийцүүлэн мэдээлэл технологийн инженерийг бэлтгэж ирсэн япон улсдаа хамгийн анхны компьютерын боловсрол олгох “Киото компьютерийн Гакүин”-н түүхэн уламжлал болон амжилт ололтоо өвлөн ирсэн билээ. Мөн, Рочестерын технологийн их сургуулиас эхлээд гадаадын бусад их дээд сургуулиудтай холбогдсон глобал боловсролын сүлжээг үндэслэн дэлхийн хамгийн орчин үеийн мэдээлэл технологийн сургалтын хөтөлбөрийг нэвтрүүлж, улмаар удирдлага, менежментийн сургалтын хажуугаар, урьд нь судалгааны магистрын сургуульд сурган төлөвшүүлэхэд бэрхшээлтэй байсан мэдээлэл технологийн салбарын өндөр түвшний мэргэжилтнүүд, ялангуяа CIO (Мэдээллийн албаны дарга) зэрэг мэдээллийн технологийн хэрэглээний салбарын шилдэг удирдагчдыг сургаж байна.

Сургуулийн үзэл баримтлал

Манай сургуулийн зорилго нь нийгмийн эрэлт хэрэгцээг хангах, одоогийн болон хойч үеийнхнийг бэлтгэх чадвар бүхий бизнесийн өнөөгийн байдлын талаар хангалттай мэдлэг туршлагатай, онолын суурь мэдлэгийг өндөр түвшинд эзэмшсэн, бүтээлч, шинэлэг сэтгэлгээтэй мэдээлэл технологийн өндөр түвшний мэргэжилтнүүдийг бэлтгэхэд оршино.

KCGI-ийн эрхэм зорилго ба зорилтууд

IT-н нийгэм дэхь өндөр түвшний янз бүрийн хүний нөөцийн хэрэгцээ шаардлагыг хангах, цаашлаад хаа саагүй компьютержих энэхүү эрин үед ердийнхөөс өндөр түвшний үнэ цэнэтэй мэдлэг чадвар эзэмшсэн IT-н өндөр түвшний мэргэжилтнүүдийг бэлтгэн гаргаснаар өндөр түвшний мэдээллийн нийгмийг бий болгох, эдийн засгийн хөгжилд хувь нэмэр оруулахад оршино.

Бидний зорилго өндөр түвшний мэргэжилтнүүдийг сургаж бэлтгэхэд мэдээллийн болон бусад технологийн хөгжилтэй хөл нийлүүлэн алхах, шинжлэх ухаан, технологи, бизнесийн удирдлагатай холбоотой сургалтын чиглэлүүдээр онол, дадлага хосолсон технологийн боловсрол олгоход оршино.

kcg.edu
The Kyoto College of Graduate Studies for Informatics

Элсэлтийн бодлого

IT /ICT-н салбар нь мэдээллийн салбар болон менежментийн салбарын аль алиныг хамарсан цогц салбар тул зорилт нь цогц бөгөөд янз бүр байдаг. Тиймээс IT-н салбарт ирээдүйтэй өндөр авьяас чадвар бүхий мэргэжилтнүүдийн хэрэгцээ урьд өмнөхөөсөө илүү өсөн нэмэгдэж, төрөлжиж байна. Япон улсын одоогийн боловсролын тогтолцоо нь зөвхөн инженерийн мэргэжлийн зэрэг олгох сургуулиудад суралцаж буй инженерийн бакалаврын оюутнуудыг хөгжүүлэхэд чиглэж байгаагийн улмаас өнөөдрийг хүртэл Японд тус салбарын өндөр авьяас чадвар бүхий төрөл бүрийн мэргэжилтнүүдийн эрэлт хэрэгцээг хангах боломжгүй байсан билээ. Цаашид Япон улсын аж үйлдвэр, эдийн засгийг улам хөгжүүлэхийн тулд янз бүрийн суурь боловсролтой хүмүүсийг сургаж, IT /ICT-н өндөр түвшинд мэргэшсэн мэргэжилтэн бэлтгэх нь чухал юм.

Эдгээр хэтийн төвлийг харгалзан манай сургууль заавал бакалаврын зэрэгтэй байх ёстой гэсэн шаардлага тавихгүйгээр янз бүрийн суурь боловсролтой олон оюутнуудыг элсүүлэх бодлого баримтлан ажиллаж байна.

1) Манай сургуульд мэргэжлийн боловсрол эзэмших суурь академик чадвартай хүмүүс.

2) Шинэ зүйл сурч мэдэх, бие даан шинээр сэтгэх, тогтсон ойлголтонд баригдалгүйгээр шинэ зүйл бүтээх хүсэл эрмэлзэлтэй хүмүүс.

3) Бусадтай хамтран ажиллах болон бусадтайгаа хамтран асуудал шийдвэрлэх хүсэл эрмэлзэлтэй хүмүүс.

KCGI-н сургалт

The Kyoto College of Graduate Studies for Informatics

Киотогийн мэдээлэл технологийн эрдмийн зэрэг олгох их сургууль

Киотогийн мэдээлэл зүйн Гакүэн сургуулийн Профессор, Захирал

Хасэгава Ватарү

長谷川 亘

Васэда их сургуулийн хэл шинжлэлийн баклавар

(АНУ) Колумбын их сургуулийн боловсролын докторын зэрэг горилох эхний болон дунд улирлын сургалтыг дүүргэсэн

Киотогийн Мэдээлэл үйлдвэрлэлийн нийгэмлэгийн дарга

Үндэсний болон орон нутгийн мэдээлэл үйлдвэрлэлийн холбоо (ANIA)-ы гүйцэтгэх захирал

Японы IT-н байгууллагуудын хорооны орлогч дарга, зөвлөх

Тайландын Вант Улсын Боловсролын яамны дэд сайдын шагнал (хоёр удаа)

Бүгд Найрамдах Гана Улсын Боловсролын яамны шагнал

АНУ-ын Нью-Йоркт боловсролын удирдлагаар мэргэшсэн

Хятад улсын Тяньжиний Шинжлэх Ухаан Технологийн Их сургуулийн зочин профессор

БНАСАУ-ын хуурай газар, далайн тээврийн салбарын дэргэдэх компани Чэжү олон улсын чөлөөт хот төлөвлөлтийн төвийн Бодлогын зөвлөлийн гишүүн

Хариуцах хичээл : “Удирдлагын онол”, “Магистрын төсөл”

Киотогийн мэдээлэл технологийн эрдмийн зэрэг олгох их сургууль (KCGI) нь Японы анхны мэргэжлийн зэрэг цол олгох мэдээллийн технологийн сургууль юм. Үүний эхлэл нь Японы анхны компьютерийн сургалтын хувийн байгууллага болох Киото Компьютерийн Гакүин (KCG) юм. Үүний үүсгэн байгуулагч Хасэгава Шигэо болон Хасэгава Ясүко нарын ирээдүйг харсан өвөрмөц гүн ухаанд тулгуурлан нээсэн сургууль нь 1963 онд байгуулагдсанаас хойшхи 55 гаруй жилийн хугацаанд компьютерын сургалт явуулж ирсэн бөгөөд энэхүү хугацаанд ахлах сургууль төгсөгчдөөс гадна 4 жилийн сургалтанд олон оюутан элсэж төгссөн билээ. Тухайн үед манай улсад зөвхөн судалгааг голчилсон сургалтаар эрдмийн зэрэг олгодог сургуулиас өөр сургууль байгаагүй учраас иймэрхүү дээд сургуулийг төгссөний дараа элсэн орсон хүмүүсийн ихэнх нь ажил хэрэгтэй шууд холбоотой дээд боловсролын байгууллага хайсны үр дүнд, KCG-г сонгодог болсон. KCG нь тусгай боловсролын сургуулийн тогтолцоонд багтдаг байсан хэдий ч, нийгэмд их сургууль төгсөгчдөд зориулсан сургалтын их сургуулийн салбар сургууль төгсөгчдөд зориулсан байгууллагын үүргийг гүйцэтгэж, өөрөөр хэлбэл нэг төрлийн мэргэжил, бизнес ажил хэргийн эрдмийн зэрэг олгох сургуулийн үүргийг ч гүйцэтгэж ирсэн талтай.

Ийм урьдчилсан нөхцөл, туршлагадаа тулгуурлан, KCG нь 1998 оноос Америкийн Рочистерийн инженер техникийн их сургуулийн эрдмийн зэрэг олгох сургууль (Мэдээллийн технологи, компьютерийн шинжлэх ухаан гэх мэт)-тай хамтарсан төсөл хөтөлбөрийг эхлүүлж, практик сургалтанд чиглэсэн мэргэжлийн сургуулийн хөтөлбөрийг хэрэгжүүлж байна. Энэ нь, Японы мэргэжлийн сургууль болон эрдмийн зэрэг олгох Америкийн сургууль хоорондын программ солилцооны хувьд манай улсад хамгийн анхных болсон түүхэн үйл явдал байлаа.

Киото компьютерийн Гакүин (KCG)-ны чадварлаг мэргэжилтнүүдэд төгсөлтийн дараах мэргэжлийн сургуулийн шинэ тогтолцооны хүрээнд IT төвтэй боловсролын байгууллага байгуулах зайлшгүй шаардлага тулгарсан юм. Киотогийн мэдээлэл технологийн эрдмийн зэрэг олгох их сургууль (KCGI) нь санхүүгийн болон боловсролын салбарын холбогдох талуудын дэмжлэг, хамтын ажиллагааны хүрээнд байгуулагдсан бөгөөд сүүлд Рочестерийн Технологийн Дээд Сургууль, Колумбын Их Сургуулийн факультетууд үүнд нэгдсэн юм. Шинэ тогтолцоог нэвтрүүлсэн эхний жилд буюу 2004 оны 04-р сард KCGI нь Японы анхны бөгөөд цорын ганц IT-н мэргэжлийн зэрэг олгох сургуулийг нээсэн билээ.

KCGI-ын гол зорилго нь “нийгмийн хэрэгцээ шаардлагыг хангах, одоо үеийг дэмжих, дараагийн үе рүү биднийг хөтлөх бүтээлч, өндөр түвшний практик ур чадвар эзэмшсэн хэрэглээний мэдээллийн технологийн мэргэжилтнүүдийг бэлтгэх”-д оршино. KCGI нь IT-н боловсролыг олон улсын бизнесийн боловсролтой хослуулснаар Тооцоолон бодох машины холбоо (ACM)-ны Мэдээллийн систем (IS)-ийн магистрын курсын шинэчилсэн сургалтын төлөвлөгөөгөөр инженерүүдийг бэлтгэх, ялангуяа веб бизнес (цахим бизнес) -ээр мэргэшсэн CIO-г бэлтгэх программ бий болгосон. KCGI-ын эрхэм зорилго болон зорилт нь онцгой ур чадвар эзэмшсэн, өндөр мэдлэг боловсролтой, олон улсын түвшний IT-н мэргэжилтнүүдийг хангахад хувь нэмэр оруулах явдал юм. Эдгээр хүчин чармайлтынхаа үр дүнд бид эдийн засгийн хөгжил болон мэдээлэл технологийн дэвшилтэт нийгмийг бүтээхэд хувь нэмэр оруулж, IT болон бусад холбогдох технологитай хөл нийлүүлэн алхах ажлыг хөнгөвчилж, шинжлэх ухаан, технологи, бизнесийн менежменттэй холбоотой академик чиглэлүүдийн онол, практик хосолсон технологийн боловсролыг хангахад хувь нэмэр оруулж чадна гэдэгтээ итгэж байна. Түүнчлэн эдгээр ололт амжилтууд нь өндөр ур чадвар бүхий мэргэжилтнүүдийн дараагийн үеийг бэлтгэхэд хөтлөнө гэдэгт итгэж байна.

KCGI үүсгэн байгуулагдах хүртэл Япон улсын бакалаврын болон магистр докторын сургуулиудад веб бизнес (цахим бизнес)-тэй холбоотой мэргэжлийн хөтөлбөрүүд байдаггүй байсан. Эдгээр мэргэжлийг зөвхөн бизнесийн менежмент, аж үйлдвэрийн инженерчлэлийн технологи, мэдээлэл гэх мэт уламжлалт мэргэжлийн хөтөлбөрүүд туслах чиглэл болгон оруулдаг байв. Эдгээр мэргэжлийг системтэй цогц мэргэжлийн нэг хэсэг эсхүл үндсэн мэргэжлийн нэг хэсэг болгон заадаг байжээ.

KCGI нь МТ-ын өргөн хүрээнд IT-н мэргэжлийн сургуулийн хувьд манлайлах ур чадварыг олгоход чиглэсэн дэлхийн түвшний мэргэжлийн сургууль болохыг зорьж байгаагаараа ялгаатай юм. Ихэнх сургуулиудаас ялгаатай нь манай сургууль “төрөлжсөн нэг салбар”-ын мэдээллийн технологийн эрдмийн зэрэг олгох сургууль эсхүл мэдээлэлзүй, математикийн эрдмийн зэрэг олгох сургуулийн аль нь ч биш юм. Манай сургууль эдгээр сургуулиудтай олон талаараа ижил төстэй боловч өөр төрлийн IT-н чиглэлийн эрдмийн зэрэг олгох сургууль юм. Сурган хүмүүжүүлэх ухаанд суурилсан сургалтын хөтөлбөртэй, чадварлаг багшийн бүрэлдэхүүнтэй болсноос гадна KCGI нь Японы их дээд сургуулиудад ховор ажиглагддаг өргөн хүрээний бодлого, элементүүдийг нэгтгэсэн цогц боловсролын системийг бий болгохыг зорьж байгаа юм. Тухайлбал суралцагч-төвтэй сургалтын төлөвлөгөө, ажиллах хүчний нөөлттэй болон хэвтээ хуваарилалттай боловсролын тогтолцоо, сургалтын үр дүнгийн шаталсан үнэлгээ гэх мэт.

Түүнчлэн KCGI нь Ази болон дэлхий дахинд ажиллах чадвартай IT болон менежментийн ур чадварыг хослуулсан олон улсын манлайлагч, бизнес эрхлэгчдийг бий болгоход анхаарч байна. Азид номер нэг мэдээллийн технологийн мэргэжлийн сургууль болохын тулд бид үүсгэн байгуулагдсан цагаасаа хойш KCGI-д дэлхийн эргэн тойрноос оюутан суралцагчид элсүүлэхийг нэг гол зорилтоо болгон ажиллаж байна.

Өнөөдөр IT нь бидний өдөр тутмын амьдрал болон аж үйлдвэрийн салбарын салшгүй хэсэг болжээ. Олон төрлийн чиглэлээр салбарлан хөгжиж буй IT нь нийгмийн төрөл бүрийн хэрэгцээг хангаж байна. KCGI нь төгсөгчиддөө IT-н суурь ойлголт, сонгосон салбартаа чухал үүрэг роль гүйцэтгэх ур чадвар, аж үйлдвэржсэн дэлхийд ур ашигтай практик ур чадвар эзэмшүүлэхийн тулд сургалтын хөтөлбөрөө тогтмол шинэчлэн сайжруулдаг. 2018 оны хичээлийн жилд KCGI нь хичээлд бүртгүүлэх 3 хэлбэрийг нэвтрүүлсэн. Мэргэших хичээлүүд нь оюутнуудад тодорхой чиглэлээр суурь мэдлэгээс хэрэглээний арга техник хүртэлх мэргэжлийн ур чадвар олгодог. Төрөлжсөн хичээлүүд нь IT ашигладаг салбар бүрт ур дүнтэй төлөвлөлт, шийдлийн ур чадвар эзэмшүүлдэг. Мөн түүнчлэн оюутнуудын төрөл бүрийн суралцах зорилгод нийцүүлэн дундын сонгох хичээлүүдийн дагуу тодорхой чиглэлээр олон тооны хичээл сонгон суралцах боломж бүрдүүлсэн. KCGI-д эзэмшсэн практик ур чадвар, өргөн хүрээний мэдлэг боловсролынроо тусламжтайгаар манай төгсөгчид Япон болон олон улсад төрөл бүрийн салбарт чухал үүрэг гүйцэтгэн ажиллаж байна.

KCGI нь мөн Саппоро болон Токио хотуудад хиймэл дагуулын оюутны хотхон байгуулсан. Эдгээр хиймэл дагуулын хотхонууд нь Киотогийн төв сургуультай цахим сургалтын системээр холбогдсон тул эдгээр хиймэл дагуулын хотхонд суралцахынхаа зэрэгцээ IT-н мэргэжлийн боловсрол эзэмших боломжийг бүрдүүлж өгсөн. Цагийг чанд баримтлан сургалт явуулдаг нь оюутнуудад профессоруудаас камераар шууд асуулт асуух боломжийг олгодог. Мөн эдгээр сургалтуудын бичлэгийг хийж хадгалдаг тул оюутнууд манай сервер дээр хадгалагдсан хичээлүүдийг гэрээсээ үзэх боломжтой. Орон зай, цаг хугацааны хязгааргүйгээр оюутнууд хаанаас ч, хэзээ ч мэргэжлийн боловсрол эзэмших боломжтой болсон. Түүнээс гадна KCGI нь дэлхийн эргэн тойрон дахь, тухайлбал АНУ, Хятад, БНСУ-ын дээд боловсролын байгууллагуудтай нягт холбоо харилцаатай ажилладаг. KCGI нь энэхүү олон улсын холбоо харилцаагаа улам өргөжүүлэхийн зэрэгцээ боловсролын үйл ажиллагаагаа идэвхтэй хөгжүүлэн ажиллаж байна.

Өнөөдөр дэлхий дахинд өрнөж буй өөрчлөлтүүдийн дотроос KCGI нь өөрийн үзэл баримтлал, үүсгэн байгуулагдсан зорилго, зорилтуудынхаа хүрээнд өндөр түвшний IT-н мэргэжилтнүүдийг бэлтгэхээр шаргуу ажиллаж байна. Мөн та бүхэн шиг эрч хүчтэй оюутнуудыг элсүүлэхийг тэсэн ядан хүлээж байна.

kcg.edu

The Kyoto College of Graduate Studies for Informatics

Цаг үеийн эргэлтийн цэг дээр ирсэн нь

Захирлын мэндчилгээ

Киотогийн мэдээлэл технологийн эрдмийн зэрэг олгох их сургууль,
Хэрэглээний Мэдээлэл Технологийн Сургуулийн Захирал & Тэргүүн

Ибараки Тошихидэ 茨木 俊秀

Киотогийн их сургуулийн инженерийн баклавр,
тус сургуулийн доктронтурыг дүүргэсэн (Электрон техникийн инженерийн мэргэжлээр),
техникийн инженерийн доктор Киотогийн их сургуулийн хүндэт профессор,
Киотогийн их сургуулийн эрдмийн зэрэг олгох их сургуулийн мэдээлэл судлалын тэнхимийн эрхлэгч,
эрдмийн зэрэг олгох Кансайн их сургуулийн профессор асан,
Иллиной их сургуулийн зочин профессор. ACM, электрон мэдээлэл харилцаа холбооны тэнхим,
Мэдээлэл боловсруулах тэнхим,
Японы хэрэглээний математикийн тэнхим болон бусад 4 тэнхимийн гишүүн

Хариуцах хичээл : “Дэвшилтэт системын онол”, “Магистрын төсөл”

18-р зууны сүүлийн хагасаас өрнөсөн аж үйлдвэржилтийн хувьсал нь уурын хөдөлгүүр хэмээх шинэ хөдөлгүүр бий болсноос үүдэлтэй.
Үйлдвэрлэлийн хүчин чадлын өсөлт нь цаашдаа цахилгаан, газрын тосны хэрэглээнээс шалтгаалан улам хурдасч, 20-р зууны сүүлийн хагас гэхэд хүн төрөлхтөний хэрэглэх хэрэгцээт хэмжээнээс хавьгүй их үйлдвэрлэлийн хүчин чадалтай болсон юм. Үүний үр дүнд, “тоо хэмжээнээс чанарын хувьсгал”-д явгдаж, эдүгээ хүртэлх масс үйлдвэрлэлийг цаг үеэс хоцрогдсонд тооцох болж, олон төрлийг цөөн тоогоор үйлдвэрлэх эрин үед шилжсэн юм. Энэхүү явцад, дэлхийн аж үйлдвэрлэлийн бүтэц ихээхэн өөрчлөгдөж, нийгмийн шинэ хэв журамтай болсон.
Үүнтэй адил үзэгдэл мэдээллийн ертөнцөд ч үүссэн юм. Гэхдээ асар хурдацтайгаар. Анхны компьютер бүтээгдсэнээс хойш 70 жил өнгөрч байгаа ч гэсэн, түүний шинэчлэл асар хурдтай өрнөж, үйлдлийн хурд болон санах багтаамж нь төсөөлөхийн аргагүй хүчин чадалтай болсон. Цаг агаарын өөрчлөлтийг тэмдэглэх хэсгийн хагас дифференциаль тэгшитгэлийг цаг уурын бодит өөрчлөлтөөс өмнө хурдан тодорхойлж чаддаг болсон нь цаг уурын урьдчилсан тооцоог гаргахад дөхөм үзүүлсэн. Санах багтаамжийн хана үндсэндээ үгүй болж, тухайлбал дэлхий нийтийн ном зохиолыг дежиталь өгөгдөл болгон сануулах боломжтой болсон. Хүний нэг насаараа үзэж сонссон бүх өгөгдлүүдийг сануулж ч болно. Энэ мэтийн мэдээллийн хүчний өсөлт нь бидний амьдрал, соёлын шинж чанарыг өөрчлөх хангалттай төвшинд хүрснээс зайлахгүй.
Уг нь, чанарын өөрчлөлтийн шинж тэмдэг 21-р зууны эхнээс огцом илэрсэн мэт санагддаг. Хялбархан функц буй болсон, хэмжээ жижгэрсэний үр дүнд гар утас болон смартфон нь хүмүүсийн халаасанд байх газраа олж, ялангуяа залуучуудын амьдралын хэв маягыг өөрчилсөн.
Интернетээр дамжуулсан харилцаа холбоо нь оптик ширхэгийн улмаас үсэг, фото зураг, хөдөлгөөнт өгөгдлийг хүртэл агшин зуур солилцохуйц болов. Мэдээлэл холбооны технологи (ICT) нь дэлхий дахины хүмүүсийг шууд холбогдсоноороо дэлхий дээрхи мөнгө санхүү, бизнесийг даяаршуулж, улс, нийгмийн байдалд хүртэл ихээхэн нөлөө үзүүлсээр байна. Мэдээж эдгээр өөрчлөлтүүд нь бүгд хүсүүштэй зүйлс байгаагүй. Мөн, компьютерийн гэмт хэрэг гэх мэтийн сөрөг талыг авчирсныг ч үгүйсгэх аргагүй. Энэ утгаараа орчин үе нь өөрчлөлтийн яг дунд нь, хэтрүүлж хэлбэл хүн төрөлхтний ирээдүйг шийдвэрлэх үе ирсэн гэж болно.
Тус сургуулийн эх болох Киотогийн компьютерийн сургуулийн үүсэл нь 1963 он, компьютерийн сургалтын байгууллагын хувьд компьютерийн хөгжилтэй хамт өсч өндийн, өмнөхөөсөө илүү чадвартай олон боловсон хүчнийг төгсгөж ирсэн юм. Энэхүү уламжлал болон бодит туршлагаа залгамжлан, улсынхаа анхны мэргэжлийн эрдмийн зэрэг олгох сургууль болох Киотогийн мэдээлэл технологийн эрдмийн зэрэг олгох их сургууль байгуулагдаж, 2003 оны 11 сард сургууль байгуулснаа зарлан, 2004 оны 4 сард анхныхаа оюутнуудыг угтсан юм. Цаг үеийн шийдвэрлэх мөчид, хөл дээрээ баттай алхаж чадсан гэж болно. Тус сургууль нь мэдээлэл холбооны технологийн аливаа судалгааг хуримтлуулангаа, түүний нийгэмд үзүүлэх нөлөөг бүрэн ойлгож, зөв чиглэлд залж чадах боловсон хүчин бэлтгэхийг хүсдэг. Сурах хүсэл эрмэлзлэлтэй хүнд, нас сүүдэр, эрхэлж байсан ажил, соёл иргэншил үл харгалзан хаалга үүдээ нээлттэй байлгадаг. Их сургуулиа дөнгөж төгссөн хүн мэдээж, аль хэдий нь бодит нийгэмд зүтгэж байгаа карьер ахихыг хүссэн хүн, гадаадад байгаа атлаа Японд хичээллэхийг хүсдэг оюутан, бид иймэрхүүсийн элсэлтийг чин сэтгэлээсээ баярлан угтах болно.

KCG-ын сүлд тэмдэг

kcg.edu

KCG групп нь дэлхийн боловсролын байгууллагуудын ассемблей юм. Үүнд Киото компьютерийн Гакүин (Ракүхокү сургууль, Камогава сургууль, Киото Экимаэ сургууль), Киотогийн мэдээллийн эрдмийн зэрэг олгох их сургууль, Киото Автомашины мэргэжлийн сургууль, Киото Япон хэлний сургалтын төв болон KCG карьер зэрэг багтдаг. KCG группын бэлгэ тэмдэг болох “kcg.edu" нь 2003 онд KCG группын гүйцэтгэх захирал Хасэгава Ватарүгийн сонгосон бэлгэ тэмдэг бөгөөд 1995 онд авсан интернетийн домэйн нэр (www.kcg.edu)–ээс үүдэлтэй.
“kcg” гэсэн домэйн нэр нь Японы хамгийн анхны компьютерийн боловсролын байгууллагын нэр болох “Киото Компьютерийн Гакүин” гэсэн үгний эхний үсэг юм. “.edu” гэдэг нь дээд шатны ерөнхий домэйн нэр (gTLD: тэргүүлэх салбарын интернет домайнуудын нэг) бөгөөд зөвхөн АНУ-ын магадлан итгэмжлэлийн байгууллагуудад хүлээн зөвшөөрөгдсөн дээд боловсролын байгууллагад олгодог. Боловсролын байгууллагуудыг анх 1985 оны 04-р сард “.edu” дээр бүртгэсэн бөгөөд Колумбын Их Сургууль, Карнеги Меллоны Их Сургууль, Пурдуэ Их Сургууль, Райс Их Сургууль, Беркли дахь Калифорнийн Их Сургууль болон Лос Анжелес дахь Калифорнийн Их Сургууль зэрэг Америкийн дээд боловсролын 6 байгууллага бүртгүүлж gTLD авч байжээ. Дараа нь удалгүй АНУ-ын их сургуулиуд болох Массачусетсийн Технологийн Их Сургууль (MIT), Харвардын Их Сургууль, Стэнфордын Их Сургуулиуд бүртгүүлсэн байна. KCG групп 1989 онд АНУ-ын MIT болон бусад их дээд сургууль, судалгааны төвүүдтэй хамтран гадаадад сургууль зуучлах, оюутан солилцох төв болох Бостон дахь оюутны хотхоныг байгуулсан. Эдгээр хүчин чармайлтын үр дүнд KCG групп нь АНУ-ын компьютер хөгжүүлэгчид ба интернетийн эрин үеийн санаачлагч нарт “.edu”-ыг ашиглах эрх бүхий итгэмжлэгдсэн компьютерын сургууль, дээд боловсролын байгууллагаар хүлээн зөвшөөрөгдсөн. Тус групп энэхүү gTLD-г авсан Японы анхны боловсролын байгууллага юм. Сүүлд gTLD “.edu”-ыг зөвхөн АНУ-ын боловсролын байгууллагуудад ашиглах онцгой эрхтэй болгосон билээ. Өнөөдрийг хүртэл KCG Групп нь “.edu”-г хэрэглэж буй Японы цорын ганц боловсролын байгууллага хэвээр байна.
KCG групп “kdg.edu” домэйныг эзэмшиж байгаа нь KCG ба KCGI нь АНУ болон Японд дээд боловсролын байгууллагаар хүлээн зөвшөөрөгдсөнийг баталж байна. Манай “.edu" домэйн нь өнөөдөр бидний үйл ажиллагааны бэлгэ тэмдэг болж байна. “Kcg.edu” бэлгэ тэмдэг нь KCG Группийн боловсролын байгууллагын мөн чанарыг илэрхийлдэг бөгөөд дэвшилтэт мэдээллийн нийгэмд шинийг санаачлах мөн чанарыг ямагт эрхэмлэж, энэхүү эрин үеийн чиг хандлагыг тогтоох чадвартай мэргэжилтнүүдийг бэлтгэх бидний үзэл санааг харуулдаг.

KCG группын өнгө

kcg.edu
The Kyoto College of Graduate Studies for Informatics

KCG улаан
(Киотогийн мэдээлэл технологийн эрмийн зэрэг олгох их сургуулийн өнгө)

KCG группыг үүсгэн байгуулагч Хасэгава Щигэо нь амьдралынхаа сүүлийн жилүүдэд сургуулиа удирдахын хамт Харвардын их сургуульд суралцаж, залуу насандаа биелүүлж чадаагүй эрдэмд дахин шамдсан. Бостонд байр хөлслөн, залуу оюутнуудтай хамт утга зохиол, гүн ухааны хичээлүүдэд сууж байлаа. Зэрэг цол олгох Киотогийн мэдээлэл технологийн эрмийн зэрэг олгох их сургуулийн өнгө болох хүрэн улаан өнгийг үндэс болгон KCG цэнхэртэй жишсэн өнгийн хоршил болгон баталсан. Энэ нь хөгшин залуу, эр эмээс үл хамааран ямагт шинэ зүйлд өөрийгөө сорьж, даруу төвшинөөр суралцах төлөв байдлыг илэрхийлж байгаа юм.

kcg.edu
Kyoto Computer Gakuin

KCG цэнхэр
(KCG сургуулийн өнгө, KCG группын өнгө)

KCG сургуулийн өнгө болон KCG группын өнгө болох цэнхэр зай авах цэнхэрньүүсэн байгуулагдах үеийн бүх гишүүд Киотогийн их сургуулийн аспирантурыг төгсөгчид байснаас үүдэн Киотогийн их сургуулийн өнгө болох хар хөхийг язгуур болгон сонгосон.
1970 оны орчмоос ашиглагдаж эхэлсэн боловч үүсэн байгуулагдсаны 35 жилийн ой (1998он)-ыг тохиолдуулан өнгөний зохицлыг тодорхойлж, KCG цэнхэр хэмээн тогтсон.

kcg.edu
Kyoto Computer Gakuin Automobile School

KCG улбар шар
(Киото автомашины мэргэжилийн сургуулийн өнгө)

Дараахи шинэ үеийн автомашины технологид тохирсон өндөр төвшний IT, сүлжээний технологи, мэдлэг бүрдсэн автомашины механикчийг бий болгоно. Автомашины мэргэжилийн сургууль нь 2013 он, KCG групп нэгдсэн. Сургуулийн өнгө нь KCG групп шинэ эрч хүчийг дуудаж оруулахийг илэрхийлнэ.

kcg.edu
Kyoto Japanese Language Training Center

KCG ногоон
(Киото япон хэл сургалтын төв-сургуулийн өнгө)

KCG группын гадаадаас ирсэн оюутнуудын хувьд эхний үүд хаалга болдог Киото япон хэлний сургалтын төв нь Япон хэлний боловсролыг хөгжүүлэх нийгэмлэгээс хүлээн зөвшөөрөгдсөн япон хэлний сургууль бөгөөд “БШУЯ”-аас бэлтгэл боловсролын судлагдахууны зааврыг авсан. Дэлхийн 7 тивийн ногоон их газрын дүрслэлээс сургуулийн өнгө болгон дээрхи KCG цэнхэр болон KCG улаантай хорших өнгө хослолыг ногооноор тогтсон.

KCGI-ийн онцлог

Нийгэмд хувь нэмэр оруулах практик мэдлэг чадварыг эзэмшсэн байх.

■ Салбарын эрэлт хэрэгцээ болон IT-ийн дэвшилд нийцүүлэн боловсруулсан сургалтын төлөвлөгөө

Тус сургууль нь аж үйлдвэрийн салбараас тавигдах шаардлагад нийцсэн сургалт явуулахын тулд хичээлийн хөтөлбөр болон анги хуваарилалт, заах арга зүйн хөтөлбөрийг тус сургуулийн гадаад дотоодын мэргэжилтнүүдээс зөвлөлгөө авч тогтоодог. Мөн, IT (ICT)-ийн огцом өөрчлөлтөнд нийцүүлэхийн тулд, Америкийн Рочестерийн их сургуультай хамтран ажиллахын зэрэгцээ дэлхийн хамгийн шинэлэг IT-н сургалтын хөтөлбөрийг нэвтрүүлж, хамтарсан судалгаа хийдэг.

■ Практик сургалтын тууштай хөтөлбөр боловсруулдаг

Тус сургуульд IT (ICT) болон менежментийн мэдлэг чадварыг жигд эзэмшсэн боловсон хүчин бэлтгэхийн төлөө IT-с гадна удирдлага, эдийн засаг зэрэг бизнестэй холбоотой бусад хичээлд суралцах нөхцлийг бүрдүүлж өгсөн. Төгсөх жилдээ магистрын диплом хамгаалах ажилтай дүйцэх төсөл боловсруулан хэрэгжүүлж, карьераа ахиулахын төлөө өндөр түвшний мэдлэг чадварыг эзэмшинэ.

■ Цахим сургалт болон танхимын сургалтыг хавсран хэрэглэснээр сургалтын үр дүнтэй хэв маягыг нэвтрүүлэх

Тус сургууль нь Америкийн Колумбын их сургуулийн профессорын багийн халуун дэмжлэгээр, дэлхийд хамгийн өндөр түвшний мэдээллийн технологийн сургалт явуулахыг зорьж байна. Хичээлийн хэлбэрийн хувьд ч уян хатан байхыг чухалчлан, кейс судалгаа, хээрийн судалгаа, хэлэлцүүлэг гэх мэт бодитой бөгөөд олон янзын бүтэцтэй байдаг. Мөн, цахим сургалтын студи байгуулан, цахим сургалт, танхимын сургалтыг хослуулснаар үр дүнтэй сургалт явагдаж байна.

IT (ICT) болон менежментийн талаарх мэдлэгийг тэгш эзэмшинэ.

■ IT болон менежмент гэх мэт олон чиглэлээр үйл ажиллагаа явуулах чадвартай мэргэжилтнүүдийг бэлтгэх

Өнөө үеийн бизнесийн хувьд, вэб технологид тулгуурласан IT (ICT)-н мэдлэг болон менежментийн стратеги зэрэг удирдлагын ур чадварыг давхар эзэмшсэн боловсон хүчин шаардагдах болсон. Тус сургуульд, мэдээлэл, менежментийн чиглэлийн хоёроос дээш мэргэжил эзэмшсэн мэргэжилтэнг бэлтгэж байна.
Сургалтын хөтөлбөр нь оюутан бүрийн төвшинд тохирсон мэдээлэл, менежментийн чиглэлийн хичээлийг тэнцвэртэй заахаар зохион байгуулагдсан байдаг.

■ Корпорацийн болон бусад IT-ийн стратегийн хөгжүүлэлтээр практик туршлага чадвар эзэмшсэн олон тооны багш сурган хүмүүжүүлэгч нарыг ажиллуулах.

Тус сургууль, мэргэжилтэн бэлдэхийн тулд том үйлдвэр, компаний бодит ажлын туршлагатай олон хүмүүсийг багшаар ажиллуулдаг. Багш бүр өөрийн туршлагадаа тулгуурласан лекцээрээ, оюутнуудын бодит чадварыг өсгөн дээшлүүлдэг. Бодит байдалтай шууд холбогдсон хамгийн шинэлэг онол, технологийн ойлголтыг гүнзгийрүүлж, оюутнууд мэргэжилтэний үүднээс цогц мэдлэг эзэмшдэг.

Карьераа өөрчилж, мэдээллийн технологийн салбарт ажиллана.

■ Хүмүүнлэгийн, шинжлэх ухааны гэх мэт төрөл бүрийн чиглэлээр оюутнууд элсүүлэх боломжтой.

KCGI-ийн нэг зорилт нь төрөл бүрийн суурь боловсролтой хүмүүсийг IT-н чадварлаг мэргэжилтнэн болгон бэлтгэх юм. Бид хүмүүнлэгийн болон шинжлэх ухааны гэх мэт төрөл бүрийн салбараас янз бүрийн элсэгчдийг хүлээн авдаг бөгөөд голлох мэргэжлээр заавал төгссөн байх ёстой гэсэн шаардлага тавьдаггүй. KCGI нь оюутнуудын өмнөх мэдлэг, ур чадвар, хэрэгцээ шаардлагад тохирсон сонгон суралцах боломжтой хичээлүүдийг санал болгосноороо төрөл бүрийн суурь боловсролтой оюутнуудыг дэмжин ажилладаг. Насанд хүрэгчдэд ажлынхаа хажуугаар суралцах боломж олгохын тулд KCGI нь олон төрлийн сургалтын сонголтуудыг санал болгодог. Бид Япон дахь эрдмийн зэрэг олгох сургуулиудаас олох боломжгүй ажил мэргэжлийн замналаа өөрчлөх боломжийг бахархалтайгаар бий болгосон.

■ Элсэлтийн үеийн мэдлэгийн төвшинд тохирсон сургалтанд хамрагдах боломжтой

KCGI-д IT-н чиглэлээр суралцаж буй оюутнууд компьютерын ямар ч мэдлэггүй хүмүүнлэгийн чиглэлийн төгсөгчөөс эхлээд IT-ын салбарт SE болон бэлтгэгдэж буй ажилтан хүртэлх янз бүрийн ур чадвартай хүмүүс байдаг. Тус сургуульд, мэдээллийн технологийн мэдлэгтэй эсэх болон ирээдүйн зорилгод нь нийцүүлэн оюутан бүрт хамгийн тохиромжтой сургалтын загварыг санал болгоно. Ингэснээр, урьдчилсан мэдлэггүй оюутан ч гэсэн зорилгодоо үе шаттайгаар саадгүй хүрч чадах болно. Суурь мэдлэгтэй оюутан илүү мэргэшсэн хичээлээс сурч эхлээд, өөрийн мэдлэг чадвараа үр ашигтайгаар ахиулж чадна.

Бид дэлхийн тавцанд идэвхтэй үүрэг роль гүйцэтгэхийг үргэлж эрмэлздэг.

■ Дэлхийн улс орнуудын IT-н салбарыг төлөөлөх хамгийн анхдагч хүний лекцийг сонсох боломжтой

IT-н бизнес бол хил хязгааргүй даяаршин хөгжсөн салбар юм. Тус сургууль нь, оюутнуудад олон улсын төлөвшил эзэмшүүлэхийн тулд, Америк, Азийн бүс нутгуудаас нэр хүндтэй эрдэмтэн, багш нарыг урьж ирүүлдэг. Америкийн Рочестерийн инженерийн их сургууль, Колумбын их сургууль, мэдээллийн нууцлалын салбарт дэлхийд тэргүүлдэг Солонгосын Кооайн их сургуулийн мэдээлэл хамгаалах сургууль зэрэг дэлхийн улс орнуудын их сургууль, компаниудтай эрдэм шинжилгээ судалгааны хамтын ажиллагаа, ажил хэргийн харилцан туслалцаатай ажиллаж, хамтарсан судалгаа болон олон улсын хурал зөвлөлгөөнүүд зохион байгуулах зэргээр глобалчилсан харилцааны дэвшилд анхаарлаа хандуулж байна.

Бид бүх хичээлүүдийг Англи хэлээр явуулах замаар оюутнуудыг дэлхийн хэмжээний тоглогч болгон бэлтгэдэг.

KCGI нь олон хичээлүүдийг Англи хэлээр санал болгодог бөгөөд оюутнуудад зөвхөн Англи хэл дээр хичээлээ үзэж, Магистрын зэрэг горилох боломжийг олгодог. Эдгээр хичээлүүдийг нэр хүндтэй гадаад профессорууд заадаг. KCGI-н бакалавр болон докторын сургалтанд дэлхийн 17 гаруй улс орон, бүс нутгаас оюутнууд ирж элсэн суралцдаг бөгөөд ихэнх хичээлүүд нь англи хэл дээр явагддаг. Япон оюутнууд шаардагдах Англи хэлний ур чадварын шаардлагыг хангасан тохиолдолд Англи хэлээр суралцах боломжтой. Оюутнууд энэхүү олон улсын түвшний орчны давуу талыг ашиглан Англи хэлээ сайжруулаад зогсохгүй IT-д суралцахаас гадна олон улсын сэтгэлгээнээс суралцах боломжтой юм.

Premathilaka Shashikala Nimanthi (S)
Student enrolled in KCGI in April 2018, Graduate of Rajarata University

Koichi Hasegawa (H)
Professor of KCGI

Student Interview

Professor Hasegawa (H): Hi, how are you?
Premathilaka Shashikala Nimanthi (S): I'm very fine, thank you.
H : OK, let's talk about your life at KCGI. First, please relax (ha-ha).
S : Thank you.
H : How is your life in Japan?
S : Before I came to Japan, I really admired Japanese culture and life. I especially liked the self-discipline and self-control of Japanese people. The only difficult thing is Japanese language.
H : I see. How did you learn about our graduate school?
S : I wanted to do my Master's degree outside of Sri Lanka. So, I searched many universities. At that time, a Sri Lanka agency introduced me to KCGI. I learned that KCGI has Master courses that can be taken in English and Japanese. Then, I searched the KCGI's online website, where I found details about the school, courses and especially about job focus areas. I was really happy because I could come to Japan.
H : So, you are interested in Information Technology....
S : Yes, my undergraduate degree was in Information and Communication.
H : How are your studies going so far?
S : I am really enjoying my studies here. I have learned so much interesting and useful things across many IT fields. And the KCGI professors are teaching me a lot. They have much knowledge and experience to share. I have learned a lot of things from them, and also have done self-study using the class materials. It's been a really good experience.
H : What is your concentration?
S : My concentration is ERP.
H : Do you have any favorite courses?
S : Yes, I enjoy all courses especially, "International Accounting" and "Computer Organization Theory".
H : In the future, do you want to take a job related to ERP?
S : Yes, after I graduate, I want to start my career as an ERP consultant. Before I came to Japan, I worked as a project manager. While I am here, I wish to pursue a job as an ERP consultant.
H : Are you planning to take the test for ERP qualification?
S : Yes, my professor always recommends me to take extra examinations. I will register for the SAP ERP examinations soon.
H : After you graduate from KCGI, do you want to stay in Japan and find a job?
S : Yes, I would prefer to find a job here in Japan. I want to work in a company which has branches all over the world so I can get more work experience in different environments. One day I would like to return to Sri Lanka and give back to my country. That is my target. I have been given so many things from my country so I feel it is my responsibility to give back my knowledge.
H : I see. Thank you for your time and cooperation.

Сурсан зүйлээ ашиглан нийгэмд ажиллаж чадна.

■ Ганцаарчилсан сургалтанд хамрагдсанаар мөрөөдсөн ажилдаа орох боломжтой

KCGI нь бүх оюутнуудаа төгссөнийхаа дараа ажилд орох боломж олгохыг эрмэлздэг. Хариуцсан багш нар нь тус салбарын болон бусад салбар дахь туршлага, хувийн сүлжээгээрээ дамжуулан оюутнуудаа ажилд зуучилдаг. Багш нар нь а ганцаарчлан зөвшилцсөнөөр мөрөөдлийн ажилдаа ороход нь туслахыг хичээн ажилладаг.
Мөн, шинээр бизнес эрхлэхийг хүссэн оюутанд компани байгуулах, удирдлага менежменттэй холбоотой ноухауг зааж өгөх зэргээр төрөл бүрийн дэмжлэг үзүүлнэ.

■ Төгсөгчдийн дунд бизнесийн сүлжээ бий болгох

Тус сургуульд, IT-д тэргүүлэх олон төгсөгчид мөр зэрэгцэн ажиллаж байгаа бөгөөд, төгсөгч хоорондын бизнесийн холбоо буй болгоход ч анхаарлаа хандуулдаг. Суралцах явцад нь багаар ажиллах олон боломж гаргаж өгснөөр, төгссөнийхөө дараа нийгэмд гарсан хойноо ч нэг ангийнхан өөр өөрийнхөө ур чадвараа ашиглан харилцан бие биенээ дэмжин б үсэг илүү болгохыг зорьж байна.

Сургалтын орчин

Дэлхийн стандартад нийцсэн боловсролын системийг нэвтрүүлсэн, дадлагажих боломж бүхий сургалтын орчинтой

SAP Сургалтын систем

■ SAP компанийн ERP системийг нэвтрүүлсэнээр мэргэжлийн чадварлаг боловсон хүчин бэлтгэх боломжийг бүрдүүлэв

Ихэнх их дээд сургуулиудын мэдээллийн технологийн боловсролын тогтолцоог бизнесийн үйл ажиллагаанд хэрхэн ашиглах талаарх мэдлэг дутмаг байсан. Ялангуяа төрөлжсөн үйл ажиллагаа явуулдаг компанид орж ажиллахын тулд мэдээллийн технологийн боловсролыг хэрхэн олгох, тэр орчин нь хараахан бүрдээгүй байгаа юм.
Тус сургуульд мэдээллийн технологийн салбарын өндөр түвшний мэргэжлийн боловсон хүчин бэлтгэх зорилгоор Дэлхийн хамгийн том ERP системийг нийлүүлдэг Герман улсын SAP компанийн системийг нэвтрүүлснээр дадлагажих сургалт болон судалгааны орчинг бүрдүүлээд байна. Энэхүү аж ахуйн нэгжийн нөөцийн төлөвлөлт (ERP)-ийн системийг 437,000 компаниуд нэмэлт програм хангамж (2020 оны 3-р сарын байдлаар SAP хэлбэрийн) нэвтрүүлснээр ашиглаж байна. Том компаниудын дундаас Форбс Глобал 2000-д багтсан компаниудын 92% нь SAP ERP ашигладаг.
Энэхүү систем нь үндсэндээ мэдээллийн технологийн удирдлагын боловсрол олгоход ашиглагдаж ирсэн ба харин тус сургууль гагцхүү системийн боловсруулалт болон ERP чиглэлийн мэргэжилтэн бэлтгэх сургалтанд ашиглаж байгаа нь Япон улсдаа ховор тохиолдол бөгөөд мэдээллийн технологийн чиглэлээр боловсрол олгож буй манай их сургуулийн нэг онцлог давуу тал юм.

Цахим сургалтын систем

KCGI нь Киотогийн төв сургуулийг хиймэл дагуулын хотхон болон бусад сургуулиудтай холбохын тулд дараагийн үеийн цахим сургалтын системийг ашигладаг бөгөөд ингэснээр лекцийг яг цагт нь явуулах, оюутнуудад алсын зайнаас суралцах таатай боломжийг бүрдүүлж өгсөн.

Орчин үеийн цахим сургалтын системээр дамжуулан Саппоро, Токио, Киото хотуудыг шууд холбон нэгэн зэрэг сургалт явуулж байна (Ижил хугацааны цахим сургалт). Бид мөн KING-LMS-д нэгтгэсэн сургалтын агуулгаар хэзээ ч, хаанаас ч онлайнаар судалгаа шинжилгээ хийх боломжийг бүрдүүлсэн. Эдгээр шинэчлэлийн тусламжтайгаар KCGI нь онлайнаар (асинхрон цахим сургалт) суралцах боломжтой олон сургалтыг санал болгон ажиллаж байна.

※KING-LMS (KCG Information Network Galaxy-Learning Management System) өөрийн дуртай цагтаа онлайнаар дамжуулан суралцах боломж бүхий цахим сургалтын систем.

■ Ажил эрхэлдэг завгүй хүмүүс суралцах боломж бүрдүүлэх

Сүүлийн жилүүдэд өөрийн ур чадвар, ажлын карьераа өсгөх зорилгоор ажлын хажуугаар их дээд сургуульд суралцах хандлага ихэсч байна. KCGI нь ажиллангаа суралцах хүсэлтэй хүмүүст IT-н чадварлаг мэргэжилтэн болох боломжийг бүрдүүлсэн.



Идэвхи зүтгэлийн талбар

Одоо, аж үйлдвэрийн салбарт мэдээллийн технологи (ICT)-н өндөр түвшинд, (ялангуяа вэб бизнесийн технологийн хэрэглээ) өмнөх үеийн “мэдээллийн технологийн өөрчлөлт” -тэй харьцуулбал, өндөр түвшний мэдээллийн технологийг нэвтрүүлэх асуудал яригдсаар байна. Өөрөөр хэлбэл, мэдээллийн технологи (ICT)-г зөвхөн ажлын явцыг сайжруулахын төлөө бус, орчин үеийн аж ахуйн нэгжийн стратеги боловсруулалтад ашиглах хандлага ихэсч байна.
Энэ нь удирдлагын өндөр түвшинд мэдээллийн технологи хэрэгтэй болж байгаагийн илрэл бөгөөд үүнтэй холбогдуулан өндөр мэргэжлийн мэдлэг, ур чадвартай боловсон хүчинтай байх шаардлага тавигдаж байна.
Тус сургууль нь дэлхийд хүлээн зөвшөөрөгдсөн мэдээллийн технологийн боловсон хүчинг бэлтгэх хөтөлбөрийг нэвтрүүлэн ажиллаж байна. Манай сургуулийг төгссөнөөр дараах ажлын байранд ажиллах чадварыг эзэмших юм.

CIO (Chief Information Officer: Мэдээллийн асуудал хариуцсан дэд захирал)

Аливаа компанийн мэдээллийн технологийн хэрэглээ нэвтэрч, удирдлагын түвшинд мэдээллийн технологийг өргөнөөр ашиглах болсноор, мэдээллийн технологийн стратеги бодлого боловсруулах удирдах түвшний албан тушаал зайлшгүй шаардлагатай болж байна. CIO нь тухайн байгууллагын дээд түвшний стратеги шийдвэр гаргах явцад оролцож, тухайн бодлогыг хэрэгжүүлэх боломжийг бүрдүүлэхэд шаардлагатай мэдээллийн бодлого боловсруулж, компанийн эзэмшиж буй төрөл бүрийн мэдлэг мэдээллийг хамгийн ур ашигтай ашиглах мэдээллийн системийг боловсруулан хэрэгжүүлэх өндөр ур чадвар шаардсан чухал албан тушаал юм.

Төслийн менежер

Төслийн менежер нь мэдээллийн технологийг нэвтрүүлэх төслийг удирдах ажлыг хариуцах тул хариуцлагатай ажил юм. Төслийн менежер нь компанийн нөөц бололцоог хамгийн үр өгөөжтэй ашиглахад анхаарч, өрөнхий удирдлага болон бүтээмжийг дээшлүүлэх, сүүлийн үеийн техник технологийг нэвтрүүлэх чадвар бүхий өндөр түвшний мэргэжлийн боловсон хүчин юм. Тийм учраас удирдлагын болон мэдээллийн технологийн өргөн хүрээний мэдлэгтэй байх шаардлагатай. Түүнчлэн, өөр өөр алба хэлтсийн харьяаллын хүмүүстэй төсөл дээр ажиллах тул харилцааны өндөр ур чавдарыг эзэмшсэн байх шаардлагатай.

Өндөр түвшний SE (ахлах инженер), вэб систем хөгжүүлэлтийн инженер

Өндөр түвшний ахлах инженер нь төслийн менежерт дэмжлэг үзүүлж, төслийн удирдлагад оролцдог инженер юм. Зөвхөн техникийн асуудлаас гадна зардал болон үйл ажиллагаа зэрэг удирдлагын хэрэгслийн талаар зохих мэдлэгтэй байх шаардлагатай. Вэб систем хөгжүүлэлтийн инженер нь төслийн менежер болон ахлах инженерийн зааврын дагуу сүүлийн үеийн мэдээллийн технологийн мэдлэгийн хүрээнд систем хөгжүүлэлтийн ажлыг хариуцан гүйцэтгэнэ.

Системийн ерөнхий зөвлөх

Японы компаниудын хувьд, мэдээллийн технологийн ажилтны хүрэлцээ бага тул гадны зөвлөх авч ажиллуулах эрэлт ихсэж байна. Системийн ерөнхий зөвлөх нь үйлчлүүлэгч байгууллагын стратеги бодлогод нийцүүлэн бизнесийг нь системжүүлэх талаар зөвлөх үйлчилгээ үзүүлдэг бөгөөд өнөөгийн ширүүсч байгаа олон улсын зах зээл дэх өрсөлдөөнд ялах, байгууллага хоорондын бүтээмжийг дээшлүүлэх чадвар бүхий нарийн мэргэжлийн боловсон хүчин юм. Байнгын үйлчлүүлэгчдийнхээ хэрэгцээг ойлгож, түүнд тохирох шийдлийг боловсруулах зэрэг удирдлага, харилцааны өндөр чадвар хэрэгтэй байдаг.

Вэб маркетингийн мэргэжилтэн

Цахим худалдааны сайт боловсруулах чадвар бүхий интернэтийн орчинд аливаа үйлчилгээ үзүүлэх ажлыг зохион байгуулах, хэрэглэгчдийн онлайн төлөв байдлыг судлан түүнд тохирсон маркетингийн үйл ажиллагааг удирдан явуулах, цахим бизнесийн үйл ажиллагаа эрхлэх чадвар бүхий мэргэжлийн боловсон хүчин юм. Бараа үйлчилгээний худалдааны талаар нарийн мэдлэг эзэмшсэн, түүний логистик болон аюулгүй байдал сүлжээний талаарх өргөн мэдлэг, ур чадвартай байх шаардлагатай.

Системийн архитектур

Системийн архитектур нь компаний мэдээллийн технологийн талаар баримтлах бодлогыг судалж, түүний шийдэл арга замыг боловсруулах, нарийн төвөгтэй олон төрлийн системийн хоорондын уялдаа холбоо хамаарлыг боловсруулах, зохион байгуулах ур чадвар бүхий нарийн мэргэжлийн боловсон хүчин юм. Компаний бодлого болон боловсруулагдаж байгаа системийг холбох үүрэг гүйцэтгэнэ. Тийм учраас техникийн мэдлэгээс гадна, бизнесийн үйл ажиллагаа, менежментийн талаарх өргөн мэдлэгтэй байх шаардлагатай.

Мэдээллийн аюулгүй байдлын зөвлөгөө

Мэдээллийн сүлжээ нь, өбизнес болон IoT (Internet of Things) зэргийг бодит болгоход зайлшгүй шаардлагатай дэд бүтэц болсон байна. Нөгөө талаар, эдгээр сүлжээг хамарсан аюулгүй байдлын эрсдэл нэмэгдсээр байна. Мэдээллийн аюулгүй байдлын талаарх зөвлөгөөг хэрэглэгчдэд өгч, мэдээллийн өмчийг хамгаалах дэмжлэг үзүүлнэ. Мөн, хэрэглэгчийн нөхцөл байдлыг ойлгож, түүнд тохирсон үйлчилгээ үзүүлэхийн тулд, удирдах болон харилцааны ур чадвартай байх шаардлагатай.

Контент бүтээлийн хянагч

Кино болон анимэшн, тоглоомын софт зэрэг медиа контентын бүтээлийн хувьд, контент бүтээлийн хянагч нь, төслийн багийн нийт хяналтыг хийнэ. Эхлээд төслийн загварыг боловсруулж, хамтарч бүтээх компанитай ярилцаж, дэлгэрэнгүй төсвийг баталгаажуулна. Мөн, бүтээлийг хэрхэн хэрэглэж хөрөнгө оруулалтаа нөхөхийг төлөвлөж, гүйцэтгэнэ. Өнгөрсөн ажлын дүн болон одооны зах зээлийн байдлыг дүгнэх чадвар болон, баг нэгтгэн төлөвлөгөөг гүйцэтгэх тэргүүлэх чадвар шаардагдана.

Мэдээллийн шинжээч

Мэдээллийн шинжээч нь бизнесийн үйл ажиллагааны явцад үйлчлүүлэгч болон бүтээгдэхүүний талаар олон тооны мэдээллийг цуглуулж, уг мэдээллийн шинж чанар болон хандлагыг тогтоохын тулд тодорхой зорилтот дүн шинжилгээ хийдэг. Дараа нь менежментийн болон системийн хөгжүүлэлтийн асуудалд чиглэсэн олон шийдлүүдийг боловсруулж санал болгодог. “Big Data”-г хөдөө аж ахуй, анагаах ухаан зэрэг салбарт ашиглах нь сүүлийн жилүүдэд өргөжин тэлж байгаа бөгөөд үүнийг хэрэглэх салбаруудын хүрээ хүрээ улам бүр өргөжиж байна. Мэдээллийн шинжилгээ хийхэд маркетинг, менежментийн мэдлэгээс гадна статистик дүн шинжилгээ, өгөгдөл олборлох, таамаглалыг туршиж баталгаажуулах логик сэтгэлгээ гэх мэт IT-н ур чадвар шаардагддаг.

Боловсролын зорилтууд

Суралцагчдад боловсрол олгох сургуулийн эрхэм зорилго, зорилтоо хэрэгжүүлэхийн тулд бид вэб бизнес технологийн мэргэжлийг дараах зорилт болгон тогтоолоо.

1) Суурь боловсрол эзэмших

Оюутнууд бизнесийн суурь мэдлэг, нийгмийн болон харилцааны чадварт суралцсан байх ёстой. Мөн IT/ICT-г хангах програм хангамж, техник хангамж гэх мэт мэдээллийн суурь технологийг ойлгох чадвар эзэмшинэ.

2) Төлөвлөлт, загварыг бүтээх чадварыг сайжруулах

Оюутнууд 1) бизнесийн болон IT/ICT-н одоогийн болон цаашдын чиг хандлагыг өргөн хүрээнд судлаж, дүгнэх 2) аж ахуй нэгжийн болон нийгмийн сорилтуудыг даван гарах логик аргачлалыг төлөвлөж, санал болгох чадвараа хөгжүүлнэ. Түүнчлэн оюутнууд санал болгож буй төлөвлөгөөгөө сайжруулахуйц төрөл бүрийн систем болон контентуудын загвар бүтээх чадвар эзэмшинэ.

3) Зохион бүтээх, ажиллуулах ур чадварыг сайжруулах

Оюутнууд програм хангамжийг хэрэгжүүлэх явцдаа төлөвлөж боловсруулсан систем, контентуудыг бие даан ашиглах, эцсийн хэрэглэгчдэд санал болгох чадвараа хөгжүүлнэ. Ингэхдээ эдгээр систем, контентуудыг зохион бүтээх болон ажиллуулахад шаардагдах төрөл бүрийн арга хэрэгсэл болон кодчлох дүрмийн талаарх практик ур чадвараа гүнзгийрүүлэх.

4) Мэргэжлийн ухамсар, ёс зүйг төлөвшүүлэх

Бизнесийн үйл явцыг хариуцлагатайгаар удирдан зохион байгуулах чадварыг төлөвшүүлнэ. Бизнесийн үйл ажиллагааг тасралтгүй сайжруулахын тулд мэргэжлийн өндөр ухамсар, ёс зүйг төлөвшүүлсэн байх шаардлагатай. Эдгээр хоёр зүйлийг нэгтгэснээр оюутнууд байгууллага удирдах практик манлайлах ур чадвар, арга барилд суралцана.

Хөтөлбөрийн дүрэм

Бид өөрсдийн эрхэм зорилго, зорилтын хүрээнд IT/ICT-н менежментийн ур чадвар хавсруулан эзэмшсэн, сонгосон мэдээлэл технологийн бизнесийн салбараа ур дүнтэйгээр хөгжүүлж чадахуйц өндөр түвшинд мэргэшсэн мэргэжилтнүүдийг бэлтгэх сургалтын хөтөлбөрийг санал болгож байна.

1. Сургалтын хөтөлбөрийг дараах байдлаар ангилна.

• Мэргэшүүлэх хичээлийн бүлэг - сургалтын тодорхой чиглэлүүдийн талаарх мэдлэгийг гүнзгийрүүлэх зорилгоор системтэйгээр бүлэг болгон хуваасан хичээлүүд.
• Салбарын хичээлийн бүлэг - Бизнесийн болон мэдээлэл технологийн мэргэжилтнүүдтэй хамтран кейс судалгаа, төслийн судалгаа зэргийг ашиглан тодорхой салбарын технологи, ур чадварыг практик дээр ашиглахад чиглэсэн хичээлүүд.
• Дагалдан сонгох хичээлийн бүлэг –Технологийн чиг хандлага, өндөр түвшний онолын сургалт, төвлөрсөн болон үйлдвэрийн салбарын хичээлийн мэдлэгийг бататгах ур чадварын сургалтыг хамарсан хичээлүүд.

2. Сургалтын загвар, аргачлалыг бий болгох

Оюутнуудын суралцах зорилго болон сонирхолд нийцүүлэн суурь мэдлэгээс эхлээд IT-тай холбоотой тодорхой салбарын мэдлэг туршлага хүртэлх өргөн хүрээний мэдлэг чадвар олгох багц хичээл буюу нэг "мэргэшүүлэх" хичээл сонгон суралцах боломжтой. Мөн түүнчлэн захиалгат сургалтын хөтөлбөр нь оюутнуудад өөрийн янз бүрийн хэрэгцээ шаардлага болон сургалт судалгааны хувийн зорилгодоо тохирсон хичээл сонгон суралцах боломжийг олгодог.
Сургалтыг мэргэжлийн практик хэрэглээ хүртэл өргөжүүлэхийн тулд энэхүү сургалтын хөтөлбөр нь төрөл бүрийн аж үйлдвэрийн салбарт технологийг практикт ашиглах ур чадвар олгодог дадлагажих хичээлүүдийг мөн санал болгодог. Дадлагажих хичээлүүд нь оюутнуудын мэргэшүүлэх хичээлээр олж авсан ур чадварыг бататгах зорилготой юм.

3. Магистрын төсөл

Манай сургалтын хөтөлбөр нь курсын ажлаас гадна магистрын төслийн ажлыг Факультетын удирдамжийн дагуу өөрийн сонирхлын хүрээнд гүйцэтгэснээр ур чадвараа практикт хэрэглэх чадварыг төлөвшүүлдэг.

4. Өөрчлөлтөнд хариу арга хэмжээ авах

Манай сургалтын хөтөлбөр нь IT/ICT-н салбарын хурдацтай өөрчлөлтөд хурдан хариу арга хэмжээ авдаг. Манай сургууль Япон болон гадаад дахь өндөр ур чадвартай мэргэжилтнүүдэд зайлшгүй шаардлагатай болсон салбарын болон нийгмийн өөрчлөлтийн дагуу сургалтын хөтөлбөрөө байнга шинэчлэн сайжруулдаг.

Диплом олгох дүрэм

Манай сургууль нь дараах шаардлагыг хангасан хүмүүст магистрын зэрэг олгодог.

1) Урьдчилан тогтоосон хичээлийн хуваарийг заасан хугацаанд (тухайлбал 4 семестрт) бүрэн дуусгасан бол.
2) Урьдчилан тогтоосон төгсөлтийн кредитийн шаардлагыг бүрэн биелүүлсэн бол.

Манай сургууль оюутнуудад дараах хандлагыг эзэмшүүлэхийг зорьдог.

a. Өөрийн мэргэжилдээ хувь нэмрээ оруулахын тулд суур мэдлэг эзэмшиж тогтмол сайжруулах.
b. Өндөр ур чадвартай мэргэжилтэн болохын тулд энэхүү мэдлэгээ сонгосон салбартаа хэрэглэх чадвартай байх.
Мэргэжлээрээ хүндэтгэл хүлээсэн нэгэн болохын тулд өндөр ёс зүйтэй биеэ авч явах.

"Хэрэглээний мэдээллийн технологийн мэргэжилтэн" бэлтгэн гаргахад зориулсан нэгдсэн сургалтын хөтөлбөр

KCGI-ын сургуулийн үзэл баримтлалын нэг зорилт нь өндөр түвшний мэргэшсэн мэдээлэл технологийн мэргэжилтнүүдийг бэлтгэж төгсөх юм. Энэхүү зорилтоо биелүүлэхийн тулд KCGI нь оюутнуудын төрөл бүрийн боловсролын зорилтыг оюутнуудын санаачилсан төсөл болон үйл ажиллагаанд нийцүүлэхийн тулд төрөл бүрийн хэлбэрээр хичээлд бүртгүүлэх нэгдсэн сургалтын хөтөлбөр боловсруулсан.

■ Мэргэжлийн ур чадварыг эзэмших

Өндөр түвшинд мэргэшсэн мэдээлэл технологийн мэргэжилтний хувиар IT-тай холбоотой бүх мэдлэг ур чадварыг эзэмшинэ гэвэл бодит байдалд нийцэхгүй. Оюутнуудад мэргэших боломжийг бүрдүүлэхийн тулд KCGI нь тодорхой чиглэлүүдийг тодорхойлж, түүнд тохирсон сургалтын хөтөлбөр боловсруулдаг. Эдгээр мэргэжүүлэх чиглэлүүд нь оюутнуудад сонгосон чиглэлийнхээ дагуу суурь мэдлэгээс эхлээд хэрэглээний технологи, практик ур чадвар хүртэлх өргөн хүний гүн гүнзгий мэдлэг олж авах боломжийг олгодог.

■ Нийгмийн хэрэгцээнд хариулах

Орчин үеийн аж үйлдвэрийн хөгжилд нийцүүлэхийн тулд ур дүнтэй байдлыг нэмэгдүүлэх, мэдлэг чадвар эзэмших болон бусад байдлаар асуудал шийдвэрлэхэд IT-г хэрэглэх хэрэгцээ шаардлага улам өсөн нэмэгдэж байна. KCGI нь оюутнуудад дадлагажих салбар сонгож, кейс судалгаа хийх, асуудал шийдвэрлэхэд суралцах замаар тухайн салбартаа IT-р дадлагажих боломж бүрдүүлэхийн тулд дадлагажих сургалт зохион байгуулснаар эдгээр хэрэгцээ шаардлагыг ханган ажиллаж байна.

■ Бүтээлч, хэрэглээний чадварыг илрүүлэх

Өндөр түвшинд мэргэшсэн мэдээлэл технологийн мэргэжилтэн нь хичээлээр эзэмшсэн мэдлэг чадвараа практикт болон бодитоор асуудал шийдвэрлэхэд хэрэглэх чадвартай байх ёстой. Мөн өөрсдийн санаачлагаар авч хэрэгжүүлэх цуврал арга хэмжээг төлөвлөж, эдгээр шийдлүүдийн үр ашгийг бусдад хүртээх чадвартай байх ёстой. Шаардлагатай мэдлэг чадвараа эзэмшихийн тулд оюутнууд төслийн удирдагчийн удирдлаган дор Бие даан сургалт/Судалгааны ажлуудыг хийхээс гадна төрөл бүрийн сэдвүүдийг хамарсан Магистрын төслийн сургалтын хөтөлбөрийг хэрэгжүүлдэг.

■ Мэргэжилийн бодол

Өндөр түвшинд мэргэшсэн мэдээлэл технологийн мэргэжилтнүүд асуудлыг бодитоор шийдвэрлэх, аж үйлдвэрийн бодит салбарт практик шийдэл санал болгох чадвар бүхий өндөр түвшинд бэлтгэгдсэн мэргэжилтний хувиар өөрийн үүрэг хариуцлагыг биелүүлэх ёстой. Түүний тулд, компани болон бүлэг тус бүр internship-г дэмжин ажиллаж, ажилтанд шаардагдах технологийн чадвар, асуудал шийдэх ур чадварыг дадлагажиж сурах орчинг бүрдүүлнэ.

Эдгээр сургалтын загвар, төсөлд оролцохыг бүх оюутанд тулгахгүй. Оюутан бүрийн сонирхол, сурах төвшинд тохируулан, янз бүрээр хослуулан сонгох боломжтой. KCGI нь өндөр түвшинд мэргэшсэн мэдээлэл технологийн мэргэжилтнүүдийн эзэмшсэн байх ёстой мэдлэг чадвар, арга техникийг нээн илрүүлэх боломжийг бүрдүүлсний зэрэгцээ өөрийн сонгосон чиглэлээр суралцах эрх чөлөөг оюутнуудад олгосон сургалтын хөтөлбөр хэрэгжүүлдэг.

KCG дахь Сургалтын хөтөлбөрийн бүтэц

KCGI нь оюутнуудад ICT-н салбарт зайлшгүй шаардлагатай үндсэн арга техник болон мэдлэг чадварыг тусгасан сургалтын хөтөлбөр санал болгодог. Заавал суралцах хичээлд бизнес эрхлэгчдэд шаардлагатай анхан шатны мэдлэг чадвар олгох, мэргэжлийн салбарт практик дээр мэдлэг чадвараа ашиглах чадамж эзэмшүүлэх хичээлүүд багтдаг. Мэргэшүүлэх хичээл нь тухайн мэргэжлийн салбарын талаарх янз бүрийн ойлголтоос бүрдсэн хичээл юм. Дадлагажих хичээл нь эрэлт ихтэй байгаа томоохон салбаруудтай холбоотой хичээлүүдээс бүрдэнэ.

ICT нь хурдацтай хөгжиж байгаа тул оюутнууд заримдаа сургалтын хөтөлбөрөө уламжлалт бус аргаар зохиож, судлах шаардлагатай болдог. Энэхүү хэрэгцээ шаардлагаа хангахын тулд оюутнууд багш нартайгаа зөвлөлдсөний үндсэн дээр өөрийн хувийн боловсролын зорилтод нийцсэн албан бус хичээлүүдээс сонгон сургалтын хөтөлбөр зохиох боломжтой. Ийм сургалтын хөтөлбөрийг IT-ын ерөнхий сургалтын загвар гэж нэрлэдэг.

Элсэлт

Заавал суралцах хичээл

- ICT бодит харилцаа
- Удирдлагын онол
- Төслийан үндэслэл

Мэргэшүүлэх хичээлүүд

- ERP
- Бизнес дата анализ
- Global entrepreneurship
- Вэб систем бүтээх
- Сүлжээ хянах
- IT манга, анимэ
- IT-ийн аялал жуулчлал
- Хиймэл оюун ухаан (AI)

Дээр дурдсан мэргэшүүлэх хичээлүүдээс нэгийг сонгоно.

эсвэл

Үйлдвэрийн салбарын хичээл

- Fintech
- Хөдөө аж ахуй
- Далай
- Эмчилгээ, эрүүл мэнд
- Контент маркетинг
- Боловсрол

Дагалдах сонгон судлах хичээл

Захиалгат сургалт

Өөрийн хувийн боловсролын зорилтондоо тохирсон албан бус хичээлүүдээс сонгон өөрийн сургалтын хөтөлбөрийг зохионо.

Магистрын төсөл

Мэдээллийн технологийн магистр (мэргэжлийн зэрэг)-г дүүргэнэ

Заавал суралцах хичээл

Тус сургуульд, төгссөн мэргэжлээс хамааралгүй, янз бүрийн суурь мэдлэгтэй оюутнуудыг элсэн оруулж байгаа. Ингэснээр, олон хүнд карьерээ өөрчлөх боломжыг олгох нийгмийн үүргийг гүйцэтгэж байна. Иймээс KCGI-ийн заавал судлах хичээлүүд нь оюутан бүрийн мэргэшсэн салбараас үл хамааран өндөр түвшний мэргэжилтний эзэмших ёстой харилцааны үр дүнтэй, оновчтой суурь ур чадвар олгох сургалт юм.

Заавал сурах
- ICT бодит харилцаа
- Удирдлагын онол
- Төслийан үндэслэл

Бие даасан сургалт/Судалгааны ажлууд

“Бие даасан сургалт/Судалгааны ажлууд” нь, тус сургуулийн сургалтын хичээлийн хүрээнд ороогүй бөгөөд бие даасан судалгааг багшийн зааврын доор хийх систем юм. Оюутнууд судалгааны тайлангаа нэгтгэн гаргаж, амаар тайлагнана. Хэрэв тайлангаа хамгаалж чадвал оюутнуудад кредит олгоно. Мастерийн ангийн зарим төслийг бие даан суралцах эсвэл судалгааны ажил хийх зэрэг хөтөлбөрүүдтэй хослуулах боломжтой.

Сурах хичээлээ сонгох

Сургалт зохицуулагчтай зөвлөлдсөний үндсэн дээр оюутнууд тухайн улиралд үзэх мэргэшүүлэх, дадлагажих болон дагалдах сонгон суралцах хичээлүүдийг сонгож, өөрийн хувийны сургалтын төлөвлөгөөгөө боловсруулна.
Эдгээр хичээлийг суурь мэдлэг шаарддагагүй ерөнхий хичээл ба тодорхой түвшний суурь мэдлэг шаардаг мэргэжлийн хичээл гэж ангилдаг. Эрдэм шинжилгээний өндөр үр дүнд хүрэх боломжийг оюутнуудад бүрдүүлж өгөхийн тулд сургалтын аргачлал (санал болгож буй сургалтын хэлбэр)-ийг тодорхой зааж өгдөг. Үүнээс гадна оюутнуудын нэг улиралд үзэж дуусгах хичээлийн тоонд хязгаар тавьдаг. Ингэснээр оюутнууд бие даан суралцахад хангалттай цаг хугацаа олгохуйц сургалтын төлөвлөгөө боловсруулах боломжтой.

Internship

Тус сургуульд, сургалттай холбоотой компани болон байгууллагат тодорхой хугацаагаар ажиллаж үзэх “internship” систем байдаг. Оюутнууд сурч мэдсэн зүйлээ практикт хэрэглэх чадвартай байхын тулд KCGI-аас олж авсан мэргэжлийн мэдлэг боловсрол болон харилцааны ур чадвараа бодит байдал дээр ажлын орчинд ашиглах чадвар эзэмших ёстой. Дадлага хийсний дараа оюутнууд дадлагын тайлан бичиж, амаар хамгаалах ба кредит авна.

Магистрын төсөл

KCGI-ийн ихэнх багш нар Киотогийн их сургууль болон Японы бусад нэр хүндтэй их дээд сургуулийн оюутнуудад зөвлөгөө өгөх арвин туршлагатай бөгөөд дэлхийн хэмжээнд бизнесийн тэргүүн шугаманд ажилласаар ирсэн билээ. KCGI-ийн оюутнууд эдгээр багш нараас Магистрын төслийн ажлын удирдамжийг шууд авах боломжтой.

Товчлол

KCGI -ийн Мастерийн төсөл нь оюутнуудыг өөрсдийн ухамсар дээр үндэслэн аливаа асуудлыг тодорхойлох, дүн шинжилгээ хийх, шийдвэрлэхэд туслах зорилготой мэдээллийн технологийн чиглэлээр хэрэглэгддэг практик хэрэглээ болон технологид чиглэсэн сургалтуудтай.
Бусад уламжлалт их сургуулиудын магистрын зэрэг олгох сургалтууд болон судалгааны ажлуудтай харьцуулахад KCGI нь судалгаанд онцгой анхаарал хандуулдаг бөгөөд оюутнуудад одоо байгаа багаж хэрэгсэл, хамтын ажиллагаа зэргийг ашиглан нийгэм болоод хувь хүмүүсийн амьдралыг сайжруулах боломжийг бий болгох зорилготой юм.

Зорилго

KCGI -ийн мастерийн төсөл нь оюутнуудын бакалаврын зэрэгт суралцаж байх хугацаандаа олж авсан салбар, үйлдвэрлэлийн чиглэлээрх мэргэшсэн мэдлэг дээр үндэслэн тодорхой хэрэгслүүд болох платформ, програм хангамж, үйлчилгээ, хамтын ажиллагаа, бизнесийн загвар зэрэг дээр анхаарч, асуудлуудад дүн шинжилгээ хийж, шийдвэрлэх арга замыг хөтөлбөртөө багтаасан байдаг.

Явагдах арга

Магистрийн төсөл нь төслийн ивээн тэтгэгч (Мастерийн төсөл хариуцагч багш)-н удирдамжийн дагуу оюутнууд өөрсдийн санаачлагаар явагдана. Семестрийн үе шат бүрт дараах алхамууд явагдана. KCGI нь боловсролын чиглэлээр дэлхийд тэргүүлэгч Колумбийн их сургуулийн арга барил дээр суурилан хөтөлбөрүүдээ боловсруулж үйл ажиллагаагаа явуулдаг. Суралцах хугацаа, хөтөлбөр зэргээс хамааран оюутнууд дараах дөрвөн төрлийн сургалтаас аль нэгийг нь сонгон суралцах боломжтой.
1) Мастерийн тайлан 2) Мастерийн төсөл 3) Хүндэт мастерийн төсөл 4) Хүндэт мастерийн дипломын ажил

Магистрын төслийн ажлын үйл явцын урсгалын жишээ (ерөнхий зүйлс)

2-р семестр

Оюутан Магистрын төслийн ажлын Төслийн үндэслэл хичээл (заавал суралцах хичээл)-д хамрагдаж, төслийн бүтэц, хэрэгжүүлэх арга замын талаар ерөнхийд нь суралцана. Магистрын төсөл хэрэгжүүлж буй оюутан судалгааны төлөвлөгөө боловсруулж, хүргүүлнэ.

3 болон 4-р улирал

Оюутан төслийн ивээн тэтгэгчид төслийн явц, үр дүнг тогтмол тайлагнадаг. Төгсөхөөсөө өмнө оюутнууд дипломын ажил бичих ба амаар хамгаалах замаар багш нартаа шүүлэг өгнө.

еСургалтын заал

Төв заал

Лекцын өрөө

Хичээлээ сонгох

KCGI-д Мэдээлэл Технологийн Шинжлэх Ухааны Магистрын зэрэг (IT-н MS) хамгаалахын тулд бүх оюутан тодорхой тооны кредитийг цуглуулж, Магистрын төслийн ажлаа хийж гүйцэтгэсэн байх шаардлагатай.
KCGI-иас санал болгож буй хичээлүүд нь дараах гурван хэсэгт хуваагддаг. Үүнд: Мэргэшүүлэх хичээл, дадлагажих хичээл болон дагалдах сонгон суралцах хичээл орно. KCGI нь вэбэд суурилсан бизнестэй холбоотой олон төрлийн хичээлүүдээс салбарын анхаарлыг ихэд татсан, холбогдох мэдлэг чадварын эрэлт хэрэгцээ өндөртэй хичээлүүдийг сонгодог. Дараа нь эдгээр хичээлүүдийг сургалтын төлөвлөгөөнд тусгаснаар оюутнуудад үр дүнтэйгээр мэргэжилдээ мэргэших боломжийг олгодог. Оюутнуудад өөрсдийнхөө аргаар суралцах эрх чөлөөг олгохын тулд сургалтын төлөвлөгөө нь тодорхой чиглэлд холбогдолгүй хичээл сонгох судлах боломжийг тусгаж өгсөн байдаг.

Мэргэшүүлэх чиглэлүүд	IT холбоотой өргөн хүрээний мэдлэгийн дотроос тус бүр тодорхой салбарыг сонгон, тухайн мэдлэгийг гүнзгийрүүлэх зорилготой хичээлийн бүлэг юм. Мэргэжлийн бөгөөд өргөн хүрээний мэдлэг эзэмшихийн тулд, салбар бүрийг бүлэгжсэн хичээлтэй болгосон.
ERP	Аж ахуйн нэгжид ажиллах боловсон хүчин, эд зүйл, мөнгөтэй холбоотой мэдээллийг хянах, удирдах явцад шийдвэр гаргахыг дэмжих суурь мэдээллийн системийн талаар суралцана.
Бизнес дата анализ	Cloud болон database-д хуримтлагдсан бизнес мэдээллийг анализ хийж, үр дүнтэй шийдвэр гаргахад хэрэглэх аргыг суралцана.
Global entrepreneurship	Компани байгуулагч хүний үзэл бодол болон тэргүүлэх ур чадвар, data анализ, хэрэглээний арга зэрэг, IT бизнесийн салбарт өөрийн компанийг байгуулахад хэрэгтэй мэдлэг, технологиос суралцана.
Вэб систем бүтээх	Database болон Cloud үйлчилгээ зэрэгтэй холбоотой вэб хуудас төлөвлөх, зохион бүтээх, PC ба smartphone-д зориулсан вэб аппликешн хийх зэргээс суралцана.
Сүлжээ хянах	Энэ хичээлд хамрагдсад зориулалтын дагуу сүлжээ байгуулж, үүлэн тооцоолол болон ашуулгүй байдлын менежментийн талаар судалж, төрөл бүрийн клиент/серверийн системийг хэрхэн хөгжүүлж, хэрэгжүүлэх талаар суралцана.
IT манга, анимэ	Анимэ болон зурган бүтээлийг хэрэглэн төлөвлөх, бүтээх технологи, тухайн загварыг бизнестэй холбох аргын талаар сурна.
IT-ийн аялал жуулчлал	Энэхүү сургалтын хөтөлбөрөөр оюутнууд аялал жуулчлалд ICT-г хэрэглэх, аялал жуулчлалын бизнест IT-ийг хэрэгжүүлэх, аялал жуулчлал, зочид буудал болон бусад мэдээллийн менежмент, аялал жуулчлалын төлөвлөлт, төлөвлөгөөний талаар судалдаг.
Хиймэл оюун ухаан	Энэхүү хичээлд хамрагдаж буй оюутнууд хиймэл оюун ухаан (AI) болон холбогдох технологийг хөгжүүлэх үндсэн онол, хэрэглээний талаар бусад салбар болон бодит амьдрал дээр тулгуурлан суралцах болно.
Үйлдвэрийн салбарын хичээл	**Эдгээр хичээлүүд нь тодорхой чиглэлийн мэргэжлийн мэдлэг чадвар болон технологийг практикт ашиглахад чиглэгддэг. Хичээлүүд нь салбар тус бүрээр төрөлжсөн байна. Салбар тус бүрийн тэргүүлэх шилдэг хүмүүс лекц уншина. Эдгээр хичээл болон бусад хичээлүүдийг судалж буй салбар бүрийн тэргүүлэх чиг хандлагыг харгалзан байнга шинэчилж байдаг.**
Fintech	Санхүүгийн салбар дахь ICT хэрэглээ. Цахим мөнгө болон цахим төлбөрийн одоогийн байдал болон ирээдүйн төлөвийг заана.
Хөдөө аж ахуй	Хөдөө аж ахуй салбарт дахь ICT хэрэглээ. Ургамлын үйлдвэр зэрэг ургуулах орчины хяналт, хөдөө аж ахуйн тээвэрлэлтийг сайжруулах аргыг заа на.
Далай	Усан онгоц болон далай дахь ICT хэрэглээ. Усан онгоцны хяналт, далайн бүтээгдэхүүний орчны хяналтыг заана.
Эмчилгээ, эрүүл мэнд	Эмэнэлгийн салбар дахь ICT хэрэглээ. Цахим картын мэдээлэл хянах, AI болон дата-г харагдахаар болгож оношлогооны тусламжыг заана.
Контент маркетинг	Манга, анимэ, кино, дуу зэргийн ICT хэрэглээ. Бүтээх процессыг дижитал болгох, оюуны эрхийн хяналт, түгээх төлөвлөгөө гэх мэтийг үзнэ.
Боловсрол	Боловсролын салбар дахь ICT хэрэглээ. Цахим сургалтын контент төлөвлөх, бүтээх, олон төрлийн харилцах системийг заана.
Дагалдах сонгон судлах хичээл	**Энэхүү сургалтын хөтөлбөр нь мэргэжлийн чиглэл болон салбар үл харгалзан мэргэжилтнүүдийн заавао ээзмшсэн байх ёстой харилцаа холбоо ба менежмент гэх мэт суурь мэдлэг чадвар олгох хичээлүүдээс бүрдэх ба ICT-ийн хэрэглээ, технологийн чиг хандлагыг хамарсан кейс судалгаа зэрэг хичээлүүдээс бүрдэнэ. Энэ нь суурь мэдлэг чадвараас эхлээд төрөл бүрийн чиглэлийн хичээлүүдийг хамтад нь заадаг тул энэхүү сургалтын хөтөлбөр нь оюутнуудын мэдлэгийн цар хүрээг нэмэгдүүлдэг.**
Харилцаа	ICT болон бизнесын салбарт хэрэгтэй логик бөгөөд ойлгомжтой харилцаа (харилцан ярих чадвар, илэрхийлэх чадвар)-г бодитоор суралцана.
Менежмент	Оюутнууд аж ахуй нэгжийн орчинд зайлшгүй шаардлагатай менежментийн ерөнхий аргачлалыг ойлгож, хэрэглэх чадвар ээзмшинэ.
Бүтээгдэхүүн хийх	Бүтээгдэхүүний чанарын сайжруулалт болон шинэчлэл бүтээх хүрээ зэргийг тодорхой жишээнд тулгуурлан сурна.
ICT тэргүүлэх хэрэглээ болон технологийн хандлага	ICT тэргүүлэх хэрэглээний жишээ, технологийн хандлагыг тодорхой жишээнд тулгуурлан суралцана.

Мэргэшүүлэх чиглэлүүд

Мэргэшүүлэх чиглэлүүд нь, өргөн хүрээний IT холбоотой мэдлэг дотор, тодорхой хүрээний мэргэжилийн болон өргөн хүрээний мэдлэгийг олж авахын тулд, оюутан сонгох хичээлийн салбарыг хэлнэ. Тус сургуульд, ялангуяа салбарт чухалд тооцогддог IT холбоотой мэдлэг болон чадвар шаардагддаг ажлыг доорхи байдлаар 8 хуваасан, тус бүрийн зорилгод тааруулан хуваасан, бүлэг болгосон.

ERP (Enterprise Resource Planning)

▶Энэхүү мэргэжүүлэх чиглэлүүдийн хичээлийн талаарх мэдээллийг 33-р хуудаснаас харна уу.

ERP (Enterprise Resource Planning: Байгууллагын нөөц төлөвлөлт) гэдэг нь аж ахуй нэгжийн боловсон хүчин, эд зүйл, мөнгө, мэдээлэл гэсэн resourse (эх үүсвэр)-г IT хэрэглэн нийтэд нь хянах удирдлагын арга юм. Тэр аргыг бодит болгох суурь мэдээллийн систем (ERP систем)-г ойлгож, аж ахуй нэгжийн ERP системийг оруулснаар бизнес процессыг сайжруулахад чухал алхам болно.
Энэ концентрацид оюутнууд бизнесийн интеграцчилал, санхүүгийн нягтлан бодох бүртгэлийн систем, борлуулалт, түгээлтийн системийг багтаасан SAP ERP боловсролын системийг (SAP S / 4HANA) ашиглан практик судалгаанд хамрагддаг. Мөн, янз бүрийн аж ахуй нэгжийн асуудалд анализ хийх болон ERP хэрэглэсэн жишээг судлах зэргийг хийнэ. In memory database болон IoT зэрэг сүүлийн шинэ аж ах уй нэгжийн дэд бүтэц болон ERP холбогдох талаар судална.

Бэлтгэгдэх боловсон хүчин

- ERP эхлэх консалтант
- ERP хэрэглэгчийн инженер
- ERP addon бүтээх инженер

Төслийн удирдагчийн зурвас Профессор **Ли Юи**

Өрсөлдөөн улам эрчимжиж буй энэ цаг үед олон компани бизнесээ өргөжүүлэхийн тулд ERP интеграцийн багцыг хэрэглэж байна. Төрөл бүрийн бизнес эрхэлдэг компаниуд ERP системийг бизнесийн интеграцчиллын үндсэн систем болгон суурилуулж байгаа тул бизнесийн төрөл бүрийн шинж чанаруудад дүн шинжилгээ хийх, компаниудын үйл ажиллагааны хэрэгцээ шаардлагад нийцсэн системийг хэрэглэх чадвартай ERP зөвлөхүүд зайлшгүй шаардлагатай болж байна.
Менежмент, нягтлан бодох бүртгэлийн мэдлэг чадвар ээзмшиж, программчлах гэх мэт мэдээлэл технологийн үндсэн ур чадварт суралцсанаар KCGI-ийн оюутнууд ERP системийг бараа материалын худалдан авалт, үйлдвэрлэл, борлуулалт, ложистик, нягтлан бодох бүртгэл, хүний нөөцийн менежментэд хэрхэн нийцүүлэхийг суралцана.
Магистрийн төслийн ажлаараа оюутнууд тодорхой салбарын ERP-ийн хэрэгжилтийн талаар судалгаа хийж, бизнесийн үйл явцыг сайжруулахад чиглэсэн менежментийн асуудлыг шийдвэрлэх шийдлийг санал болгодог. Оюутнууд ERP системийг өөрчлөн тохируулахаас гадна шаардлагатай үед нэмэлт болон гадаад системийг хөгжүүлэх ёстой.
Даяарчлал явагдахын хэрээр олон улсын тавцанд ажиллах чадвартай ERP зөвлөхүүдийн эрэлт улам нэмэгдэж байна. KCGI нь өнөө үеийн эрэлт хэрэгцээг хангах чадвартай дэлхийн ERP зөвлөхүүдийг Япон, Англи хэлээр бэлтгэн гаргадаг. Мөн Англи/Японы ERP системийг хөгжүүлэхийн зэрэгцээ бид олон улсын санхүүгийн тайлагналын стандарт (СТОУС)-д нийцсэн ERP системийн хэрэгцээ шаардлагыг тодорхойлох судалгаа явуулдаг.
Бид мөн улс орнуудын нягтлан бодох бүртгэл болон бизнесийн нөхцөл байдлыг судалснаар тухайн улсад тохирсон ERP системийг нэвтрүүлэх судалгаа явуулдаг. Манай ихэнх оюутнууд дэлхийн зөвлөх пүүсүүдэд ERP-ийн зөвлөх болох мөрөөдлөө биелүүлэхийн тулд шаргуу суралцаж байна.

ERP зөвлөх болох арга зам

ERP-ийн мэргэшүүлэх чиглэлээр заадаг үндсэн хичээлүүд нь дараах дараалаарх лекц болон практик хичээлүүдээс бүрдэнэ. Энэ нь мэргэшсэн SAP зөвлөх болох мэргэжлийн шалгалтанд оюутнуудыг бэлтгэж, корпорацийн орчинд ERP төслийг хэрэгжүүлэх мэргэжлийн чадвар ээзмших боломжийг олгодог. Эдгээр хичээлүүдэд мөн ERP-аас өөр мэргэшүүлэх чиглэл сонгосон оюутнууд ч хамрагдах боломжтой.

1-р семестр	Менежментийн мэдээллийн системийн удиртгал	▶ Аж ахуйн нэгжийн систем ▶ Ажлын нэгтгэл болон еБизнес
2-р семестр	Мэргэшсэн SAP зөвлөхийн шалгалтанд бэлтгэх лекцүүд ▶ Санхүүгийн нягтлан бодох бүртгэлийн систем бүтээх 1, 2 ▶ Борлуулалтын тээвэрлэлтийн систем бүтээх 1, 2 ▶ Үйлдвэржилтийн хяналтын системийг хийх	
3-р семестр болон дараагийн семестрүүд	ERP системийг хөгжүүлж, хэрэгжүүлэх практик судалгаа ▶ Дуураймал ERP хэрэгжүүлэх төсөл ▶ Internship ▶ Нэмэлт хэрэглэгдэхүүний хөгжүүлэлт болон программчлал	

Бизнес дата анализ

▶Энэхүү мэргэжүүлэх чиглэлүүдийн хичээлийн талаарх мэдээллийг 33-р хуудаснаас харна уу.

Бизнес дата анализ / ажилын дата анализ нь, сүүлийн үед янз бүрийн үйлдвэрийн салбарт анхаарал татаж буй бизнес арга бөгөөд аж ахуй нэгжүүд bigdata болон компани доторхи database-р хуримтлуулсан мэдээлэлд анализ хийж, өөрийн компаний хөгжилд хэрэгтэй үр дүнтэй шийдвэр гаргахад ашиглахыг гол зорилго болгож байна.
Энэ төвлөрсөн хичээлд олон төрлийн дата хуримтлалыг даган аж ахуй нэгжийн янз бүрийн асуудлыг хэрхэн шийдэх талаарх ойлголттой болно. Оюутан нь дата-г хэрхэн анализ хийж, хэрэглэж аж ахуй нэгжийн асуудлыг шийдэхэд хэрэглэх талаар суралцана. Маркетингийн талаарх ойлголт, статистик анализд суурилсан CRM (хэрэглэгчийн мэдээлэл хянах) болон тээврийн дэд бүтэц, хүргэлтийн бизнес загварын SCM (Supply Chain Management) зэрэг чухал ойлголтыг хамтад нь сурна.

Бэлтгэгдэх боловсон хүчин

- Мэдээллийн эх үүсвэрийг гаргах, хэрэглэх (data mining), зах зээлийн анализ зэргийг хийх аналист
- Бүтээгдэхүүний төлөвлөгөөний талаар зөвлөх, чиглүүлэх консалтант
- Дата-д суурилсан аж ахуй нэгжийн төлөвлөгөө зохиох, гүйцэтгэх зэрэг шийдвэр гүйцэтгэх CEO
- Хэрэглэгчийн хөдөлгөөний загвар болон төлөвлөгөө / урьдчилсан загварыг бүтээх CRM менежер

Төслийн удирдагчийн зурвас Профессор **Хон Сеун Ко**

Миний удирддаг төслүүд нь ихэвчлэн онлайн бизнес (“цахим маркетинг”)-ыг үр дүнтэй ажиллуулах B2C маркетингийн стратегид чиглэсэн байдаг. Манай оюутнууд цахим маркетингийн үндэс суурийг бүрдүүлдэг ICT-ийн мэдлэг чадвар эзэмшихийн зэрэгцээ онлайн борлуулалт, ашиг орлогыг нэмэгдүүлэхийн тулд худалдан авагчдын онлайн худалдан авалт хийх хандлагад дүн шинжилгээ хийдэг. Дараа нь эдгээр үр дүнг когортын шинжилгээ, AHP шинжилгээ зэрэг статистик арга техник ашиглан стратеги боловсруулахад хэрэглэдэг.
Миний удирдлаган дор судалгааны ажлаа хийж буй оюутнуудын зарим төлөөлөл жилд 1 удаа Хойд Америк, Европ гэх мэт улсуудад олон улсын эрдэм шинжилгээний бага хуралд оролцож Англи хэл дээр илтгэл тавьдаг. Худалдан авагчдад чиглэсэн мэдлэгийн менежментийн гол цөм болох маркетингийн стратегийг судлахыг зөвлөдөг. Та гадаадад олон улсын эрдэм шинжилгээний бага хуралд илтгэл тавих сорилттой тулгарахад бэлэн үү?

Global entrepreneurship

▶Энэхүү мэргэжүүлэх чиглэлүүдийн хичээлийн талаарх мэдээллийг 33-р хуудаснаас харна уу.

Дэлхийн бизнес эрхлэгчид өөрсдийн болон бусдын венчурын бизнесийг эхлүүлж, хөгжүүлж, удирдаж, бусад салбар дахь бизнесийн хөгжлийг дэмжихэд өөрсдийн туршлагаа ашигладаг. Энэ төвлөрсөн хичээл нь оюутнуудад бизнесийн сэтгэлгээ, манлайллыг төлөвшүүлэхэд шаардлагатай мэдлэг ур чадварыг эзэмшүүлнэ. Оюутнууд дэлхийн бизнес түүний дотор цахим худалдаа, вэбэд суурилсан бизнес зэрэгт анхаарлаа төвлөрүүлэхийн зэрэгцээ санхүү, маркетинг, менежментийн үндсэн ойлголтуудыг судалдаг.

Бэлтгэгдэх боловсон хүчин

- Удирдлагын консалтант
- Аж ахуй нэгж удирдагч
- Аж ахуй нэгжийн анализ болон venture хөрөнгө оруулалтыг дэмжигч
- Аж ахуй нэгжийн ажил бүтээх продюсер

Төслийн удирдагчийн зурвас Дэд профессор **Ониши Кэнго**

KCGI нь бизнес эрхлэгч болон хувийн бизнес эрхлэх туршлагатай багш нарыг ажиллуулдаг. KCGI нь байгуулагдсан цагаасаа хойш олон тооны хувиараа бизнес эрхлэгчдийг тэдний удирдлаган дор төгсгөсөн. Эрдмийн зэрэг олгох сургуулийн хувиар KCGI нь бусад сургуулиудын санал болгох боломжгүй хувиараа бизнес эрхлэгчдийг хөгжүүлэхэд чиглэсэн сургалтын хөтөлбөр санал болгодог бөгөөд хувиараа бизнес эрхлэгчдэд зайлшгүй шаардлагатай ICT-д суурилсан маркетинг, харилцагчийн менежмент болон удирдлагын үүрэг хариуцлагын талаар мэдлэг чадвар олгодог.
Эдгээр амжилтуудыг үнэлэн Боловсруулалт, Туршилт, Үнэлгээний Хамтын Ажиллагааны Боловсролын Газраас мэдээлэл технологийн хувиараа бизнес эрхлэгчдэд зориулсан загвар сургалтын хөтөлбөр боловсруулах чиглэлээр, мөн Мэдээлэл Технологийг Дэмжих Газрын харьяа Мэдээлэл-Технологийн Хамгаалалтын Газар (IPA)-ын нэг салбар их сургуулиуд дээр Мэдээлэл Технологийн Хувиараа Бизнес Эрхлэгчдийг бэлтгэх чиглэлээр хамтран ажиллахад KCGI-ийг нэр дэвшүүлж байв. KCGI нь одоогоор хувиараа бизнес эрхлэгчдийг бэлтгэх шинэ сургалтын хөтөлбөр боловсруулах чиглэлээр бусад их сургуулиудтай нягт хамтран ажиллаж байна.
Хэрэв та тайлан боловсруулах чадвараа нэмэгдүүлэхэд ICT-ийн ур чадвараа ашиглах чадвартай бол олон нийтийн агентлагуудын зохих дэмжлэгээр бизнесээ эхлүүлэх нь таны хувьд бодит ажил болж чадна.

Вэб систем бүтээх

▶Энэхүү мэргэжүүлэх чиглэлүүдийн хичээлийн талаарх мэдээллийг 34-р хуудаснаас харна уу.

Вэб систем бүтээхэд, аж ахуй нэгжийн intranet-д байрлуулсан компани доторх вэб хуудас болон, инернетэд гадагш хандсан вэб хуудас аль аль нь багтана. Ерөнхийдөө вэб систем хөгжүүлэгч нар HTML5 гэх мэт програмчлалын хэл болон тэмдэглэгээний хэлийг ашиглан вэбсайтуудыг кодчилдог. Гэвч тэд мөн контентын менежментийн системийг (CMS) ашиглах үүрэг хүлээдэг. Энэ төвлөрсөн хичээлээр вэб системийн програмчлал, кодчлолоос гадна, сүлжээний суурь мэдлэгийн талаар суралцана.

Бэлтгэгдэх боловсон хүчин

- Хэрэглэхэд хялбар вэб хуудас төлөвлөх / програмчлах
- Шинэ хуудас хийх болон байгаа хуудасаа сайжруулахад оролцох продюсер
- Өөрийн хуудасны давуу талыг барих, сайжруулах хуудасны менежер
- Одоо байгаа вэб үйлчилгээ болон cloud үйлчилгэг нэгтгэсэн аппликешн бүтээх инженер

Төслийн удирдагчийн зурвас Дэд профессор **Накагучи Такао**

Вэб системийн хөгжил санаанд оромгүйгээр өргөжиж байна. Энэ нь үйлчилгээ үзүүлэхэд өргөнөөр хэрэглэгдэх болсон боловсронгуй технологи хэрэглэдэг боловч сүүл үеийн технологийг урьд өмнө нь хэзээ ч тохиолдож байгаагүй шинэ үйлчилгээ бий болгоход хэрэглэж байна. Мөн веб системийг оффисын орчинд хэрэглэдэг удирдлагын хяналттай хослуулах боломжтой бөгөөд ухаалаг гар утсанд ашиглах AR програмуудыг бүтээх ажлууд багтдаг.
Зарим төслүүдэд мэдрэгч, камер зэрэг төхөөрөмжөөс мэдээлэл цуглуулдаг Юмсын интернет (IoT) багтсан байж болно. Тухайлбал хэвийн бус байдлыг илрүүлэхэд дүрсээр таних систем нэвтрүүлэхийн тулд хиймэл оюун ухаан (AI) ашиглах боломжтой. Сүүлий үеийн систем хөгжүүлэлтийн төслүүдийг веб технологи ашиглан хэрэгжүүлж байна. Төрөл бүрийн програмчлалын хэл, мэдээллийн сан зэрэг нь чухал үүрэг гүйцэтгэх болжээ.
Олон янзын технологитой ажиллахад хамгийн чухал нь хөгжүүлэх гэж байгаа системийн зориулалтаа зөв тодорхойлох явдал юм. Системийг аль салбарт ашиглахаар төлөвлөсөн бэ? Ямар асуудал байна вэ, үүнийг хэрхэн шийдвэрлэх вэ? Та санал боловсруулахдаа ямар технологи ашиглах вэ? гэх мэт.
Та эдгээр зүйлсийг нэгэнт бий болгосон бол өөрийн системийг хөгжүүлж, хэрэглэгчтэй болж, ур дүнгээ үнэлэх боломжтой. Ийм төсөлд оролцох нь оюутнуудад өөрийн нийгэмд тохирох системийг боловсруулж хөгжүүлэх ур чадвар олгодог. Төгссөний дараа оюутнууд Вэб технологийн мэргэжилтнүүдийн хувиар карьераа үр дүнтэйгээр эхлүүлж чадна гэдэгт бид итгэдэг.

Сүлжээ хянах

▶Энэхүү мэргэжүүлэх чиглэлүүдийн хичээлийн талаарх мэдээллийг 34-р хуудаснаас харна уу.

Сүлжээний үйлчилгээ нь өнөөгийн мэдээллийн системийг дэмжих чухал зүйл юм. Сүлжээний хариуцагч компьютер сүлжээ болон үйлчилгээний систем бүтээх, гэмтлийг засах, хянах, сүлжээний гэмтэл гарсан тохиолдолд, гэмтлээс сэргэх болон сүлжээний датаг хадгалах ажлыг хийнэ. Энэ төвлөрсөн хичээлээр сүлжээ ажиллуулах болон мэдээллийн аюулгүй байдлын талаарх мэдлэгийг эзэмшинэ.

Бэлтгэгдэх боловсон хүчин

- Аж ахуй нэгжид зориулсан интернет үйлчилгээг хадгалах, ажиллуулах инженер
- Аж ахуй нэгжийн доторх сүлжээ болон суурь системийн аюулгүй байдлыг хянах хянагч
- Үйлчилгээ бүрийн орчин (вэб, database, бичлэг зэрэг) бий болгох, ажиллуулах менежер
- Cloud үйлчилгээ болон IoT хэрэгсэл зэрэг багтаасан янз бүрийн сүлжээний нэгтгэх дэмжлэгийн консалтант
- Сүлжээний сервер / client software бий болгох, ажиллуулах менежер

Төслийн удирдагчийн зурвас Профессор **Найто Шозо**

Миний мэргэшсэн чиглэл бол мэдээллийн аюулгүй байдал болон сүлжээ юм. Мэдээллийн систем боловсруулж ашиглах үед сүлжээ болон аюулгүй байдал нь машины дугуй шиг бие биетэйгээ нягт холбоотой чухал зүйлс юм. Сүлжээ нь мэдээллийн системийг хялбарчилдаг боловч аюулгүй байдлын эрсдлийг тэр хэмжээгээр нэмэгдүүлдэг. Сүлжээний технологи болон аюулгүй байдлын технологи нь нэг төрлийн уралдаан шиг байнга бие биенээсээ өрсөж хөгжиж байдаг. “Хаа сайгүй сүлжээтэй нийгэм” гэдэг үгс сүүлийн үед байнга сонсогдох болжээ. Энэ нь төрөл бүрийн зүйлсийг сүлжээнд холбох нь улам өргөжиж байгааг харуулж байна. Түүнчлэн одоогийн бас нэгэн нийтлэг хандлага бол техник хангамж болон платформ гэх мэт бүх зүйлсийг үүлэн тооцоолол гэх мэт өгөгдлийн сервер дээрх програм хангамж (аппликэйшн)-инд нэгтгэх явдал юм
Мэдээж дээр миний хэлсэнчлэн үйлчилгээний орчинг мэдээллийн аюулгүй байдлын найдвартай хамгаалалттайгаар хэрэгжүүлэх боломжтой. Хувийн мэдээлэл алдагдах, компьютерийн вирус халдваралах, Вэб серверийг хакердах, вэбсайтыг ажиллагаагүй болгох, цахим худалдааны луйвар зэргээс үүсэх хохирлын хэмжээ нь сүлжээ өргөжихийн хэрээр нэмэгддэг. Гэвч хаалттай эсхүл сүлжээгүй орчинд бүцаж шилжих нь зөв сонголт биш юм. Харин өнөөгийн нөхцөл байдалд зохих тэнцвэрийг хадгалах шийдэл эрж хайх нь зүйтэй.
Шинээр элсэж буй оюутнуудыг онол, практик хоорондох тэнцвэрийг хадгалснаар хамгийн сүүл үеийн сүлжээний болон мэдээллийн аюулгүй байдлын технологид суралцахыг урьж байна. Энэхүү сургалтын хөтөлбөр нь мэдээлэл технологи болон мэдээллийн ёс зүй нь нийгмийн системд ямар үүрэг гүйцэтгэдэг талаар авч үзэх боломжийг бүрдүүлдэг.

IT манга, анимэ

▶Энэхүү мэргэжүүлэх чиглэлүүдийн хичээлийн талаарх мэдээллийг 34-р хуудаснаас харна уу.

Японы контент, бүтээлч үйлвдэрлэлийн салбар нь манга боон анимэ-р дамжуулан дэлхий дахины анхаарлыг ихээр татаж байна. KCGI-д оюутнууд контент бүтээлч үйлдвэрлэлийн салбарт тулгардаг олон нөхцөл байдлууд тухайлбал контент-бүтээлч үйлвэрлэлийн салбар дахь хуучин бизнес загваруудын судалгаанд үндэслэн бизнесийн шинэ загвар бий болгох, аниме төлөвлөх, үйлдвэрлэх дадлага хийх зэрэг туршлагатай болно. Энэхүү сургалтын хөтөлбөр нь оюутнуудад контент бүтээх явцад тулгарч буй бэрхшээлтэй асуудлуудыг шийдвэрлэх шийдлийг олох дадлыг эзэмшүүлнэ.Мөн ICT-н гол хүч нь контент, бүтээлч үйлдвэрлэлийн салбарт зайлшгүй шаардлагатай тул оюутнууд дижитал хэрэгслийг эзэмшиж сурдаг. Энэхүү сургалтын хөтөлбөрөөр дамжуулан олон янзын нөхцөл байдалд хэрэглэх шийдлийг боловсруулах чадварыг хөгжүүлэн суралцана.

Бэлтгэгдэх боловсон хүчин

- Манга, анимэний контент төлөвлөлт, бүтээх, танилцуулахыг нийтэд нь хийх продюсер
- Тоон / аналог төрөл бүрийн хэрэгсэлийг ашиглаж чадах контент бүтээгч
- Бүтээлийн зорилгод тааруулан, зургийн бүтэц болон эффектийг үр дүнтэй үзүүлэх чадвартай директор
- Боловсрол болон зугаа зэрэг, манга, анимэгийн зах зээлийн хандлагад суурилсан контент төлөвлөх чадах маркетинг директор

Төслийн удирдагчийн зурвас Профессор **Үэда Кожи**

Миний мэргэшсэн салбар бол програмчлал, мультимедиа, ICT болон хөгжиж буй орнуудад технологи нэвтрүүлэх чиглэлээр сургалтын хөтөлбөр боловсруулах юм. Хөгжиж буй болон хөгжингүй орнуудын хувьд хүн бүр удахгүй цахим сургалтаар тодорхой контентуудыг ашиглан өөрсдийн хүсч буй боловсролоо хялбархан эзэмших боломжтой болно гэдэгт итгэж байна. Тэр үед хаанаас ч үзэх боломжтой илэрхийллийн нэг арга болох энимэйшн нь хамгийн үр дүнтэй арга хэрэгсэл болно гэж найдаж байна.
Анимэ бүтээгч болоход урлагийн бүтээл туурвих гэх мэт дижитал арга хэрэгслийг ашиглах чадвар шаардагдах боловч үнэндээ илүү олон ур чадвар шаардлагатай болдог. Анимэ бүтээгч нь контент боловсруулах, зардалд хяналт тавих, урлагийн бүтээлийг түгээх аргуудаас бүрдсэн бизнес загваруудын талаар зохих мэдлэгтэй байх шаардлагатай. Контент бүтээгч нь мөн тухайн улсын нөхцөл байдал болон соёлын ойлголтонд үндэслэн хилийн чанадад хялбархан нэвтрүүлэх боломжтой контентуудыг бүтээх мэдлэг чадвартай байх ёстой. Энэ чиглэлээрх миний зорилго бол олон талын өнцгөөс харж контент бүтээх, ICT ашиглан дэлхий дахинд түгээх арга барил эзэмшсэн контент хөгжүүлэгчдийг бэлтгэхэд оршино.

Хиймэл оюун ухаан

▶Энэхүү мэргэжүүлэх чиглэлүүдийн хичээлийн талаарх мэдээллийг 35-р хуудаснаас харна уу.

21-р зууны эхэн үеэс хиймэл оюун ухаан нийгмийг өөрчлөх үндсэн технологи болж гарч ирсэн. Энэхүү технологийн онол үсрэнгүй хөгжихийн хэрээр интернет ашиглан Big Data-г олж авах нь хялбар болж микропроцессорууд болон бусад компьютерийн системүүд хурд, хүчин чадлаараа квант үсрэлт хийсэн. Хиймэл оюун ухааны хэрэглээний хүрээ өргөжиж, одоогоор автомат орчуулагч, өөрөө явагч хэрэгсэл, эмнэлгийн мэдээлэл боловсруулах, сувилахуйн үйлчилгээнд зориулсан роботууд болон үүнтэй төстэй спорт, цахим спорт, мөн корпорациудын стратеги, хөдөө аж ахуйн менежмент болон бусад бизнесийн хэрэглээнд шинэ хандлага зэргийг нэвтрүүлэхэд суралцах болно.
KCGI-ийн хиймэл оюун ухааны чиглэлээр мэргэшиж буй оюутнууд хиймэл оюун ухааны онолын үндэс болоод түүнийг хэрэгжүүлж буй дэлхийн нийтийн бодит жишээн дээрээс суралцахаас эхэлнэ. Сургалтын хөтөлбөрт нь хиймэл оюун ухааны технологийг ашиглах буюу энэхүү технологийн ашиглах чадвартай мэргэжилтнүүдийг төлөвшүүлэхэд чиглэсэн олон тооны холбогдох програм хангамжийн хөтөлбөрүүд багтсан байдаг.

Бэлтгэгдэх боловсон хүчин

- Ирээдүйн хиймэл оюун ухаан хөгжсөн дэвшилтэт нийгэмд амжилт гаргах чадвартай хүмүүс
- Хиймэл оюун ухааныг бусад олон салбарт ашиглаж, хэрэглээнд оруулах чадвартай хүмүүс

Төслийн удирдагчийн зурвас Профессор **Шинжи Томита**

Математикийн үндсэн онол нь хиймэл оюун ухааныг судлахад амин чухал хичээлүүдийн нэг юм. Гэхдээ энэ нь зөвхөн нэг номерын шаардлага биш, харин хоёр ба гурав дахь тоо юм. Харамсалтай нь маш олон оюутнууд математикийг үзэн яддаг. Энэ нь үнэхээр ичгүүртэй зүйл билээ, учир нь амттай жимс хэн нэгнийг зулгаахыг хүлээж байхад, тэд амсахаасаа ч өмнө нь аль хэдийн дургүй болсон байдаг.
2045 онд хиймэл оюун ухаан "өвөрмөц байдал"-аараа хүний байр суурийг эзэлнэ гэдэгт би зарим хүмүүсийн адил итгэдэггүй. Хиймэл оюун ухаан нийгмийг танигдахын аргагүй болгож өөрчлөнө ч гэсэн асуудал байхгүй. Тиймээс бид хиймэл оюун ухааны тусламжтайгаар нийгэмд хөгжихөд шаардлагатай ур чадварыг эзэмшүүлж сургах ёстой. Хүмүүс хэрэгтэй үндсэн онолоо судалж, ойлгон туршлагатай болсныхоо дараа хэрвээ тэд хүсвэл үндсэн онолыг мартаж болох юм.

IT-ийн аялал жуулчлал

▶Энэхүү мэргэжүүлэх чиглэлүүдийн хичээлийн талаарх мэдээллийг 35-р хуудаснаас харна уу.

Сүүлийн жилд, засгийн газарын аялал жуулчлалыг хөгжүүлэх төлөвлөгөө зэргийн нөлөөгөөр, гадаадаас ирэх жуулчид ихсэж, 2019 онд хамгийн ихдээ 31,880,000 хүнд хүрсэн (Японы засгийн газарын аялал жуулчлалын төвийн судалгаа). Алангуяа тус сургууль байрлах Киото, Токио, Саппород аль аль нь аялал жуулчидад алдартай, аялал жуулчлалын хэрэгцээ, тулгарах асуудлыг ойрхон мэдрэх орчин байдаг.
Нэн ялангуяа оюутан солилцоонд чиглэсэн энэхүү мэргэшүүлэх хичээл нь аялал жуулчлалын шинэ үйлчилгээ болон бизнесийн моделийг IT ашиглан бий болгох олон давуу талуудыг бий болгодог. KCGI нь аялал жуулчлалын мэдээллийг олон хэлээр хэвлэл мэдээллийн хэрэгслээр хангах, харилцагчийн үйл ажиллагааг дижиталчлах, дүн шинжилгээ хийх, урьдчилан таамаглах гэх мэт үйл ажиллагаагаар дамжуулан асуудлуудыг бодитоор хэрхэн шийдвэрлэх талаар хүмүүст зааж сургадаг.

Бэлтгэгдэх боловсон хүчин

- Аялал жуулчлалын бизнесийн төлөвлөгөө, систем бүтээх, big data хэрэглэх зэрэгт холбогдох инженер
- Аялал жуулчлалын үйлчилгээний менежментийг ICT-р илүү үр дүнтэй болгох чадвартай менежер

Төслийн удирдагчийн зурвас Профессор **Ли Мэйхүй**

Би дэлхийн боловсон хүчний хөгжлийн чиглэлээр мэргэшсэн. Сүүлийн жилүүдэд эдийн засгийн даяарчлал эрчимжихийн зэрэгцээ гадаадын харьяа компаниуд Японы зах зээлд орж ирэх явдал нэмэгдэж байна. Үүнээс гадна гадаадын зах зээл өмнөхөөсөө илүү өсч байна. Үүний үр дүнд үйлдвэрлэлийн болон борлуулалтын баазаа хилийн чанадад гаргах хүсэлтэй Японы аж ахуйн нэгжийн улам нэмэгдэж байгааг харж болно. Одооноос дэлхийн хэмжээний боловсон хүчнийг сургаж бэлтгэх, хадгалж үлдэхийг эрмэлзэж байгаагаас нь харахад иймэрхүү мэргэжилтнүүдийн эрэлт хэрэгцээ эдгээр компаниудад эрс нэмэгдэх нь тодорхой байна. Улсын засгийн газар Япон улсыг аялал жуулчлалын гол бүс нутаг болгох бодлогоо хэрэгжүүлэхийн хэрээр аялал жуулчлалын салбар Японы эдийн засгийг дэмжих гол салбар болж байгаа нь улам ихээр сонирхол татаж байна. Дотоодын аялал жуулчлалын чиглэлээр ажиллах хүмүүсийн эрэлт нэмэгдэж байгаа нь уг чиг хандлагатай холбоотой нь тодорхой юм.
Эдгээрийн дундаас нэгэн шинээр урган гарч ирж байгаа асуудал бол аялал жуулчлалын ачаалал хэтрэх юм. Нийтийн тээврийн ачаалал, Япончуудын ёс зүйгүй гэж үздэг зан авир гэх мэт олон асуудал үүсэхээс гадна нутгийн иргэдэд аюулгүй байдлаа алдсан мэт сэтгэдэл төрүүлж болзошгүй юм. KCGI нь жуулчдын сонирхлыг ихээр татдаг Киото хотод байрладаг. Киотод байрладаг олон тооны уламжлалт сүм хийдүүдийг ариун газар гэж үзэх үү эсвэл аялал жуулчлалын нөөц гэж үзэх үү? Бүс нутгийн соёлын өвийг хадгалах, жуулчдын эрэлт хэрэгцээг хангах гэсэн 2 асуудлын хоорондох үүсэх зөрчилдөөн бодит байдал дээр байнга ажиглагддаг.
Энэхүү мэргэшүүлэх хичээлээр бид дэлхийн шинжлэх ухааныг урлагтай нэгтгэсэн арга хэрэгслийг ашиглан эдгээр асуудлуудыг шийдвэрлэх арга хэмжээний талаар авч үзэх ажиглалт судалгааны ажил санал болгодог. Бид дэлхийн аялал жуулчлалын томоохон хотуудын нэг Киотод IT-ийн аялал жуулчлалын чиглэлээр ажиллах мэдлэг, чадвар, өндөр боловсролтой мэргэжилтнүүдийг сургаж бэлтгэх зорилго тавин ажиллаж байна.

Италийн Милан дахь хамгийн нэр хүндтэй аялал жуулчлалын боловсролын сургууль

Италийн Милан хотод байдаг хамгийн нэр хүндтэй аялал жуулчлалын боловсролын сургууль болох IULM их сургуультай KCGI хамтран ажилладаг. 1968 онд байгуулагдсан. Аялал эуулчлал, урлагаас эхлээд хэл судлал, харилцаа холбооны 3 фаүультеттэй ба одоогоор суралцаж буй оюутнуудын тоо магистерт сурч буй оюутнуудтай нийлээд 6300 оюутан байна.

IULM International University of Languages and Media
https://www.iulm.it/en/home

Давхар зэрэгтэй хөтөлбөр

(2 жил) **KCGI + IULM** (1 жил)

Энэ хөтөлбөр нь KCGI-ийн ердийн 2 жилийн мастерийн хөтөлбөрийг 3 жилийн хугацаатай сунгаж, сүүлийн жил нь KGCI-ийн түншийн сургууль болох IULM-д солилцооны оюутнаар суралцаж, хоёр талаас магистр зэрэгтэй зэрэгцэн суралцах хөтөлбөр юм. Манай сургуульд та Япон эсвэл англи хэлээр суралцах боломжтой бөгөөд англи хэл дээр IULM-д суралцаж болно.

Англи хэлээр дэлхийн шилдэг сургуульд аялал жуулчлалыг судлана!

3 жилийн туршид, Италийн болон бусад улс орнуудын оюутнуудтай харилцах боломжтой!

Дүүргэсний дараа Япон, Итали, бусад орнуудад аялал жуулчлалын салбарт ажиллах зам нээгдэнэ!

Япон, Итали, бусад орнуудад дадлага хийж болно!

Дадлагажих үйл ажиллагаа

Эдгээр хичээлээр ICT-ийг практикт хэрэглэх мэргэжлийн мэдлэг чадвар шаардсан тодорхой салбаруудад мэргэшүүлэх чиглэлийн дагуу судалгаа шинжилгээ хийдэг. Тус сургуульд ялангуяа ICT-г хэрэглэн асуудлыг шийдэх доорхи 6-н салбар, төрөлд ялган, тус бүрийн салбарт ажиллах боловсон хүчинг бэлтгэхэд зориулсан хичээлийг сонгон, грүпчилж байна.

Fintech

Банк санхүү (Finance) болон мэдээллийн технологи (Technology)-г нийлүүлсэн тоон төлбөр болон цахим төлбөр зэрэг шинэ банк санхүүгийн төрлийн мэдээллийн үйлчилгээ, өөрөөр хэлбэл “финтек (financial technology)” нь нийгмийн анхааралыг татаж байна.
Банк санхүүгийн төрлийн мэдээллийн үйлчилгээний ард байгаа тооцоо болон банк санхүүгийн бүтцийг сурахтай хамт, финтекийн систем зохиох бодит байдлын талаар суралцана. Тэр мэдлэгтээ тулгуурлан, веб болон smartphone аппликешн бүтээх, дата цуглуулах, анализ хийх гэсэн ICT-н ур чадвартай хослуулан, финтек салбарт ажиллаж чадах боловсон хүчинг бэлтгэнэ.

Бэлтгэгдэх боловсон хүчин
- Банк санхүү, тооцооны literacy болон веб бизнестэй холбоотой суурь мэдлэгтэй SE болон төлөвлөгч
- Хэрэглэгчийн хувийн мэдээлэл болон санхүүгийн мэдээлэл зэргийг цуглуулан, анализ хийх дата аналист
- Цахим мөнгө болон банк санхүү API зэрэг шинэ технологийг хэрэглэх аппликешн инженер

Хөдөө аж ахуй

Ногооны үйлдвэр болон хөдөө аж ахуйг дэмжих cloud үйлчилгээ зэрэг хөдөө аж ахуйд ICT-г оруулснаар, өв залгамжлах хүний хомсдолоос нас ихсэлт явагдаж, импортын хөдөө аж ахуйн бүтээгдэхүүнтэй өрсөлдөх чадвар буурах гэх мэтээр японы хөдөө аж ахуйн асуудлыг шийдэх хөдөлгөөн сүүлийн жилүүдэд их явагдаж байна.
Хөдөө аж ахуй салбарт одоогийн “Хөдөө аж ахуйн ICT”-н ажлыг танилцуулахын зэрэгцээ, түүний ард буй ногооны үйлдвэржилт, хэрэглээний бүтэц, түүнийг сайжруулах чиглэлээс суралцана. Мөн, орчны сенсор болон IoT оруулсан хөдөө аж ахуйн ICT-н системийн талаар суралцана. Эдгээр мэдлэгт суурилан, Бизнес дата аналитик болон Вэб систем бүтээх зэрэг төвлөрсөн хичээлтэй хослуулан, хөдөө аж ахуйн салбарт ажиллаж чадах технологич, консалтантыг бэлтгэнэ.

Бэлтгэгдэх боловсон хүчин
- Үйлдэрлэгчийн үйлдлийн дата болон хөдөө аж ахуйн бүтээгдэхүүний чанарын датаг цуглуулан, анализ хийж чадах дата аналист
- Үйлдэрлэгчийн know how-г сурах бичиг болгон дараахи үеээ бэлдэх цахим сурах бичиг бүтээгч
- Үйлдэрлэгч болон хэрэглэгч шууд холбогох (=CRM)-г дэмжих веб системийн SE болон консалтант

Далай

Далай, усны үйлдвэржилтийн хөгжилд ICT-г хэрэглэн далайн аюулгүй байдлыг хангах, ур дүнтэй үргэлжлэх процесстой загасны аж ахуйг бий болгохын тулд, satellite-г хэрэглэсэн дагах үйлдэл бүхий далайн эх үүсвэр, орчинтой холбоотой дата цуглуулах систем нэвтрүүлэх гэх мэт эрэлхийлэгдэж байгаа. Мөн, усан онгоцны бага энергижилт, аюулгүй байдал, CO_2 багасгах, далайн бохирдолоос сэргийлэх, далайн байгалын энерги ашиглах гэх мэтэд чиглэсэн усан онгоцны IT-жилт бас шаардагдаж байна. Эдгээр далайн IT-г тэргүүлэх боловсон хүчинг бэлтгэнэ.

Бэлтгэгдэх боловсон хүчин
- Усан онгоцны аюулгүй байдлыг дэмжих мэдээллийн систем бүтээх, ажиллуулж чадах SE
- Загасчлал, далайн үйлдвэрлэлд ажиллагчын know how-с, дараахи үеийн боловсролд чиглэсэн цахим сургалтын материал зэргийг төлөвлөх, бүтээж чадах консалтант
- Далайн үйлдвэрлэл, тээвэрлэлт, худалдахтай холбоотой тээврийн анализ, хяналтын мэдлэг бүхий менежер

Эмчилгээ, эрүүл мэнд

Эмчилгээний салбарт эмчилгээний бичиг баримтын систем, захиалгын систем, цахим карт системийн дүрслэл оношлогоо зэрэг IT-жилт эрчимтэй хөгжиж байна. Мөн, өвчтөн бүрийн эмчилгээнд хэрэглэгдэж байсан эмчилгээний дата болон эмчилгээний багажын датаг цуглуулж bigdata болгон анализ хийснээр халдвараас сэргийлэх болон хамгийн тохиромжтой эмчилгээний төлөвлөгөөг бэлдэх, интернет дэхь эмчилгээтэй холбоотой хэллэгийг анализ хийж халдварыг урьдчилан тооцох, сэргийлэх зэрэгт хэрэгтэй IT (ICT)-н хэрэглээ ихсэж байна. Ингэснээр, өндөр түвшний IT (ICT)-н ур чадварыг эмчилгээний салбарт хэрэглэж чадах боловсон хүчин хэрэгцээтэй.

Бэлтгэгдэх боловсон хүчин
- Цахим карт болон зайн эмчилгээ зэрэг, эмчилгээний салбарт янз бүрийн мэдээллийн систем бүтээх, хийх, ажиллуулж чадах SE
- Эмчийн оношлогоог дэмжихийн тулд, эмчилгээний дата болон эмчилгээний багажын датаг цуглуулан, анализ хийх, харагдахаар болгох know how бүхий дата шинжлэх ухааны
- Эмнэлэг доторхи болон бүсийн эмчилгээний төлөөх өндөр төвшиний мэдээллийн системийг хянаж чадах инженер

Контент маркетинг

Контент бизнест зайлшгүй оюуны өмчийн эрхийн талаар, манга, анимэ гэх мэт дуу болон зураг, бичлэгийн вэб хуудас, төрөл бүрийн оюуны өмчийн эрхийн талаар лекц хийж. оюуны өмчийн эрхийн талаархи мэдлэгийг гүнзгийрүүлнэ. Мөн, оюуны өмчийн эрхийн бизнесийн талаар үзэж, алдартай character ашигласан бизнес загварыг судална.
Тоглоом, манга, анимэ гэх мэт контент төлөвлөгөө, хийхээс танилцуулах хүртэлх процесс бүрт хэрэгтэй мэдлэг, технологийг эзэмшихийн зэрэгцээ, сүүлийн үеийн технологийн хандлага болон олон улсын зах зээлийн хандлагыг судлан, анализ хийж, сайжруулах санал болон бизнес загварыг санал болгоно.

Бэлтгэгдэх боловсон хүчин
- Боловсрол болон зугаа зэрэг, манга, анимэгийн зах зээлийн хандлагад суурилсан контент төлөвлөж чадах маркетинг директор
- Оюуны өмчийн эрх болон зохиогчийн эрх зэрэг, контенттай холбоотой хуульд тулгуурлан, маркетинг төлөвлөгөөг хийж чадах төлөвлөгөөч

Боловсрол

Боловсролын талбарт төрөл бүрийн цахим сургалтын ситем болон зөөврийн төхөөрөмж зэрэгт хэрэглэгдэх болж, багшийн сурах материал болон сурагчийн өөрийн бодлыг янз бүрийн медиагаар илэрхийлэх нь суурь мэдлэгээс сурах үйлдэл гэж үзэх болж ирсэн. Үсгээс гадна, дуу, зураг, infographics зэргийг хослуулан, гайхалтай ойлгомжтой сурах бичиг хийж, өөрийн сурсан зүйлийг графикжуулж дата болон хүснэгтээр цэгцэлж танилцуулах үйл ажиллагааг ICT-р илэрхийлэх нь өдөр тутам шаардагдах болж байна.
Мөн, сургуулийн боловсролоос гадна, хөдөө аж ахуй болон далайн төрөл бүрийн үйлдвэрийн салбарт өмнөх үеийн бий болгосон know how (далд мэдлэг)ийг дараа үед өвлүүлэхийн тулд, know howыг дүрс болон үйлдлийн дата зэргээр үлдээж, цэгцэлж, ойлгомжтой байдлаар сурах бичиг болгох ажил хүлээгдэж байгаа.
Цахим сургалтын орчинг бий болгоход мэргэшин, олон төрлийн илэрхийлэл болон цахим медиа-г тохиромжтой instructional design-д суурьлан, багш болон сурагчийн аль алинд нь ур дүнтэй боловсролын медиа хэрэглэхийг бодитоор сурна.

Бэлтгэгдэх боловсон хүчин
- Олон төрлийн илэрхийлэл, цахим медиаг ашигласан цахим сургалтын систем бүтээх болон ажиллуулахад оролцох боловсролтой холбоотой хүн
- Янз бүрийн үйлдвэрийн салбарын know how-г, цахим сурах бичиг бүтээхээр дамжуулан дараахи үедээ дамжуулах, хэрэглэх контент бүтээгч
- Олон төрлийн медиаг нэгтгэсэн боловсролын системийн анализ, загвартай холбоотой инженер

Вэб бизнес технологийн мэргэжилийн курс
Гол суралцах хичээл

Категори	Ангилал	Хичээлийн нэр	Кредитийн тоо	Дадлагат сургалт	Хичээлийн нэр	Кредитийн тоо	Дадлагат сургалт	Анхаарах зүйл
Мэргэшүүлэх хичээлүүд	ERP	Мэдээллийн сангийн ерөнхий онол	2		Борлуулалтын тэзвэрлэлтийн систем бүтээх 1, 2	Тус бүр 3	○	Эдгээр мэргэшлийн чиглэлийн аль нэгийг сонгоно уу. Та мөн төрөл бүрийн салбарын хичээлүүдээс сонгох боломжтой.
		IT-ийн статистик	2		Үйлдвэржилтийн хяналтын системийг хийх	3	○	
		Хэрэглээний мэдээлэл зүйн суурь математик	2		Худалдан авах агуулахын систем бүтээх	3	○	
		Вэб программлал 1, 2	Тус бүр 2	○	Боловсон хүчин хянах систем бүтээх	3	○	
		Аж ахуйн нэгжийн систем ＊	2		ERP ажлын аппликешн бүтээх ＊	3	○	
		Ажлын нэгттгэл болон еБизнес ＊	4	○	ERP зөвшилцлийн гүнгийрүүлсэн сэдвүүд	2		
		Олон улсын санхүүгийн онол	2		Объект хандалтат программчлал	4	○	
		Санхүүгийн нягтлан бодох бүртгэлийн систем бүтээх 1, 2 ＊	Тус бүр 3	○				
	Бизнес дата анализ	Мэдээллийн сангийн ерөнхий онол ＊	2		Өгөгдлийн шинжлэх ухаан ＊	2	○	
		IT-ийн статистик	2		Үнэлгээ хийх дата анализ хийх арга	2	○	
		Хэрэглээний мэдээлэл зүйн суурь математик	2		Хайх дата анализ болон харагдахаар болгох	4	○	
		Компютерын бүтэцийн онол	2		Мэдээлэл олборлолтын үндсэн онол	2		
		Вэб программлал 1, 2 ＊ (эвхэн 2)	Тус бүр 2	○	Техөөрөмж суралцах	2		
		Хиймэл оюун ухааны математик	2		Мэдээллийн сангийн хяналтын тусгай онол ＊	4	○	
		Хиймэл оюн ухаан програм хангамжийн програмууд 1, 2 ＊ (эвхэн 2)	Тус бүр 2		Орчны мэдээлэл зүйн систем	2		
		Компьютерийн программлал (Python) ＊	3	○	Зохион бүтээх сэтгэлгээ	4		
		Вэб бизнесийн ерөнхий онол	2		Интернет бизнес стратеги, маркетинг	2		
	Global entrepreneurship	IT-ийн статистик	2		Бренд загвар болон удирдлага	2		
		Хэрэглээний мэдээлэл зүйн суурь математик	2		Интернет бизнес стратеги, маркетинг ＊	2		
		Вэб программлал 1	2	○	еХудалдааны олон төрлийн арга барил ＊	2		
		Тогтмол хөгжихийн төлөөх тэргүүлэх чадвар	2		Global entrepreneurship болон бизнес загвар ＊	2		
		Байгууллагын төлөв судлал	2		IT Бизнесийн харилцаа судлал	2		
		Мэдээлэл ёс зүйн тусгай онол	2		Тоглоомын онол болон хэлэлцээр	2		
		Вэб бизнесийн ерөнхий онол ＊	2		Зохион бүтээх сэтгэлгээ	4		
		Бизнес экономик 1, 2	Тус бүр 2		Бодит cloud компьютерчлал	2		
		Оюуны өмчийн эрхийн тухай хууль	2		Хувиараа бизнес эрхлэгчдийн тухай шинэ хууль тогтоомж	2		
		Бизнесийн удридлагын тусгай онол ＊	2		Төсөл хянах аргачилал ＊	2		
		Аж ахуйн нэгжлийн менежментийн дадлагын онол ＊	2		Олон улсын хүний нөөцийн хөгжил	2		
		IT компани дадлагын онол	2					
	Вэб систем бүтээх	Мэдээллийн сангийн ерөнхий онол	2		Мэдээллийн сүлжээний ерөнхий онол	2		
		IT-ийн статистик	2		Вэб технологийн ерөнхий онол	2		
		Компьютерийн программлал (Python) ＊	3	○	Вэб үйлчилгээ хийх арга	4	○	
		Хэрэглээний мэдээлэл зүйн суурь математик	2		Вэб программлал 3 ＊	4	○	
Python програмчлалын хэл нь хиймэл оюун ухааны боловсруулалтанд оновчтой хэд хэдэн онцлог шинж чанартай байдаг. Жишээлбэл, өргөн цар хүрээтэй номын сантай гэх мэт. Оюутнууд энэхүү хичээлээр Python-ийн дүрмийг судалж, Python хэл дээр програмчлах шаардлагатай чадварыг эзэмшинэ.

Төсөл хянах аргачилал

Онлайн орчинд бизнес төлөвлөгөөг боловсруулж, бизнесийг хэрэгжүүлэхэд зайлшгүй шаардлагатай удирдлагын зүйлсийг ойлгож авна.Түүнчлэн бодит жишээ, кэйс судалгаа ашиглан, төслийн менежментийн аргуудыг практик дээр судалж, янз бүрийн арга хэрэгслийг ашиглах боломжтой.

Хэрэглээний мэдээлэл зүйн суурь математик

Энэхүү хичээлийг үзэж буй оюутнууд математикаар логик сэтгэлгээний чадварыг эзэмших ба ирж буй хиймэл оюун ухааны эрин үед мэдээллийн технологийг ашиглахад шаардагдах мэдлэг чадварыг эзэмшинэ. Хичээл суурь мэдлэг олгохоос эхлэх ба зарим үр ашигтай арга хэрэгслүүдийг авч үзэх болно.

IT хослуулсан Аялал жуучлалын тойм

Энэ хичээлийн зорилго нь аялал жуучлалын мэдээллийн технологийг судлах хэрэгцээ, суурь мэдлэгийг ойлгох явдал юм. Аялал жуучлалын мөн чанар, IT-н харилцан уялдаатай орчинд дэлхий дахины дэвшилтэт тохиолдлын судалгааг танилцуулахаас гадна ICT хэрэглэдэг аялал жуучлалын өвөрмөц шинж чанарыг судлах болно. Бүлгийн хэлэлцүүлэг гэх мэтчилэн янз бүрийн аргаар ICT ашиглан аялал жуучлалын салбарын талаархи мэдлэгийг олж авна.

Вэб програмчлал 1, 2

Вэб програмчлалын хамгийн сүүлийн үеийн тэмдэглэгээний хэл HTML5, CSS3 ашиглан вэб хуудасны дизайн боловсруулах, энгийн анимацийн аргыг хэрхэн 2-д JavaScript ашиглан, динамик вэб хуудасны програмчлал хийхийг заадаг.

Аялал жуулчлалын бизнесийн тойма

Оюутнууд аялал жуулчлалын бизнес, аялал жуулчлалын мэдээллийн талаархи үндсэн мэдлэгийг олж авдаг. Мөн, аялал жуулчлалын маркетингийн талаархи үндсэн мэдлэгээс бүтээгдэхүүнийг хөгжүүлэх, сурталчлах гэх мэт аялал эуулчлалын мэдээлэлтэй холбоотой ур чадварыг бодит кейс судалгаанаас суралцаж, холбогдох асуудлуудыг авч үзнэ. Түүнчлэн, дотоодын аялал жуулчлал, аялал жуулчлалын газрыг идэвхижүүлэх зэрэг хамгийн сүүлийн үеийн жишээг судалж, асуудлыг шийдвэрлэхэд чиглэсэн мэдлэгийг олж авна.

Объект хандалтат системийн боловсруулалт

Вэб болон application бүтээх үеийн программ хангамж боловсруулах арга болон програмчлалын технологийг сурна. Объект хандалтат paradigmыг ойлгож, системийн анализ болон төсөлийн төрөл бүрийн аргачлалыг суралцаж, ур ашигтай өндөр чанарын систем бүтээхийг зорино.

Японы нийгмийн талаарх ойлголт

Энэ хичээл дээр Японы нийгмийг юу бүрдүүлдэг талаар болон Японы ард түмний зан төлөв, хандлага, сэтгэлгээний хэв маягийг судална. Өргөн хүрээний кейс судалгаанд үндэслэн оюутнууд лекц, бүлгийн хэлэлцүүлэг, илтгэл тавих замаар Японы нийгмийн тухай ойлголтуудыг судлах болно.

Хэвлэл мэдээллийн арвин агуулга бүтээх

Интернэтээр илгээхийг зорило болгон, вэб зарлал болон бүтээгдэхүүн, арга хэмжээний зарлал зэрэгийн контент бүтээнэ. Бичлэг засварлах, хөдөлгөөнт зургийг засварлах программ ашиглана. Мөн хэрэглэгчийн интерфэйс болон хэрэглээний чанарын талаар хүрч, хэрэглэхэд амар, үр бүтээлтэй контент хийж сурна.

Аялал жуулчлалын удирдлагын менежмент

Аялал жуулчлалын газрыг хөгжүүлэх менежментийн талаас нь авч үзвэл, гадаадын жуулчдыг татах, хэт их төвлөрсөн жуулчдын тоог хуваарилах гэх мэтчилэн жуулчлалын бүс нутгийн стратегийн зорилтууд дээр тулгуурлан, аялал жуулчлалын мэдээлэл цуглуулах, дүн шинжилгээ хийх, мэдээллийн үйлчилгээг бүс нутагт хэрхэн бүтээх арга зүйг зааж өгдөг.

Дүрс бүтээх онол

Видео камераар бичлэг хийх, засах software-р зурагийн засварын суурь аргыг сурна. Мөн, мэдээлэл цуглуулах, цэгцлэх, дүрсэн бүтээл болгон нэгтгэх чадварыг хөгжүүлнэ. Богино хэмжээний видео бүтээлээр дамжуулан, дүрсэн бүтээлээр илэрхийлэх аргын онцлог болон загварын талаар суралцана.

Аялал жуулчлалын мэдээллийн дүн шинжилгээ

Аялал жуулчлалын мэдээллийг шинжлэх, үнэлэх үндсэн суурь онол, ур чадварыг эзэмшдэг. Тухайлбал, аялал жуулчлалын бодит мэдээллийг ашиглан өгөгдөл цуглуулах, боловсруулалт, кластеринг, ангилал, таамаглал, цаг хугацааны цуврал анализ гэх мэт өгөгдөлд дүн шинжилгээ хийх үндсэн онол, ур чадварыг эзэмшдэг.

Онцгой дүрслэлийн арга

Дүрс илэрхийлэлд хэрэглэгддэг харааны онцгой эффектийн онол болон хишээний талаар танилцуулж, өөрийн бичсэн видео дүрсийг бүтээл болгох үед, засах software (Adobe Premier гэх мэт)-г хэрэглэн үр дүнтэй дүрслэлийн аргыг бодит дадлагаар сурна.

IT-ийн аялал жуулчлалын үүнзгийрүүлсэн сэдвүүд

Оюутнууд Японы аялал жуулчлалын салбарын хөгжил, бодлого, төлөвлөлт, хүний нөөцийн хөгжил, маркетинг гэх мэт ерөнхий ойлголтуудаас эхлэхэд аялал жуулчлалын салбарт тулгамдаж буй асуудалд дүн шинжилгээ хийх замаар аялал жуулчлалын IT-д суралцдаг. Энэ хичээлд хамрагдсан хүмүүс IT ашиглан аялал жуулчлалыг дэмжих замаар бүс нутгийн хөгжлийг хангах аргуудыг авч үзэх, санал болгох чадвар эзэмшинэ.

Аниме төлөвлөлт, бүтээлт, сурталчилгааны тусгай онол

Японы аниме салбарын бизнес, технологи, бүтээлт, гадаад орон дахь стратеги, хэрэгцээт хүний нөөц гэсэн, салбарын нөхцөл байдалд хамаарагдсан янз бүрийн сэдэвийн талаар танилцуулж, технологийн хөгжилөөр аж үйлдвэрийн бүтээцийн өөрчлөлтийн талаар дурдна. Мөн зохиогчын эрхийн хуульд хамаарагдах олон төрлийн асуудал, цаашлаад интернэтийн тархалтаас үүдэлтэй контент үйлдвэрлэлийн стратеги гэх мэтийг авч үзнэ.

Аялал жуулчлалын төлөвлөлт

IT-ийг ашиглан "шинэ аялал жуулчлал"-ыг хэрхэн төлөвлөх талаар судална. Оюутнууд онол, кейс судалгаа, хэлэлцүүлэг зэргээр дамжуулан аялал жуулчлалын үйл ажиллагааны маркетингийн арга барилд суралцана. Мөн аялал жуулчлалын бизнес эрхлэхэд зориулж аялал жуулчлалын төлөвлөгөө гаргах зорилгоор хээрийн судалгааны ажил гүйцэтгэнэ.

Өгөгдлийн шинжлэх ухаан

Мэдээллийн шинжлэх ухааны давуу тал нь мэдээлэл боловсруулах, статистик, програмчлал болон мэдээллийн шинжлэх ухааны бусад салбарыг ойлгож чадварлаг, ур дүнтэй ашиглах чадвар юм. Бид R програмчлалын хэлний танилцуулгаас эхлэх бөгөөд энэ нь анхаарал татсан өгөгдлийн шинжлэх ухааныг сурах хэрэгсэл болох юм. Үүний дараа бид практик судалгаанд анхаарлаа төвлөрүүлж, ангилал, регресс, таамаглалын тест зэрэг статистик болон олон хувьсагчийн шинжилгээнд шаардлагатай янз бүрийн арга техникийг суралцана.

IT-ийн аялал жуулчлалын дадлага

Энэхүү хичээлийн зорилго нь аялал, зочид буудал, агаарын тээврийн үйлчилгээний салбар гэх мэт аялал жуулчлалтай холбоотой салбаруудын талаар олж авсан мэдлэг чадвараа бататтахад оршино. Японд болон хилийн чанадад дадлага хийх болон ажил эрхэлснээр оюутнууд IT ашиглан ажил үүргээ гүйцэтгэх, аялал жуулчлалын бизнест шинэ карьер эхлүүлэхэд шаардагдах мэдлэг болон практик ур чадвар эзэмшинэ.

Бизнес экономик 1

Энэ хичээлээр микро эдийн засгийн онолын үндсийг авч үзнэ. Үйлдвэрлэгчийн нийлүүлэлт ба хэрэглэгчийн эрэлт хэрэгцээ хоорондох харилцан хамаарал, зах зээлийн механизм ямар ямар холбоотой болохыг судална.

Олон улсын хүний нөөцийн хөгжил

Олон улсын хүний нөөцийг хөгжүүлэх зорилгоор сэдэвчилсэн олон сэдвүүдийг хэлэлцэж, өргөн хүрээний ойлголтыг гүнзгийрүүлдэг. Японыг аялал жуулчлалын зориулалтаар ашиглахын тулд дотоодын эрэлт хэрэгцээ өсөхийн хэрээр дотоодын зах зээлд ажиллах боловсон хүчний ур чадварыг хөгжүүлэх шаардлагатай байгаа туул, аялал жуулчлалын ажилтнуудын бодит эрэлт хэрэгцээг судлан, боловсон хүчний баазыг хөгжүүлэх талаар суралцдаг.

Брэнд бүтээх болон бизнесийн удирдлага

Энэ хичээл дээр оюутнууд брэнд бүтээх болон менежментийн онолыг судлах ба брэндийн маркетинг, брэндийн менежмент гэх мэт компаниудын брэндийн үнэ цэнийг нэмэгдүүлэх стратегид суралцдаг. Энэ хичээлийн зорилго нь хувиараа бизнес эрхлэгчийн хувиар брэнд бий болгох ур чадвар эзэмшүүлэхэд оршино.

Гар утасны аппликэйшн хөгжүүлэх

Энэ хичээлээр оюутнууд Java програмчлалын хэлийг ашиглан ерөнхийдөө ухаалаг гар утсанд өргөнөөр хэрэглэгддэг үйлдлийн систем болох Android програмд тохирсон аппликэйшн хөгжүүлнэ. Үг зорилгын хүрээнд оюутнууд Java-ийн талаар суурь мэдлэгтэй болж, Android API болон Android зохион бүтээх хэв маяг, хамрах хүрээг судална.

◆ Хиймэл оюун ухаан

Энэхүү хөтөлбөрт хамрагдаж буй оюутнууд олон янзын чиглэлээр хийсэн кейс судлагаагаар дамжуулан хиймэл оюун ухаан, түүнтэй холбоотой технологийн үндсэн онол, хэрэглээний талаар суралцана. Оюутнууд хиймэл оюун ухаантай холбоотой програм хангамжийн талаар мэдлэгтэй болсноор олон олон салбаруудад хиймэл оюун ухааныг ашиглаж, хэрэгжүүлэх боломжтой болно.

IT-ийн статистик

Өнөөдрийн дэвшилтэт мэдээллийн технологийн ертөнц дээр статистик нь цуглуулсан мэдээллийг ашиглан нийгэм болон эдийн засаг дахь учир шалтгаан ба үр дагаврын харилцан хамаарлыг шинжлэх, авч үзэхэд чухал үүрэг гүйцэтгэж байна. Энэ хичээлээр оюутнууд статистикийн үндсэн ойлголт, арга зүйд суралцаж, тодорхой жишээг ашиглан статистик дүн шинжилгээ хийхэд шаардлагатай суурь мэдлэг, ур чадварыг эзэмшинэ.

Хиймэл оюун ухааны талаарх танилцуулга хичээл

Энэхүү хичээлээр “Хиймэл оюун ухаан гэж юу вэ?” гэсэн асуултын хариултыг олж авах болно. Үүний тулд хиймэл оюун ухааны тодорхойлолт, хиймэл оюун ухааны судалгааны түүх, автомат төхөөрөмжийн үндсэн онолын талаар суралцах, хиймэл оюун ухааны бусад талууд, хиймэл оюун ухааны өнөөгийн асуудлууд, хиймэл оюун ухааныг ашиглах ёс зүй зэрэг ойлголтуудын шаардлагатай асуудлуудын талаар суралцана.

Алгоритмын талаарх танилцуулга хичээл

Оюутнууд Жава програмчлалын хэл дээр алгоритм хэрхэн бичих талаар сурсны дараа, Жава програмыг компьютер дээр ажиллуулж, зориулалтын дагуу ажиллуулж байгаагаа баталгаажуулна. Мөн Java дэр тайлбарласан алгоритмуудыг үйлдлийн дарааллын график, хуурамч хэл зэрэг ерөнхий зориулалтын дүрслэх формат болгон хөрвүүлэх аргад суралцах болно.

Компьютерийн програмчлал (Python)

Python програмчлалын хэл нь хиймэл оюун ухааны боловсруулалтанд оновчтой хэд хэдэн онцлог шинж чанартай байдаг. Жишээлбэл, өргөн цар хүрээтэй номын сантай гэх мэт. Оюутнууд энэхүү хичээлээр Python-ийн дүрмийг судалж, Python хэл дээр програмчлах шаардлагатай чадварыг эзэмшинэ.

Мэдээллийн сангийн ерөнхий онол

Аль ч салбарт хэрэгтэй, мэдээллийн сангийн суурь болон янз бүрийн компанийн үйл ажиллагаанд ашиглагдах аргыг ойлгож, өгөгдлийн тодорхойлолтын аргачлал болон өгөгдлийн удирдлагийн талаар сурах.

Компютерын бүтэцийн онол

Мэдээллийн систем бүтээх болон ашиглахад хэрэгтэй, вэб бизнес технолог дахь, эсвэл вэб бизнес системийн боловсруулалтын үндэс суурь болох тооцоолох системийн техник хангамж, програм хангамж аль аль талын суурь мэдлэгийг сурч авах.

Хэрэглээний мэдээлэл зүйн суурь математик

Энэхүү хичээлийг үзэж буй оюутнууд математикаар логик сэтгэлгээний чадварыг эзэмших ба ирж буй хиймэл оюун ухааны эрин үед мэдээллийн технологийг ашиглахад шаардагдах мэдлэг чадварыг эзэмшинэ. Хичээл суурь мэдлэг олгохоос эхлэх ба зарим үр ашигтай арга хэрэглүүдийг авч үзэх болно.

Төхөөрөмж суралцах

Төхөөрөмж суралцахын суурь арга бодож, тодорхойлотыг сурах, тооцоолох арга, гурван давхарт neural network, гүн давхаргуудын талаар, суралцах бүтэц болон алгоритмыг танилцуулан, С эсвэл Java хэлээр хялбар програмчлалын уншиж тайлахтай хамт ойлголтоо гүнзгийрүүлнэ.

Комбинаторын оновчлол

Оновчлолын асуудал гэдэг нь тодорхой хуваарилагдсан нөхцөлд зорилтот коэффициентийг багасгахыг эрмэлздэг асуудлын нэг хэлбэр юм. Оновчлолын асуудлын сонгодог жишээ бол "аялагч борлуулагчийн асуудал" юм. Борлуулагч нь хуваарилагдсан хотуудад тус бүрт ганц удаа очих хамгийн богино замыг олох ёстой. Ингэх явцад маш олон оновчлолын асуудлууд гарч ирэх болно. Тиймээс энэхүү хичээлээр дажуулан сүлжээний оновчлолын ерөнхий асуудал тухайлбал, аяллын борлуулагчийн асуудлыг хэрхэн шийдэж болох талаар заах юм.

Хиймэл оюун ухаан програм хангамжийн програмууд 1, 2

Хиймэл оюун ухаан 1-н програм хангамжийн програмд, оюутнууд Python програмчлалын хэлний санг ашиглан автомат машины талаарх янз бүрийн ашиглах арга техникүүд болон ерөнхий үндсийн талаар суралцана. Хиймэл оюун ухаан 2-н програм хангамжийн програмд, оюутнууд Python ашиглан төв сүлжээний гол бүрэлдэхүүн хэсгүүдийг холбож ажиллуулах бөгөөд дотоод боловсруулалтыг нь ойлгохын тулд Python номын сангаас олж авсан үр дүнтэй харьцуулалт хийнэ. Энэхүү сургалт нь Python номын санг ашиглан эвдэрсэн төв сүлжээг хэрхэн ажиллуулахыг заах бөгөөд дээрх аргуудын талаар ерөнхий ойлголттой болно.

Өгөгдлийн олборлолт

Өгөгдлийн олборлолт (DM) нь асар их хэмжээний өгөгдөлд нуугдаж буй дүрмийг (мэдлэг) олж илрүүлэх, олборлох, асар их хэмжээний эмх замбараагүй мэдээллийг ангилах явдал юм. Энэхүү хичээлээр өгөгдлийн олборлолтод ашиглах боломжтой төрөл бүрийн аргууд, холбогдох алгоритмууд болон тэдгээрийн хэрэглэхэд тохиромжтой байдал, хэрэглээг тайлбарлах зэрэг, өөр өөр форматтай байж болох өгөгдөлдлийн олборлолтод зориулсан хэрэгсэл, аргуудыг тодорхойлдог. Мөн оюутнуудад өгөгдөл олборлолтийн арга, хэрэгслийг ашиглах чадварыг олгоход оршино.

Мэдээллийн сангийн хяналтын тусгай онол

Үр дүнтэй вэб бизнес хэрэгжүүлэхэд шаардлагатай өндөр чанар, өндөр чадвартай мэдээллийн сан болон систем бүтээхийн тулд, мэдээллийн сангийн суурь онолоос, бодит мэдээллийн санг ашиглах төрөл бүрийн аргачлалыг, дадлагын хичээлээр сурна.

Тоглоом ба хиймэл оюун ухаан

Шатар, шоги, Го зэрэг тоглоомуудаар дамжуулан хиймэл оюун ухааныг хэрэглэж ирсэн олон жилийн түүхтэй. Энэ хугацаанд тоглоомын онол, хайлтын онолын чиглэлээр өргөн цар хүрээтэй судалгааны ажил, боловсруулалт зэрэг үргэлжлэн хийгдсээр байна. Go-н дэлхийн шилдэг тоглогчдыг ялж дэлхийг цочирдуулсан AlphaGo програмын жишээнээс суралцаж, Монте Карлогийн модны эрэл, бэхлэлтийг сурах зэрэг арга техникийг хэрхэн хослуулж, тоглоомын дараагийн нүүдлийн стратегийг боловсруулах талаар заах болно.

Төрөлх хэлийг ойлгох / Дуу хоолойгоор ойлгох

Хиймэл оюун ухааны үндсэн технологиуд болох төрөлх хэлийг ойлгох, дуу хоолойгоор ойлгох (таних), дүрсийг ойлгох (хэв загварыг таних) зэрэг нь олон жилийн түүхтэй бөгөөд тус бүр дээр нь өргөн цар хүрээтэй судалгаа, боловсруулалт хийгджээ. Эдгээр төлөөлөх програмууд нь харилцан адилгүй байдаг. Үүнд: автомат орчуулга, хийсвэрлэл, стенографийн бичлэгийн эмхэтгэл, утасны орчуулга, роботуудтай харилцан ярилцах зэрэг орно. Сүүлийн жилүүдэд гүнзгийрүүлэн суралцах нь хиймэл оюун ухааны үндсэн технологи болох гол үүрэг гүйцэтгэж байна.

Эмчилгээний тэргүүлэх мэдээлэл судлал

Эмнэлгийн хиймэл оюун ухааны талаархи судалгаа нь сүүлийн жилүүдэд дэлхий даяар маш хурдацтай явагдаж байгаа бөгөөд хиймэл оюун ухаан нь эмнэлгийн оношлогоо, эмнэлгийн дүрсний оношлогоо, бусад хэрэглээний технологийг боловсруулахад ашиглагдаж байна. Мөн практик хэрэглээний програмууд гарч ирж байна. Дараагийн хэдэн жилийн хугацаанд өвчний оношийг тодорхойлох зорилгоор хиймэл оюун ухааныг ашигладаг системүүдийг дэлхий даяар ашиглах төлөвтэй байна. Энэ хичээлээр оюутнууд хиймэл оюун ухааны үндсийг сурах; эмнэлгийн тохиолдлын оношлогоонд хиймэл оюун ухааныг хэрэглэх аргыг судлах, тодорхой судалгаанд үндэслэн судлах; эрүүл мэндийн салбарт (эмнэлгийн хиймэл оюун ухаан) хиймэл оюун ухааны бусад хэрэглээг судлах зэрэг заагдана.

Робот техник ба хиймэл оюун ухаан

Роботууд нь механикжуулалт, электроникийн нэгдэл болж, автомашин үйлдвэрлэх болон угсрахад ашигладаг үйлдвэрлэлийн роботууд болжээ. Өнөөдөр роботууд гэрийн ажил, асрамж, хүлээн авалт, бүтээгдэхүүний мэдээлэл, агуулах (бараа материалын) менежмент, оффисын тогтмол процесс (роботын процессын автоматжуулалт: RPA) гэх мэт өргөн хэрэглээний програмуудаар төрөлжүүлж байна. Энэ хичээлээр оюутнууд роботыг бусад салбарт хэрхэн ашиглаж байгааг судалж үздэг.

Өгөгдлийн шинжлэх ухаан

Мэдээллийн шинжлэх ухааны давуу тал нь мэдээлэл боловсруулах, статистик, програмчлал болон мэдээллийн шинжлэх ухааны бусад салбарыг ойлгож чадварлаг, үр дүнтэй ашиглах чадвар юм. Бид R програмчлалын хэлний танилцуулгаас эхлэх бөгөөд энэ нь анхаарал татсан өгөгдлийн шинжлэх ухааныг сурах хэрэгсэл болох юм. Үүний дараа бид практик судалгаанд анхаарлаа төвлөрүүлж, ангилал, регресс, таамаглалын тест зэрэг статистик болон хувьсагчийн шинжилгээнд шаардлагатай янз бүрийн арга техникийг суралцана.

Нийгэм ба Хиймэл оюун ухаан 1, 2

Хиймэл оюун ухааны технологи нь нийгмийн тогтолцоонд эрс өөрчлөлт хийх шатандаа явж байна. Эдгээр технологи нь бусад бизнесийн салбарт өргөн хэрэглэгддэг. Нийгэм ба хиймэл оюун ухаан 1-д оюутнууд GPS-тэй уялдуулан автоматжуулсан жолоодлого, нийтийн болон бусад байгууламжийн аюулгүй байдлыг сайжруулах зорилгоор нүүр царай таних чадварыг ашиглах, хүргэх үйлчилгээнд дрон ашиглах зэрэг кейс судалгаанд анхаарлаа төвлөрүүлдэг. Нийгэм ба хиймэл оюун ухаан 2-т оюутнууд хиймэл оюун ухааны өнөөгийн байдал, ирээдүйн төлөв байдлын талаар ярилцдаг. Оюутнууд санхүүгийн үйлчилгээ (финтек), дараагийн үеийн хөдөө аж ахуйн менежмент, IoT ашиглан ухаалаг байшин, хот байгуулах зэрэг жишээн дээр хиймэл оюун ухааныг хэрхэн хэрэгжүүлж, бизнесийн ертөнцийг өөрчилж буй арга хэлбэрийг судалж үздэг.

Компьютерийн програмчлал (Java)

Хэрэглээний хиймэл оюун ухаанд ашигладаг янз бүрийн алгоритмуудыг ойлгон шинэ алгоритмууд зохиож, програмчлан туршиж үзэхийн тулд янз бүрийн өгөгдлийн бүтцийг удирдах чадвартай програмчлалын хэлийг судлах шаардлагатай. Энэхүү хичээлээр хиймэл оюун ухааны зориулалтын талбайн "хоёр дахь хэл" гэж тооцогддог Java-г судална.

Хиймэл оюун ухааны математик

Энэ хичээл дээр оюутнууд гүнзгийрүүлсэн сургалтын алгоритмыг ээмшихэд шаардагдах математикийн үндсэн ойлголтуудыг судлахаас гадна математик аргачлал, коэффициент, модель бүтээх арга зүй, сургалтын алгоритм, Python хэл дээрх кодчилол, шугаман регрессийн сургалтын дүрэм, нэг утга, олон талт утга болон бусад сургалтын дүрэм, алдаа тархах арга замуудад суралцана.

Үйлдвэрийн салбарын хичээл

Эдгээр хичээл нь тодорхой салбаруудад мэргэжлийн мэдлэг, арга техникийг практикт ашиглаж сургах зорилготой. Багц хичээл тус бүрийг тодорхой салбар болон бизнесийн онцлогт суурилан явуулдаг.

Банк санхүүгийн онол

Банк санхүү болон рискний шилжилт, итгэл бий болгох, төлбөр гэх мэт, банк санхүүгийн үүрэг болон үйл ажиллагаанд гол болгон бизнесийн талаас бодон, бизнес, хэрэгцээг дагасан банк санхүүгийн ажлыг төлөвлөх боломж болгоно. Мөн, өндөр насжилт, өөрийн үүрэг хариуцлагын нийгэм дэх өөрчлөлтийг даган, шинээр хэрэгтэй болох банк санхүүгийн мэдлэгийг эзэмшинэ.

FinTech онол

Мөнгөний салбар (банк, үнэт цаас, даатгал г.м)-н эдийн засгийн гүйцэтгэх үүрэг болон бүтээгдэхүүн, үйлчилгээний талаар дүгнэж, тэдгээрийн мэдээллийг хянахын тулд аж ахуй нэгж доторх болон үйлчлүүлэгчид хандсан мэдээллийн системийн агуулах ёстой үйлдлийг бодож дүгнэнэ. Хамгийн тэргүүлэх мөнгөний бодлого болон application-н жишээг танилцуулна.

FinTech системийн загварчлал

Мөнгөний мэдээллийн системийн талаар шаардагдах хамгаалалт болон API түгээлтийн талаар бодит жишээг авч үзэнгээ ярилцана. Мөн, Blockchain болон cloud үйлчилгээ зэрэг шинэ технологи нь мөнгөний мэдээллийн системд авчрах өөрчлөлтийн талаар нарийн бодож дүгнэнэ.

Дараа үеийн хөдөө аж ахуйн мэдээлэл судлал

Эртнээс ирсэн хөдөө аж ахуйн хэлбэр болон бусад төрлийн үйлдвэрлэлтэй synergy (давхар үр нөлөө)-р бий болох дараагийн үеийн хөдөө аж ахуй (Smart Agriculture) нь анхаарал татагдаж байна. Зөвхөн ногооны ургац биш, тээвэрлэлт борлуулалтанд ч шинэ хэв маягийн "хөдөө аж ахуй" бий болсон бөгөөд, үүний төвд IT нь гүнзгий оролцож байгаа. Энэ ойлголт болон жишээнүүдийг хичээл дээрээ үзнэ.

Хөдөө аж ахуйн эдийн засаг судлал

Хөдөө аж ахуйн хөдлөдааны чөлөөлт болон, хөгжиж буй орнуудын хоол хүнсний хомсдолын асуудлийн дунд, хөдөө аж ахуйн тулгарч буй эдийн засгийн асуудлын талаар үзнэ. Менежмент, улс төр, хууль гэх мэтийг хөдөө аж ахуйтай холбож ойлгон, хүнсний үйлдвэрлэгчдээс хэрэглэгч хүртэлх урсгалын талаар суралцна.

Хөдөө аж ахуйн мэдээллийн системийн загварчлал

Сайн чанарын хөдөө аж ахуйн бүтээгдэхүүнийг тогтвортой нийлүүлэхийн тулд газар тариалангийн байгаль орчний мэдээлэл болон зах зээлийн түгээх хэмжээ зэргийн мэдээллийг цуглуулж дүн шинжилгээ хийн үйлдвэрлэгч болон хэрэглэгчдийн мэдээллийн системийн дизайн, загвар дэвшилийн талаар нийтэд нь хийж болно.

Далайн үйлвэрлэлийн онол

Хүргэлт, усны аж ахуй, чөлөөт цаг гэх мэт далайн үйлвэрлэлийн эдийн засаг, менежментийн тал дээр бодож, бизнес загварын онцлог шинж чанарыг илүү сайн ойлгох болно.

Далай мэдээллийн системийн загварчлал

Sonar, GPS, байгаль орчны төрөл бүрийн мэдрэгчээс мэдээлэл авч, хөлөг онгоцын жолооны удирдлага болон аж ахуйн байгаль орчны хянлтанд ашиглаж болох далайн үйлдвэрлэлд хандсан мэдээллийн системийн загварчлал болон prototype бүтээх зэргийг гүйцэтгэнэ.

Эмчилгээний тэргүүлэх мэдээлэл судлал

Эмнэлгийн хиймэл оюун ухааны талаархи судалгаа нь сүүлийн жилүүдэд дэлхий даяар маш хурдацтай явагдаж байгаа бөгөөд хиймэл оюун ухаан нь эмнэлгийн оношлогоо, эмнэлгийн дүрсний оношлогоо, бусад хэрэглээний технологийг боловсруулахад ашиглагдаж байна. Мөн практик хэрэглээний програмууд гарч ирж байна. Дараагийн хэдэн жилийн хугацаанд өвчний оношийг тодорхойлох зорилгоор хиймэл оюун ухааныг ашигладаг системүүдийг дэлхий даяар ашиглах төлөвтэй байна. Энэ хичээлээр оюутнууд хиймэл оюун ухааны үндсийг сурах; эмнэлгийн тохиолдлын оношлогоонд хиймэл оюун ухааныг хэрэглэх аргыг судлах, тодорхой судалгаанд үндэслэн судлах; эрүүл мэндийн салбарт (эмнэлгийн хиймэл оюун ухаан) хиймэл оюун ухааны бусад хэрэглээг судлах зэрэг заагдана.

Эмчилгээний мэдээлэлийн системийн төлөвлөгөө

Эмнэлэгийн мэдээллийн системийг бий болгоход чиглэн, өвчтөний өвчний тохиолдол болон эм зэргийн талаархи мэдээллийг зай авах тохирсон загварчлал болон, тэдгээрийн database дэхь удирдах арга зэргийг бодитоор суралцана.

Бүтээлч үйлдвэрлэлийн салбар дахь тусгай сэдвүүд

Оюутнууд Японы контент үйлдвэрлэлийн салбарын хоёр онцлог шинж чанаруудын талаар сурч мэдэх болно. Үүнд: 1. фэнүүд болон контент үйлдвэрлэх баялаг уламжлалаар хооллодог бүтээлч нэр дэвшигчдийн бүлэг; жижиг хэмжээний гарчиг, фен сэтгүүлийг янз бүрийн төрөл, жанраар худалдаж авдаг боловсорч гүйцсэн баазаас зах зээлийнхээ дэмжлэгийг авдаг бүлэг. Энэхүү хичээл нь тэдгээр ертөнцийг аниме үйлдвэртэй хэрхэн холбох арга замын талаар заах болно.

Дуу хөгжим болон технологи

Энэ хичээл дээр, нэг дуунд ч гэсэн, тэр үеийн технологи болон бизнесийн төрөл төрлийн элементүүд нэгдмэлээр хамаарагдаж байгаар ойлгож, тэдгээрийг эргэж харахын зэрэгцээ, одооны дуу хөгжимтэй хамт байгаа амьдралын хэв маягийг хайна.

Тайзны урлаг ба IT

Тайзны урлаг болон концерт бэлтгэх, бэлтгэл, болох өдөр гэсэн дараалийн үед, ICT хэрхэн хэрэглэгдэж биер туршлагажин нилэнхүйд нь суралцаж ойлгоно. Мөн, дүрс зурганд дуу хоолой хавсаргахын тулд дуу хоолойн талаар лекц болон дадлага хийж, дуу хоолойн талаархи дээр ойлголтоо гүнзгийрүүлнэ.

Контент, промошн стратеги

Нийгэмд янз бүрийн барааны худалдаа болон үйлчилгээг хурдасгах комтент дүүрэн байгаа боловч, хэрэглэгчийг хэрхэн тухайн контент руу очуулах талаар стратеги хэрэгтэй. Энэ лекцээр, веб хуудас болон SNS зэргийн контентээр дамжуулан үйл ажиллагааны промошн хийж, үр дүнг харч, анализ хийнэ.

еСургалтын системийн ерөнхий онол

еСургалтын системийн дэд бүтэц болон боловсролын үр нөлөөг хэмжих зэрэг, олон тооны жишээг танилцуулна. Янз бүрийн анализ аргыг суралцан сайжруулах тал дээр санаа дэвшүүлж чадахаар болно.

еСургалт бизнесийн зааварчилгаа болон дизайн

еСургалт системийг бүтээхэд хэрэгтэй зааварчилгаа болон дизайний талаар суралцаж, түүнийг ашигласан цахим еСургалтын системийн загварыг хэрэгжүүлнэ. Мөн, бизнесийг төлөвлөхөд хэрэгтэй мэдлэгийг сурна.

Цахим сургалтын сурах бичиг бүтээх

Бичлэг голлосон цахим сургалтын материал бүтээх талаар, олон талт салбар дахь тэргүүлэх жишээ болон хэрэглэх жишээг сурахтай хамт, бодит бүтээх орчинг ашиглан грүп төсөл байдлаар лекц/дадлагаар дамжуулан сурах бичиг бүтээх аргыг эзэмшинэ.

Номын сангийн мэдээлэл зүй

Номын сан бол бидний өдөр тутмын амьдралд хамгийн ойрхон олон нийтийн байгууламж юм. Саяхан номын сан нь мэдээллийн хайлтын систем, өөрийн болон бусад номын сангуудын архиваас хайх гэх мэтчилэн мэдээллийн технологийн хувьд маш их хөгжиж буй байгууламж юм. 1) Японы номын сангийн үйлчилгээ, 2) Бодит нийгэмд тус нэмэр болох мэдээллийн хайлтын технологи 3) Насан туршдаа суралцах, асуудал шийдэхийг дэмжих үйлчилгээ гэх мэт номын сангийн ирээдүйн боломж бололцоог судлана.

Сургууль болон корпорацийн боловсролыг олон улстай харьцуулсан судалгаа

Хөдөлмөрийн зах зээл, түүний чиг хандлагын талаар ойлголттой болох, ирээдүйд шаардагдах ур чадварын төрлийг ойлгох, үндэсний, ажлын байр, сургууль, хувь хүний түвшинд өөрчлөгдөж буй бодит байдалд хариу өгөх боломжийг тодруулна. Корпорацийн мэргэжил дээшлүүлэх сургалтыг хариуцаж буй хүнд шаардлагатай мэдлэг олж авна.

Дагалдах сонгон судлах хичээл

Дагалдах сонгон судлах хичээл нь мэргэжлийн чиглэл болон салбараас үл хамааран бизнес эрхлэгч хүн бүрт шаардагдах харилцаа холбоо, менежмент болон бусад суурь ур чадваруудыг эзэмшүүлэх хичээлүүдээс гадна IT-ын кейс судлагаа, технологийн чиг хандлагын талаарх хичээлүүдээс бүрддэг. Эдгээр хичээлүүдээр IT-г IT-н бизнесийн үндэс, хэрэглээний програмуудаас эхлээд олон янзын өнцгөөс авч үздэг бөгөөд энэ чиглэлээр оюутнуудад суурь салбарын.

Хэрэглээний мэдээлэл зүйн суурь математик

Энэхүү хичээлийг үзэж буй оюутнууд математикаар логик сэтгэлгээний чадварыг эзэмших ба ирж буй хиймэл оюун ухааны эрин үед мэдээллийн технологийг ашиглахад шаардагдах мэдлэг чадварыг эзэмшинэ. Хичээл суурь мэдлэг олгохоос эхлэх ба зарим ур ашигтай арга хэрэгслүүдийг авч үзэх болно.

IT-ийн статистик

Өгөгдрийн дэвшилтэт мэдээллийн технологийн ертөнц дээр статистик нь цуглуулсан мэдээллийг ашиглан нийгэм болон эдийн засаг дахь учир шалтгаан ба ур дагаврын харилцан хамаарлыг шинжлэх, авч үзэхэд чухал үүрэг гүйцэтгэж байна. Энэ хичээлээр оюутнууд статистикийн үндсэн ойлголт, арга зүйд суралцаж, тодорхой жишээг ашиглан статистик дүн шинжилгээ хийхэд шаардлагатай суурь мэдлэг, ур чадварыг эзэмшинэ.

Технологийн харилцаа холбоо

ICT нийгмийн хувьсалтай хамт, илүү өндөр төвшиний бизнесийн япон хэл мэддэг хүний нөөц эрэлхийлэгдэж байгаа. Бизнест, бууруу ойлголцолгүй мэдээлэл болон үзэл бодол, санаагаа ойлгуулах шаардлагатай. Үүний тулд үгэз сонгох, ярих, бизнесийн бичиг баримт зэрэгийг бичих арга, илтгэл тавих чадварыг эзэмшинэ.

Бизнес илтгэл

Өнөө үед, янз бүрийн төсөл саналыг бусдад хүргэхийн тулд илтгэл тавих чадвар ихээхэн шаардагддаг. Үгний сонголт болон ярих арга, үг үсгийн сонголтоос зурвасны өгүүлбэр, дүрс бичлэг болон дуу хөгжим, мэргэжлийн программ ашигласан слайд хийх зэрэг, илтгэл тавих үед тэдгээрийг ур дүнтэй ашиглаж сурна.

Бизнесийн харилцаа холбоо 1, 2

Эдгээр хичээлийн зорилго нь оюутнуудын Японы бизнесийн талаарх мэдлэг болон харилцааны ур чадварыг сайжруулахад оршино. Бизнесийн нөхцөл байдалд өргөн хэрэглэгддэг хэллэгүүдийг түлхүү анхаарч, Япон дахь бизнесийн ёс зүй, нөхцөл байдал талаар бизнесийн Япон хэл заадаг.

Логикоор бодох

Бүтээлт, хувьсалт байгууллагат явагддаг логик бодлын ойлголт, суурь бодож арга, төрөл бүрийн хэрэгсэлийг лекц болон жишээ, сургалтаар дамжуулан ойлгож, бүтээж чадварыг бий болгоно. Логикоор бодохыг хэрэглэсэн асуудлыг шийдвэрлэх багаар гүйцэтгэж, асуудал шийдэх чадвар, хялбарчлах чадвар, тайлбарлах чадварыг хөгжүүлнэ.

Медиа харилцаа

Янз бүрийн нийгмийн асуудалыг ICT-д суурилсан харилцаагаар дамжуулан шийдэх талаар глобал хэрэгцээ ихэсч байгаагын улмаас, хамгийн сүүлийн дэвшилтэт медиа харилцааны технологийг ур дүнтэй ашиглаж, асуудлыг шийдэхэд нэмэр болох бодит мэдлэг болон онолыг эзэмшинэ.

Бизнесийн ICT

ICT-тэй холбоотой бизнес эрхлэгчид нь тус бүрийн эрхэлж буй хамааралтай салбарууд болон тус бүрт хэрэглэгддэг үйлдвэрлэлийн нэр томъёотой холбоотой мэдлэгтэй байх шаардлагатай тулгарах нь гарцаагүй. Энэхүү хичээл нь өөрийгөө зөв япон хэлээр илэрхийлэх, үйлчлүүлэгчид эсвэл дотоддоо хэлэлцүүлэг хийхдээ өөрийн бодол санаог үр дүнд хүргэхэд шаардлагатай харилцааны ур чадварыг эзэмшүүлдэг.

Систем зохиох тусгай онол

Процессор, hardware-ын төлөвлөлтийг сэдэвлэн, системын нөөлтэд оролцох бэлтгэл болон бодох арга, нөөлтийн багийн нэг гишүүний үүрэг, төлөвлөлтөөс үзүүлэлтийн шийдэлээр дамжуулан загваржилт, нөөлтэд хүрэх шат бүрээр бодоход хэрэгтэй шаардлагатай нехцөл эзргийн талаар лекц уншина. Системийн нөөлтийн багийг ажиллуулах талаархи байдал болон, эдгээр компаний ерөнхий үйл ажиллагаа болон хамтарсан бүтээлийн сүүлийн үеийн байдлын талаар суралцана.

Системийн онолын тусгай онол

Удирдлагын салбар, эдийн засгийн салбар, технологийн салбарт үзэгдэх комплекс системийг дүн шинжилгээ хийх онол, практикийг суралцах. Ялангуяа, төрөл төрлийн эзэрээтэй бөгөөд нөхцөл байдал өрсөлдөөнт харилцаа агуулсан байдал үүссэн тохиолдолд, хийсвэр эсвэл бодит загвар дээр үндэслэн тохирсон дүгнэлтийг боломжтой болгох аргачилалын талаар суралцана.

Үйлдвэрлэлийн системийн инженерчлэл судлал

Үйлдвэрлэлийн салбарт, үйлдвэрлэл мэдээллийн урсгалаас компаний үйл ажиллагаат ойлгох нь чухал юм. Энэ хичээл дээр PLM-г оролцуулж, эрэлтэн таамаглал, үйлдвэрлэлийн төлөвлөгөө, үйлдвэрлэлийн хуваарь, тээвэрлэлтийн хяналт зэрэг аж ахуй нэгжийн үйл ажиллагааны стратеги төлөвлөлтөд хамаарах ойлголтыг мэдэж, түүнтэй холбоотой мэдээлэл, харилцаа холбооны технологийг суралцана.

Робот техникийн үйл явцын автоматжуулалт

Робот техникийн үйл явцын автоматжуулалт (RPA) –ын хувьд тухайн терминал дээр хүмүүсийн гүйцэтгэж байсан ажил, бүтээлүүдийг тухайн орчин (зааварт)-т шилжүүлэн хувиргах ба тухайн үйл ажиллагаат програм хангамжийн роботоор гүйцэтгүүлнэ. RPA-ыг хэрэгжүүлдэг компаниуд ажилчдын ажлын цагийг багасгаж, үйл ажиллагааны ур дүнтэй байдлаа дээшлүүлэх боломж бүрдэнэ. Энэхүү хичээлээр оюутнууд RPA-ын давуу талууд, хэрэгжүүлэх зорилго болон бодит RPA –д суурилан програм бичихэд суралцана.

Хэрэглээний мэдээлэл судлалын хамгийн тэргүүн A / B

ICT-н онолоос хэрэглээний салбар хүртэл, хамгийн сүүлийн үеийн мэдээллийг omnibus хэлбэрээр авч үзэн, хичээлийг явуулна. Тогтмол хувьсдаг IT салбарын сүүлийн үеийн чиг хандлагыг дамжуулж, төсөл дахь бүтээх зүйлийн зорилгтой холбогдоно гэж найдаж байна.

Ахисан шатны бизнесийн ICT

Бизнесийн мэдээлэл, харилцаа холбооны технологийн чиглэлээр олж авсан мэдлэг дээрээ тулгуурлан оюутнууд MXXT-ийн хамгийн сүүлийн үеийн сэдвүүд болон ICT-н бизнесийн өнөөгийн нөхцөл байдлыг хөндөх бөгөөд энэ нь бүтээгдэхүүн боловсруулах, төлөвлөх (төслийн санал) -ийг япон хэл дээр бэлдэх чадвартай болно.

Техникийн англи хэлний харилцааны ур чадвар

Дэлхий дахинаа болж буй хамгийн сүүлийн үеийн мэдээллийг ашиглах чадвар нь ICT-н ертөнцөд нэн чухал юм. Энэхүү хичээл нь оюутнуудад ICT болон ICT-н ажлын байранд ашиглах англи хэлний харилцааны ур чадварыг дээшлүүлэхэд чиглэгддэг. Оюутнууд ICT-н ажлын байранд тавигдах шаардлагууд болох илтгэл бэлдэх, илтгэл тавих, зэргээр технологийн үндсэн сэдвүүдийн талаар амаар ярих, англи хэл дээр бичгээр илэрхийлэх чадвартай болно.

Заавал суралцах хичээл

Эдгээр хичээлээр мэргэжилтнүүдэд шаардагдах харилцааны чадвар, ёс зүйн ухамсар болон байгууллагыг удирдах манлайллын ур чадварыг олгодог.

ICT бодит харилцаа

Янз бүрийн ICT салбарын технологийн сэдвийн талаар, мэргэжилтэн болон энгийн хүмүүст бичгээр болон амаар танилцуулах суурь чадварыг эзэмшинэ. Технологийн хандлага болон хамаатай жишээг судлах арга, өгүүлбэр болон танилцуулгын материалын локиг бүтэц зэргийг сурна.

Удирдлагын онол

Байнга хувьсан хөгжиж байдаг технологи болон иргэний нийгэм болон боловсролын өөрчлөлтийг мэдэж, байгууллагийн бүхэлд нь боловсруулах, хөгжүүлэх чадвар бүхий эзэмшсэн шинэ удирдагчын шинж чанар нь юу вэ гэдгийг бодно. Байгууллагын дотоод болон гадаад хүчин зүйлсийг анализ хийх аргыг анхаарч суралцаж, хамтын боловсрол, хөгжлийн тэргүүлэх дадлыг хийнэ.

Төслийн үндэслэл

Магистрийн төслийн ажил нь оюутны суралцах үйл явцын чухал хэсэг юм. Энэхүү ажлаар оюутнууд Магистрын төслийн ажил гүйцэтгэхэд шаардагдах материалыг судалж, дүн шинжилгээ хийж, дипломын ажил бичих арга зүйг заадаг. Гол зорилго нь хичээл дуусах үед оюутнууд өөрсдийн Магистрийн төслийн ажил бичих эрдэм шинжилгээний төлөвлөгөө гаргах чадвар олгоход оршино.

Мэргэшүүлэх чиглэлүүдийн хичээлийн аргачлал
(Санал болгож буй сургалтын хэлбэр)

Заавал суралцах хичээл | Үндсэн хичээл | Хэрэглээний хичээл | Суурь хичээл

◆ ERP

ERP-г сурч, ажилыг хамгийн тохиромжтой болгох консалтант болно.

Энэхүү концентраци нь аж ахуй нэгж дэхь IT-ийн систем оруулах болон тохиромжтой болгохыг дэмжих ERP консалтант болон ERP хувилбарын нэмэлт үйлдлийг загварчилж, бүтээх SE программ зэргийг сурахыг зорьж буй оюутанд зориулагдсан болно. SAP компанийн ERP багцын хэрэглээний хичээл (Санхүүгийн нягтлан бодох бүртгэлийн систем бүтээх 1, 2)-г сурснаар, ERP системыг шатлалтайгаар сурах боломжтой.

1-р семестр	2-р семестр	3-р семестр	4-р семестр
Аж ахуйн нэгжийн систем	Санхүүгийн нягтлан бодох бүртгэлийн систем бүтээх 1, 2	Борлуулалтын тэзвэрлэлтийн систем бүтээх 1, 2	ERP эвшилцлийн гүнгийрүүлсэн сэдвүүд
Ажлын нэгттэл болон еБизнес	ERP ажлын аппликешн бүтээх	Худалдан авах агуулахын систем бүтээх	Боловсон хүчин хянах систем бүтээх
Олон улсын санхүүгийн онол	Үйлдвэржилтийн хяналтын системийг хийх	Объект хандалтат программчлал	
Вэб програмчлал 1	Вэб програмчлал 2		
IT-ийн статистик	Мэдээллийн сангийн ерөнхий онол		
Хэрэглээний мэдээлэл зүйн суурь математик			
ICT бодит харилцаа	Төслийн үндэслэл		
Удирдлагын онола	Магистрийн төсөл		

Бусад мэргэшүүлэх хичээл, дадлагажих хичээл болон дагалдах сонгон судлах хичээлүүдээс сонгоно.

◆ Бизнес дата анализ

Бизнес датаг анализ хийж, аж ахуй нэгжийн шийдвэр гаргахад хэрэглэх аналист болно.

Энэхүү концентраци нь Data mining болон статистик анализ зэрэг аргыг хэрэглэн, бизнес датаг анализ хийж, аж ахуй нэгжийн стратеги санал, гүйцэтгэл зэргийг дэмжих аналист болох зорилготой оюутанд тохирно. “Мэдээллийн сангийн ерөнхий онол/тусгай онол”-р бизнес датаг хуримтлуулах аргыг, “Өгөгдлийн шинжлэх ухаан” “Төхөөрөмж суралцах” зэргээр хуримтлуулсан датагаас шинэ саналыг олж авах аргыг тус бүр сурна.

1-р семестр	2-р семестр	3-р семестр	4-р семестр
Компьютерийн програмчлал (Python)	Өгөгдлийн шинжлэх ухаан	Мэдээллийн сангийн хяналтын тусгай онол	Орчны мэдээлэл зүйн систем
Вэб бизнесийн ерөнхий онол	Төхөөрөмж суралцах	Хиймэл оюн ухаан програм хангамжийн програмууд 2	Зохион бүтээх сэтгэлгээ
Мэдээллийн сангийн ерөнхий онол	Мэдээлэл олборлолтын үндсэн онол	Үнэлгээ хийх дата анализ хийх арга	
Вэб програмчлал 1	Вэб програмчлал 2	Хайх дата анализ болон харагдахаар болгох	
Компьютерын бүтэцийн онол	Хиймэл оюн ухаан програм хангамжийн програмууд 1	Интернет бизнес стратеги, маркетинг	
IT-ийн статистик	Хиймэл оюун ухааны математик		
Хэрэглээний мэдээлэл зүйн суурь математик			
ICT бодит харилцаа	Төслийн үндэслэл		
Удирдлагын онола	Магистрийн төсөл		

Бусад мэргэшүүлэх хичээл, дадлагажих хичээл болон дагалдах сонгон судлах хичээлүүдээс сонгоно.

◆ Global entrepreneurship

ICT-г шинэ бизнест хэрэглэх бизнес эрхлэгч болно.

Энэхүү концентрацийн оюутан нь хүн болон хөрөнгө, мөн мэдээллийг төлөвлөгөөтэй хянаж, шинэ ажлыг эхлүүлэх сорилтыг хариуцдаг бизнес эрхлэгч болно. Аж ахуй нэгж байгуулахад чухал комапний төлөвлөгөө санал болгохыг “Global entrepreneurship болон бизнес загвар”-р, байгуулсны дараах санхүүг “ IT компани дадлагын онол”-р тус тус суралцана. Мөн, “Байгууллагын төлөв судлал”-р хүний бүлэг болох компани ажиллуулах аргын талаар сурна.

1-р семестр	2-р семестр	3-р семестр	4-р семестр
Бизнес экономик 1	Төсөл хянах аргачилал	Олон улсын хүний нөөцийн хөгжил	Тогтоомын онол болон хэлэлцээр
Бизнес экономик 2	Global entrepreneurship болон бизнес загвар	Интернет бизнес стратеги, маркетинг	Бизнесийн удирдлагын тусгай онол
Вэб бизнесийн ерөнхий онол	Бодит cloud компьютерчлал	еХудалдааны олон төрлийн арга барил	Хувиараа бизнес эрхлэгчдийн тухай шинэ хууль тогтоомж
IT-ийн статистик	Оюуны өмчийн эрхийн тухай хууль	Зохион бүтээх сэтгэлгээ	Тогтмол хөгжихийн төлөөх тэргүүлэх чадвар
Хэрэглээний мэдээлэл зүйн суурь математик	IT компани дадлагын онол	Аж ахуйн нэгжлийн менежментийн дадлагын онол	
Вэб програмчлал 1	Мэдээлэл ёс зүйн тусгай онол	Бренд загвар болон удирдлага	
	Байгууллагын төлөв судлал	IT Бизнесийн харилцаа судлал	
ICT бодит харилцаа	Төслийн үндэслэл		
Удирдлагын онола	Магистрийн төсөл		

Бусад мэргэшүүлэх хичээл, дадлагажих хичээл болон дагалдах сонгон судлах хичээлүүдээс сонгоно.

◆ Вэб систем бүтээх

HTML-г голлон вэб систем бүтээхийг сурна.

Вэб аппликешн бүтээх инженер болон веб хуудасны менежер болохын тулд, “Вэб програмчлал 1-3”-г сурч, бүтээх чадвараа сайжруулна. “Мэдээллийн сангийн ерөнхий онол / тусгай онол”-р, системийн дата хянах хэсгийг байгуулна. Дээр нь “Объект хандалтат системийн боловсруулалт” “ Программ хангамж инженерчлэлийн тусгай онол” зэрэг, өндөр төвшний төлөвлөлтийн талаар суралцах боломжтой.

1-р семестр	2-р семестр	3-р семестр	4-р семестр
Вэб технологийн ерөнхий онол	Вэб програмчлал 2	Вэб програмчлал 3	Программ хангамж инженерчлэлийн тусгай онол
Вэб бизнесийн ерөнхий онол	Объект хандалтат системийн боловсруулалт	Мэдээллийн сангийн хяналтын тусгай онол	Гар утасны аппликэйшн хөгжүүлэх
Вэб програмчлал 1	Компьютерийн програмчлал (Python)	Объект хандалтат программчлал	Вэб үйлчилгээ хийх арга
Компютерын бүтэцийн онол	Хиймэл оюун ухаан програм хангамжийн програмууд 1	Зохион бүтээх сэтгэлгээ	
IT-ийн статистик	Мэдээллийн сүлжээний ерөнхий онол		
Хэрэглээний мэдээлэл зүйн суурь математик			
Мэдээллийн сангийн ерөнхий онол			
ICT бодит харилцаа	Төслийн үндэслэл		
Удирдлагын онола	Магистрийн төсөл		

Бусад мэргэшүүлэх хичээл, дадлагажих хичээл болон дагалдах сонгон судлах хичээлүүдээс сонгоно.

◆ Сүлжээ хянах

Сүлжээ, дэд бүтэцийн технологи болон мэдээллийн аюулгүй байдлын мэргэжилтэн болно.

Энэхүү концентрацийн оюутан нь аж ахуй нэгж доторх сүлжээ болон сервер бүрийн хамгаалах, ажиллуулах инженер, аюулгүйн байдлын хянагч зэргийг агуулсан мэдээллийн сүлжээний мэргэжилтэн болно. Сүлжээний системийг “Мэдээллийн сүлжээний ерөнхий онол / тусгай онол”-р сурахын дээр, “IoT болон утасгүй сүлжээ” “Cloud сүлжээ болон цахимжилт” зэрэг шинэ технологийг эзэмшинэ.

1-р семестр	2-р семестр	3-р семестр	4-р семестр
Вэб технологийн ерөнхий онол	Мэдээллийн аюулгүй байдал	Мэдээлэл сүлжээний тусгай онол	IoT-ийн хэрэглээний систем
Компьютерийн програмчлал (Python)	Кибер аюулгүй байдал	IoT болон утасгүй сүлжээ	Cloud сүлжээ болон цахимжилт
Мэдээллийн сүлжээний ерөнхий онол	Хиймэл оюун ухаан програм хангамжийн програмууд 1	Сүлжээний системийн хяналт	Нарийвчилсан чиглүүлэлт ба шилжүүлэг
Хэрэглээний мэдээлэл зүйн суурь математик	Хувиараа бизнес архлэгчдийн тухай шинэ хууль тогтоомж	Нарийвчилсан чиглүүлэлт ба шилжүүлэг	Вэб үйлчилгээ хийх арга
Мэдээллийн сангийн ерөнхий онол	Мэдээлэл ёс зүйн тусгай онол		
Вэб програмчлал 1			
Компютерын бүтэцийн онол			
IT-ийн статистик			
ICT бодит харилцаа	Төслийн үндэслэл		
Удирдлагын онола	Магистрийн төсөл		

Бусад мэргэшүүлэх хичээл, дадлагажих хичээл болон дагалдах сонгон судлах хичээлүүдээс сонгоно.

◆ IT манга, анимэ

Анимэшн болон дүрслэл зэрэг контент бүтээх мэргэжилтэн болно.

Энэхүү концентрацийн оюутан нь манга болон анимэг голлосон контент бүтээх мэргэжилтэн болно. “Аниме төлөвлөлт, зохион бүтээлт, сурталчилгааны тусгай онол” “Scenario болон story bodying”-р манга, анимэ бүтээх дээд зэргийн процессыг, “Арвин хэвлэл мэдээллийн агуулга бүтээх” “Цахим анимешн бүтээх” зэргээр нарийн хэрэгсэл ашиглан цахим контент бүтээлийг тус тус суралцана.

1-р семестр	2-р семестр	3-р семестр	4-р семестр
Хэвлэл мэдээллийн арвин агуулга бүтээх	Цахим анимешн бүтээх	Компьютер график	Дижитал болон аудио үйлдвэрлэл
Анимэ бүтээх суурь А	Аниме төлөвлөлт, бүтээлт, сурталчилгааны тусгай онол	Дүрс бүтээх онол	Тусгай дэвшилтэт визуал эффект
Бүтээлч үйлдвэрлэлийн салбар дахь тусгай сэдвүүд	Scenario болон story bodying	Практикт Анимэ бүтээх	Тайзны урлаг ба IT
Вэб програмчлал 1	Визуал, Боловсруулалт	Онцгой дүрслэлийн арга	Бренд загвар болон удирдлага
Хэрэглээний мэдээлэл зүйн суурь математик	Анимэ бүтээх суурь В		
Компютерын бүтэцийн онол			
ICT бодит харилцаа	Төслийн үндэслэл		
Удирдлагын онола	Магистрийн төсөл		

Бусад мэргэшүүлэх хичээл, дадлагажих хичээл болон дагалдах сонгон судлах хичээлүүдээс сонгоно.

◆ IT-ийн аялал жуулчлал

Аялал жуулчлалын бизнес төлөвлөх, холбогдох системийг санал болгох чадвартай IT- аялал жуулчлалын мэргэжилтэн болох хүсэлтэй оюутнуудын хувьд.

IT-ийн аялал жуулчлалын чиглэлээр суралцаж буй оюутнууд бүс нутгийн онцлог шинж чанарт тулгуурлан аялал жуулчлалын нөөц, жуулчдын хэрэгцээнд нийцсэн маркетингийн стратеги боловсруулахдаа ICT ашиглаж чаддаг болно. “IT хослуулсан Аялал жуучлалын тойм”, “Аялал жуулчлалын бизнесийн тойма” зэрэг сургалтанд хамрагдсанаар, аялал жуулчлалын салбарт тохирсон үйл ажиллагааны мэдлэг, ур чадварыг эзэмшдэг.
“Аялал жуулчлалын мэдээллийн дүн шинжилгээ”, “Аялал жуулчлалын төлөвлөлт”, “Аялал жуулчлалын удирдлагын менежмент”ийн сургалтанд суралцах замаар SNS-н сүлжээг ашиглан сурталчлах, аялал жуулчлалын мэдээллийг олон хэл, хэвлэл мэдээллийн хэрэгслээр тараах, аялал жуулчлалын үйл ажиллагааны түүхийг өөгдөлд хөврүүлэх, дүн шинжилгээ хийх, урьдчилан таамаглах зэргээс суралцана.

1-р семестр	2-р семестр	3-р семестр	4-р семестр
Аялал жуулчлалын бизнесийн тойма	Аялал жуулчлалын төлөвлөлт	Аялал жуулчлалын удирдлагын менежмент	IT-ийн аялал жуулчлалын гүнзгийрүүлсэн сэдвүүд
IT хослуулсан Аялал жуучлалын тойм	Олон улсын хүний нөөцийн хөгжил	Аялал жуулчлалын мэдээллийн дүн шинжилгээ	IT-ийн аялал жуулчлалын дадлага
Төсөл хянах аргачлал	Вэб програмчлал 2	Объект хандалтат системийн боловсруулалт	Гар утасны аппликэйшн хөгжүүлэх
Японы нийгмийн талаарх ойлголт	Бизнес экономик 1	Өгөгдлийн шинжлэх ухаан	Гар утасны аппликэйшн хөгжүүлэх
Компьютерийн програмчлал (Python)	Медиа харилцаа	Аниме төлөвлөлт, бүтээлт, сурталчилгааны тусгай онол	Онцгой дүрслэлийн арга
Вэб програмчлал 1		Дүрс бүтээх онол	Бренд загвар болон удирдлага
IT-ийн статистик			
Хэрэглээний мэдээлэл зүйн суурь математик			
ICT бодит харилцаа	Төслийн үндэслэл		
Удирдлагын онола	Магистрийн төсөл		

Бусад мэргэшүүлэх хичээл, дадлагажих хичээл болон дагалдах сонгон судлах хичээлүүдээс сонгоно.

◆ Хиймэл оюун ухаан

Энэхүү хөтөлбөрт хамрагдаж буй оюутнууд хиймэл оюун ухааны тусламжтайгаар ирээдүйд хөгжих чадварыг олж авах, хиймэл оюун ухааны технологийг хиймэл оюун ухааны мэргэжилтэнтэй адил өргөн хүрээнд ашиглах зэргэгт суралцана.

Хиймэл оюун ухааны үндсэн онол ба холбогдох технологийг судалсны дараа, оюутнууд кейс судалгааг судалж, тэдгээр суурь онол, технологийг олон төрлийн хиймэл оюун ухааны хэрэглээний талбарт хэрхэн ашиглаж болох талаар мэдлэгтэй болно. Оюутнууд хиймэл оюун ухааны салбарт өргөн хэрэглэгддэг Python хэлийг судалж хиймэл оюун ухаантай холбоотой бусад олон тооны програм хангамжууд болон хиймэл оюун ухааны технологийг бусад салбарт ашиглах, чадвартай хүмүүс болж төлөвшлөхөд тусалдаг. Мөн бид хиймэл оюун ухааны хэрэглээний програм хангамж хөгжүүлэх инженерүүдэд зориулсан хөтөлбөрүүдийг санал болгодог.

1-р семестр	2-р семестр	3-р семестр	4-р семестр
IT-ийн статистик	Техөөрөмж суралцах	Тогтоом ба хиймэл оюун ухаан	Нийгэм ба Хиймэл оюун ухаан 1
Хиймэл оюун ухааны талаарх танилцуулга хичээл	Комбинаторын оновчлол	Төрөлх хэлийг ойлгох / Дуу хоолойгоор ойлгох	Нийгэм ба Хиймэл оюун ухаан 2
Алгоритмын талаарх танилцуулга хичээл	Хиймэл оюун ухаан програм хангамжийн програмууд 1	Эмчилгээний тэргүүлэх мэдээлэл судлал	
Компьютерийн програмчлал (Python)	Компьютерийн програмчлал (Java)	Робот техник ба хиймэл оюун ухаан	
Мэдээллийн сангийн ерөнхий онол	Хиймэл оюун ухааны математик	Хиймэл оюн ухаан програм хангамжийн програмууд 2	
Компютерын бүтэцийн онол	Өгөгдлийн шинжлэх ухаан		
Хэрэглээний мэдээлэл зүйн суурь математик	Өгөгдлийн олборлолт		
	Мэдээллийн сангийн хяналтын тусгай онол		
ICT бодит харилцаа	Төслийн үндэслэл		
Удирдлагын онола	Магистрийн төсөл		

Бусад мэргэшүүлэх хичээл, дадлагажих хичээл болон дагалдах сонгон судлах хичээлүүдээс сонгоно.

Захиалгат сургалт

Өргөн мэдлэг болон хэрэглээний салбар дахь чөлөөт сурах аргыг бий болгоно.

Хувийн төвлөрөл эсвэл үйлдвэрлэлийн курсуудаас гадна, өөрөө чөлөөтэй хичээлээ сонгож, өргөн хүрээний мэдлэг болон хэрэглээний салбар дахь оригинал хөтөлбөрийг сонгох боломжтой. Заавал судлах хичээлээс бусад хичээлүүдийг эрдэм шинжилгээний зохицуулагчтай зөвлөлдсөний үндсэн дээр сонгох ба ингэснээр оюутнууд өөрийн зорилгод тохирсон сургалтын хөтөлбөрийг гаргах боломж бүрддэг. Энэхүү уян хатан байдал нь оюутнуудад IT-н хэрэглээний шинэ чиглэлийг судлах сайхан боломжийг олгодог.



Захиалгат сургалтын загварын ач холбогдол

Колумбын Их Сургуулийн Нийгмийн Ажлын Тэнхимийн Нийгмийн Ажлын Магистр (Нью-Йорк, АНУ)
4 жилийн сургалттай Сэтгэцийн эрүүл мэндийн аспирантурын төвийн психоанализ ба аналитик сэтгэлзүйн эмчилгээний чиглэлээр Магистрын зэрэгтэй
Софиягийн Их Сургуулийн Гадаад Судлалын Факультетын Испани Хэл Судлал Урлагийн Бакалаврын зэрэгтэй (гадаадад сургалт)

Изү Мацүо *Дэд профессор*

Киотогийн их сургуулийн хуулийн бакалавр, Өмнөд Калифорнийн Их Сургуулийн магистр
Sony Electronics Inc (АНУ) компанийн бүтээгдэхүүний маркетингийн ахлах менежер асан, Carl Zeiss Vision Inc (АНУ), Бүтээгдэхүүний маркетингийн менежер асан, Kyocera International, Inc (АНУ), Бүтээгдэхүүний ахлах менежер асан, Expedia Holdings KK Баруун Японы орон нутаг хариуцсан менежер асан

Жулия Ёнетани *Дэд профессор*

Сиднейн Их Сургуулийн Урлагийн Бакалавр (Австрали), Токиогийн Их Сургуулийн Урлаг, Шинжлэх Ухааны Сургуулийн Урлагийн Шинжлэх Ухааны магистр (Олон Улсын Нийгмийн Шинжлэх Ухааны чиглэлээр), Австралийн үндэсний их сургууль, Ази, Номхон Далайн Коллежийн Түүхийн Доктор (түүхийн чиглэлээр)
Өдгөө Киото мужийн Нантан хотод фермерээр ажилладаг бөгөөд дэлхийн өнцөг булан бүрт байгаа үзэсгэлэнгүүдэд гоо зүйн нөлөө бүхий бүтээлүүдээ гаргаж, орчин үеийн уран зураачаар ажиллаж байна.

еСургалтын заал

Практик лаборатори

Амралтын өрөө

Номын сан

Кампусууд

Киотогийн төв сургууль

Киотогийн төв сургууль нь хоёр кампусаас бүрддэг. Эдгээр оюутны хотхонд оюутнууд хэрэглээний мэдээллийн технологийн хамгийн өндөр эрдмийн зэрэг болох IT-н магистрын зэрэг хамгаалах зорилгоор олон төрлийн сургалт, судалгаанд хамрагддаг. Хоёр кампусын хооронд явуулын автобусаар үнэгүй үйлчлүүлж аялах боломжтой.

Хякүманбэн кампус / Киото, Сакёо-кү

Хякүманбэн кампус нь боловсрол, судалгааны байгууламжаар 2004 онд сургууль нээгдэх үед байгуулагдсан. Учир нь ихэнх хичээлүүд нь энэ байранд ордог байсан бөгөөд олон тооны оюутан, багш нар цуглардаг байв. Кампус нь Киото хотын төвд байрлах Киото их сургуулийн ойролцоо байдаг тул суралцах хүсэл эрмэлзэл, үзэл бодлын эрх чөлөөгөөр дүүрэн байдаг. Нэгэн цагт энэхүү кампус нь KCG-ийн томоохон компьютерийн төв байсан бөгөөд оюутнууд UNIVAC Vanguard компьютерийг ашиглан тооцоолох дасгал хийдэг байжээ.

Киото Экимаэ хиймэл дагуул / Минами-кү, Киото

Киото Экимаэ хиймэл дагуул нь 2005 оны хавар баригдсан бөгөөд олон тооны зорчигчдын дамжин өнгөрдөг зорчих төв болох Киото зогсоолын зэргэлдээ маш тухтай онцгой бүсэд байрладаг. Киото Экимаэ хиймэл дагуул нь хамгийн сүүлийн үеийн цахим сургалтын студиар тоноглогдсон учир олон тооны лекцийг олон улсад энэ агаараас түгээх боломжийг олгожээ. KCG-ийн Киото Экимаэ кампус болон Киото Экимаэ хиймэл дагуулийн кампус нь IT-н боловсролын тэргүүлэх томоохон төвүүдийн нэг.

Явуулын автобус

Хиймэл дагуулын кампусууд

Гол кампусуудын нэгэн адилаар хиймэл дагуулын кампусууд нь оюутнуудын, тэр дундаа хөдөлмөр эрхэлж буй хүмүүсийн анхаарлын төвд байдаг. Хиймэл дагуулын кампусууд нь Киотогийн төв кампустай диспетчерийн ангиудаар (төв кампусаас зочлон ирсэн багш нарын заадаг хичээлүүд) төдийгүй цахим сургалтын системүүдээр дамжуулан үндсэн кампустай холбогддог. Видео хичээлүүдийг урьдчилан бэлддэг учир тэдгээрийг ашиглан суралцах боломжтой. Түүнээс гадна хиймэл дагуул бүрийн тусгай багш нар оюутнуудаа зорилгодоо хүрэхэд нь туслахын тулд амин чухал мэдээллүүдийг өгч дэмжлэг үзүүлдэг.

Саппоро хиймэл дагуул / DGIC Inc-д байрладаг

2012 оны 4-р сард Японы өргөн уудам Хоккайдо мужийн зүрхэнд орших Саппоро хотод хиймэл дагуулын хотхон нээгдсэн бөгөөд энэхүү кампус нь Киотогийн гадна байрлах KCG группын анхны байгууламж байв. Саппоро хиймэл дагуулын кампусд ажилладаг бүх зааварлагч багш нар нь одоогоор IT-н салбарт идэвхтэй ажиллаж байна. Багш нар нь IT-н салбарын өнөөгийн асуудлуудын талаар салбарынхаа хамгийн сүүлийн үеийн мэдээллийг өөрсдийн туршлага дээр үндэслэн нэгтгэж, ойрын ирээдүйд IT-н салбарт шаардлагатай мэдлэг, ур чадвар, харилцааны чадварыг тодорхой тайлбарлаж өгдөг. Энэхүү хичээл нь Хоккайдо арал дахь IT-н чиглэлээр сурч байгаа оюутнуудад төдийгүй Киотогийн төв кампусын оюутнуудад оюуны урам зориг өгдөг.

Токио хиймэл дагуул / Hitomedia, Inc дотор байрладаг

Токио хиймэл дагуул нь Токио хотын Минато хотын Роппонги толгодын ойролцоо байрладаг. Энэ нь Саппоро хиймэл дагуулын дараа 2012 оны 10-р сард нээгдсэн хоёр дахь хиймэл дагуул юм. Токио хиймэл дагуулын олон сургагч багш нар өнөөгийн нийгмийн хурдацтай дижиталчлах үйл ажиллагааны идэвхтэй тоглогчид юм. Тиймээс Токиогийн хиймэл дагуулаас явуулж буй IT-н сургалт, логик сэтгэлгээний хичээлүүдэд оюутнууд, тэр дундаа Киото хотын төв кампусын оюутнууд олон жилийн туршид маш дуртай байсаар ирсэн. Токиогийн хиймэл дагуулаас явуулдаг сургалт нь дэлхийн тавцанд чухал үүрэг гүйцэтгэж чадах IT-н шилдэг удирдагчдыг төлөвшүүлэхэд ихээхэн хувь нэмэр оруулдаг.

Компьютерийн хэрэглээний систем

Оюутнууд хичээлийн бус цагаар практик лабораториуд дахь компьютерийг ашиглах боломжтой. Гэхдээ зөвхөн лобараториуд ашиглагдаагүй үед ямар нэгэн нэмэлт төлбөр төлөх эсвэл захиалга өгөх шаардлагагүйгээр ашиглаж болно.

Microsoft

Боловсролын байгууллагуудад зориулсан Office 365 ProPlus лицензтэй программ
Боловсролын байгууллагуудад зориулсан OVS-ES лицензтэй программ

KCG нь OVS-ES болон Microsoft корпорацын боловсролын байгууллагуудад зориулан гаргасан Office 365 ProPlus зэрэг лицензтэй программыг сургалтандаа ашигладаг. Эдгээр лицензтэй програмуудыг ашиглан Office програмууд, төрөл бүрийн хөгжүүлэлтийн хэрэгслүүд, Windows үйлдлийн системүүдийг компьютер, техөөремжүүдэд ашиглахад хамгийн боломжийн тохиромжтой үнээр худалдан авах боломжийг олгодог. (Оюутнууд ашиглахын тулд зөвшөөрлийн гэрээтэй танилцаж бөглөн ирүүлэх шаардлагатай.)

Худалдан авах боломжтой програм хангамж

- Microsoft Office 365 ProPlus
- Microsoft Office Professional
- Microsoft Windows OS upgrades

Тайлбар: Windows үйлдлийн системийн хувьд зөвхөн шинэчлэгдсэн хувилбарыг санал болгодог.

Профессорын ярилцлага

Японы анимэгийн ертөнцөөс бизнесийг эрэлхийлэх

Гайнакс Киото ХХК-ийн гүйцэтгэх захирал

Японы Шинжлэх Ухааны Зохиол, Уран Зөгнөлт Зохиолчид (SFWJ), Японы Уран Сайхны Зохиолчдын Клуб (SACJ)-ын гишүүн

Гайнаксын үүсгэн байгуулагч гишүүн. *Надиа, Цэнхэр тэнгисийн нууц*, *Тэнген Топпа Гуррен Лаганн* зэрэг Японы олон алдартай хүүхэлдэйн киноны продюсер

Профессор

Такэда Ясүхиро



KCG группын 50 жилийн ойн үйл ажиллагаа (URL: kcg.ac.jp/gainax)

Японы анимэ болон ICT

IT-ийн манга, анимэ гэх мэт мэргэшүүлэх чиглэлээр KCGI нь шинэ зах зээл болон бизнесийн модель бий болгохын тулд эдгээр комбинациудыг ашиглаж байна. Профессор Такэда Ясүхиро нь Анимэ төлөвлөх, бүтээх, сурталчлах тухай тусгай сэдвүүдээр хичээл заана. Профессор Такэда нь *Надиа*, *Цэнхэр тэнгисийн нууц*, *Тенген Топпа Гуррен Лаганн* зэрэг бүтээлүүдийг хийсэн алдартай студи болох Гайнаксын үүсгэн байгуулагчдын нэг юм. Гайнаксын Анимэ бүтээгчийн хувиар Профессор Такэда нь *Шинэ үеийн Евангелион*: *Төмөр бүсгүй*, мөн *Шилдэг 2-р байрын төлөө урагшаа! Дайбастер, Шидэт Дэлгүүр Аркайд Абенобаши* ба *Ханамакү Цэцэрлэг* гэх мэт олон тооны бүтээлүүд дээр ажиллаж байсан. Гайнакстай хамтран Профессор Такеда KCG Группын 50 жилийн ойн үйл ажиллагаанд ярилцлага өгсөн байна.

Бизнес гэдэг нь “Мөнгийг хэрхэн эргэлтэнд оруулах вэ”-д оршино

— Анимэг бизнестэй холбох түлхүүр нь юу бэ.

Өнөөдрийг хүртэл хийж ирсэн миний гол ажил Гайнакст хүүхэлдэйн кино төлөвлөж, бүтээх юм. Анимэ хийх төлөвлөгөө боловсруулж, хамтран ажиллахыг хүссэн компанитай хэлэлцээр хийж, дараа нь нэвтрүүлэгтээ бэлтгэн, төсвөө тооцож төлөвлөнө. Уран бүтээлээ бэлэн болонгуут, хэр их мөнгийг эргэлтэнд оруулахаа бодох нь чухал. Түүнийг хөдөлгөөнд оруулсныг, өөрөөр хэлбэл бизнес гэж хэлж болох болов уу.

— Такэда профессор та яагаад анимэ оролдох болсон бэ.

Өөрийн төлөвлөсөн бүтээлүүдээс дурдвал *Плейадес* ба *Тенген Топпа Гуррен Лаганн* зэрэг юм. Одоогоор олон тооны шинэ Анимэ төлөвлөгөөн дээр ажиллаж байна. Би ийм ажил хийж эхэлсэн нь санаандгүй зүйлээс эхлэлтэй. Оюутан байхдаа огт хичээлээ хийдэггүй байлаа. Гэвч, оюутан байхдаа сайн дурын ажил зохион байгуулах дуртай, өөрөө бүх юмаа төлөвлөж хийдэг байлаа, нэг л мэдэхэд энэ ажлыг хийх болчихсон байна. Одоо ч гэсэн би өөрийгөө сонирхогчын зүгээс ажлаа хийж байна гэж дүгнэдэг. Сонирхож эхэлсэн үеэсээ эхлээд өнөөг хүртэл “Хөгжилтэй, зугаатай юм хийх санаачлагаа” мартахгүй байхыг хичээдэг.

— Анимэг сурч буй оюутнуудад хандаж юу хэлэх вэ.

Анимэгийн зохиол бүтээлийг төлөвлөж, туурвихад асар их энерги шаардана. Түүнээс гадна, хөрөнгө мөнгөө цуглуулан санхүүжүүлнэ гэдэг бол нөсөр хариуцлага үүрнэ гэсэн үг. Уран бүтээлээ хүнд үзүүлж, үнэлгээ авч байж, хөрөнгөө эргүүлж ашгаа гаргаж авах болно. Ингээд бодоход, төлөвлөсөн зүйлээ бүтээл болголоо. Бүтээлээ гаргаж л байвал боллоо гэж байгаа бол зүгээр л сэтгэлийн ханамж авахаас хэтрэхгүй. Бүтээлээ үзүүлж үнэлгээ авч байж анх удаа бүрэн гүйцэд уран бүтээл гарна. Үнэлгээ нь зөвхөн хийсэн ажлыг дүгнэхээр зогсохгүй үйл хөдлөл, үг хэллэг гээд бүхий л талаас үнэлэгдэх болно. Та бүхэн ямар үнэлгээ авахаасаа айж шантралгүй зоригтой зогсож чадах сэтгэлийн тэнхээтэй байж сураарай.

Профессорын ярилцлага

“Хацүнэмик”-н
Crypton Future Media
ХК-н захирал

Профессор

Итох Хироюки

“Ирээдүйгээс ирсэн эхний чимээ”-гээс улбаатай зохиомол шүтээн нь дууны үг болон аяыг компьютерт суулгангуут хоршмол хоолойгоор дуулж өгдөг. Дотоод төдийгүй далайн чандад ч амьд тоглолт зохиогдож, олон шүтэн бишрэгчийн сэтгэлийг хөдөлгөдөг. Энэхүү их амжилтыг түрсэн дууг хоршуулах программ хангамж “Хацүнэ Мик”-г зохион бүтээгч Crypton Future Media Inc компанийн гүйцэтгэх захирал Ито Хироюки нь KCG-ын багшаар томилогдсон. Компьютер болон авианы нийлүүлэтийн программ хангамжийг зохион бүтээсээр байгаа Ито багш бол ирээдүйн мэдээллийн технологийн ертөнцийг нуруундаа үүрэлцэхээр зүтгэж буй залууст хандан “дөнгөж замын талдаа гэж хэлж болох “Мэдээллийн Хувьсгал”-н хилийн хязгаар нутаг бол нүд алдам их бөгөөд оюутнуудын өмнө хязгааргүй дэлгэстэй байна. Түүнийг бүрэн мэдэрч, эрдэмдээ шамдаасай” гэж захиж байна. Ито гуайн ярианаг сонслоо.

Дуу хоолойны синтезийн хувьсгалыг хөндсөн Хацүнэ Микүгийн ертөнц

Манай компани тоглоом болон анимэ зурагт ном хийдэг компани биш. Хөгжимтэй холбоотой ажил хийдэг ч дуу бичлэгийн компанитай адилхан биш. Сонирхон ороллдог компьютерийн хөгжмийг бизнестэй холбосон нэг бодлын “Дуу оруулагч” гэж болно. “Хацүнэ мик”-г 2007 оны 8 сард борлуулж эхэлсэн бөгөөд энэ нь хүмүүст ажил үйлстээ бүтээлчээр шамдан ажиллах боломжийг олгож өгсөн гэж бодож байна.
Хүн төрөлхтөн өнгөрсөн үедээ гурван том хувьсгалыг даван туулж ирсэн гэж ярьдаг. Эхний хувьсгал нь хөдөө аж ахуйн хувьсгал. Ан агнуур хөөж яахын аргагүй нүүдэллэхээс өөр аргагүй болж ирсэн хүн төрөлхтөн энэхүү хувьсгалаар хүнс тэжээлээ төлөвлөгөөтэйгөөр үйлдвэрлэж, үржүүлж чаддаг болж ирсэн тул, тогтсон газар нутагт суурьшиж эхэлсэн. Үүнээс нийгэм, улс төр үүсэн бүрэлдэж, нөгөө талаар баян ядуугийн ялгаа гарч эхэлсэн. Эдийн засгийн өсөлттэй зэрэгцэн дайн тулаан гарах болсон шалтгааныг үүсгэсэн ч гэж хэлж болно.
Хоёр дахь хувьсгал нь аж үйлдвэрийн хувьсгал юм. Хөдөлмөрийн бүтээмжийг дээшлүүлж, адилхан зүйлийг үр өгөөжтэй хийж бүтээх арга зүй хөгжсөнөөр, их хэмжээгээр үйлдвэрлэж, их хэмжээгээр хэрэгцээгээ хангаж эхэлсэн. Гадаад худалдаанд ахиц гарч, бүс нутгийн хэмжээгээр элбэг баян болоход нөлөөлсөн. Мөн, энэ хувьсгал нь “хүн амын огцом өсөлт”-г бий болгосон. Аж үйлдвэрийн хувьсгалын өмнө, олноор үйлдвэрлэж, олноор үхэж үрэгдэж байсан үе байсан ба хүн амын өсөлт тогтворжиж, нийгмийн давхаргын ялгаа багасч ирсэн боловч аж үйлдвэрийн хувьсгалаар, хүн амын өсөлт асар хурдтайгаар нэмэгдсэн.
Түүнчлэн, гурав дахь хувьсгал нь интернэтээр тэргүүлсэн мэдээллийн технологийн мэдээллийн хувьсгал байлаа. Интернэтээс өмнө, мэдээллийг түгээгч нь хязгаарлагдмал, өвөрмөц байдалтай байсан. Түгээгч нь сонин хэвлэл болон телевиз, радиогийн студи, хэвлэлийн компани гэх мэт мэдээллийн агентлагууд байсан ба эдгээр нь мэдээллийг түгээхдээ тоног төхөөрөмж болон хүн хүчдээ асар их хэмжээний зардал гаргадаг байв. Түүнчлэн энэ үеийн мэдээллийн багтаамж бага, зөвхөн нэг урсгалын байсан. Гэвч, интернэт үүссэнээр энэхүү хувьсгал гарах болсон. Мэдээллийг түгээх арга барилд ихээхэн өөрчлөлт орсон.
Одоо, интернэтийн хэрэглээ нь ердийн үзэгдэл болж, гар бүртээ, ширээн дээрээ, халаасандаа ч авч яваад ашиглах боломжтой болжээ. Мэдээ, кино, дуу хөгжим зэрэг дижиталчлагдсан мэдээллийг интернэтээр дамжуулан хялбархан түгээж, хуримтлуулж байна. Өөрийнхөө дуртай дүрс бичлэг, нэвтрүүлгийг дуртай үедээ үзэж харж, амьдрал болон ажлаа хялбарчлан хөгжилтэй өнгөрөөх боломжтой болоод байна. Мөн, энэхүү мэдээллийг өөрийнхөө мэдээтэй холбон, Facebook ба Twitter, блогоор дамжуулан өөрийнхөө тухай хялбархан, хурдан, дэлхий дахинд цацаж болдог болоод байна.
Гэвч, энэхүү мэдээллийн хувьсгалын өөрчлөлт дөнгөж эхлээд байна гэж бодож байна. Хөдөө аж ахуй, аж үйлдвэрлэлийн хувьсгал нь хүн төрөлхтөний ахуй амьдралд ихээхэн өөрчлөлтийг авч ирсэн. Мэдээллийн хувьсгалыг авчрах өөрчлөлт нь одоогоор тийм өндөр түвшинд хүрээгүй байна.
Нэг их удахгүй, цаашид жинхэнээр өөрчлөгдөж эхлэх боловуу.
20-30 жилийн дараа, хүний амьдрал, дэлхий дахиныг зүйрлэхийн аргагүй өөрчлөх байх. Гэвч, хэрхэн яаж өөрчлөгдөхийг мэдэхгүй юм. Яаж өөрчлөх вэ гэдгийг бид бүхэн болон бидний ирээдүйн залгамжлагчдын гарт атгагдаж байна.

Хацүнэ мик
Зураглал: KEI
©Crypton Future Media, INC.

Профессор

Ницца Мэлас

“Шилк дү Солэи Cirque du Solei” гол дуучин, дуу зохиогч

Олон хэлийг эзэмшсэн, дэлхийн улс бүрт сонсогдын сэтгэлийг татаж ирсэн Канад Монтореалд төрсөн дуу зохиогч. Улс бүрт цирк болон хөгжим зэргийг нийтэд үзүүлэн үргэлжилж буй intertainment бас “Шилк дү Солэи”-н гол дуучин 3-н нэг нь. Тэдгээр дунд өөрөө үгийг нь зохиож, аяыг нь хийсэн дуу нь, Шилк дү Солэи-н шоунд хэрэглэгдсэн тул, ганцхан түүнийг, багийн топ дуучин гэж хэлж болно. Label (бичлэгийн компани)-д харьялагдалгүй, дуу, үг бичих, ая зохиох-с гадна, график дизайн, промошн, худалдаа хүртэл бүгдийг хийдэг.

Шинэ үзвэр үйлчилгээний ертөнц

Урлагын ертөнц болон IT ертөнц нягт холбогдсон байдаг. Creative vision нь гайхалтай технологитой нэгдэх үед, хэрэглэгчийг өөр хэмжээс рүү татаж оруулдаг. Тиймээс тэргүүлэх технологийн эхэнд байж, мөн бүтээлч чанар болон маш хурдацтай хөгжиж буй өргөн хүрээний компьютерын салбарын мэдлэгийг эзэмших орчин байгаа боловсролын байгууллагад би оролцож байгаа нь байгалаас заяасан зүйл юм.
Intertainment-н ертөнцөд, IT бол бидний янз бүрийн бизнест нэвтэрсэн байна. Компьютер-р дуу бичих засах, кино рекламын үг ч, Шилк дү Солэи (Cirque du Solei)-н олон талт бэлтгэл болон multimedia ч байсан, би үүрч буй performance нь өндөр төвшиний мэргэжилийн технологи болон, жүжигчин болон технологичийн багийн хурц бүтээлч чанар шаардагдана.
Эдгээр хамтын ажил нь, урлаг болон технологи нь дүрс болон дууны тоглолтыг хийхийн тулд харилцан хамтрах хэсэг гэж хэлж болно. Тус сургуульд, оюутан нь мэдлэгийг олж бизнесийн ертөнцийн олон талд хэрэглэх урлагийн, технологийн мэдлэгийг сайжруулах хэрэгсэлийг сурах боломж байгаа. Professional mapping-р төлөөлсөн илтгэлийн дэвшил нь, урлагтай холбоотой мэдээлэл боловсруулах технологич гэсэн байр суурийн шаардлагыг бий болгож, хэрэглэгчийн итгэлийг давсан онцгой илэрхийлэлтийг бүтээх боломж болж байна. Тус сургууль нь энэ салбарын суралцах хамгийн тэргүүнд байгаа бөгөөд, сурагч нь өөрийн боломжийг даван гарах орчинг бий болгож байна.

KCG групп-н үүсгэн байгуулагдсан 50 жилийн ойд зориулсан CD [MUΣA]-г танилцуулах концерт дахь Ницца Мэрис профессор.

Профессор

Ко Хонсөн

өмнөх Samsung компаний төлөвлөгөө төлөвлөлтийн хэсэг мэдээлэл төлөвлөлтийн хэлтэсийн дарга (CIO)

Ниппон хэрэглээний мэдээлэл зүйн нийгэмлэг (NAIS)-ын Төлөөлөх захирал

Солонгос улсын харьяат Ко Хон Сон профессор нь, Солонгосын цахилгаан бараа, цахилгаан эд ангийн томоохон компани, Samsung ХК-н төлөвлөгөө төлөвлөлтийн хэсэг мэдээлэл төлөвлөлтийн хэлтэсийн дарга (CIO) болж, компаны интернет хэрэглэх төлөвлөгөө, B2B-н гол үзэл болох CALS, энгийн хэрэглэгчид зориулсан цахилгаан худалдаа арилжааг бий болгоход хүч оруулж, компаны мэдээлэлжүүлэлт болон ашиглын нэмэгдэлтэд ихээхэн хувь нэмэр оруулсан. Тэрхүү Ко профессор нь, ихээхэн өөрчлөгдөх е Бизнесийн ертөнцөд хэрэгтэй боловсон хүчний талаар ярина.

Стратеги шаардагдах еБизнес

—— еБизнес-н ертөнц нь маш хурдтай өөрчлөгдөж байна гэгддэг. Интернетийн тархалтыг дагаад, бизнесийн орших байдал бас өөрчлөгдөж ирсэн үү.

Би Samsung-н мэдээлэл төлөвлөлтийн хэлтэсийн дарга болоод удалгүй 1990 оны хагаст, гадаад улс руу хандсаныг оролцуулсан вэб сайт хийсэн. Тэр үед хараахан, интернет маркетинг-н хүчтэй хэрэгсэл болно гэж бодолгүй, зүгээрл, компаны нэр хүнд өсөг нэг арга гэснээс өөрөөр бодож байгаагүй. Гэвч, сайтыг нээнгүүт, дэлхийн олон газраас бүтээгдэхүүний дараахи арчилгааны талаар асуултууд болон гомдолууд зэргийн мэйл 1 өдөрт 200 орчим ирсэн. Тэр үед, вэн сайтыг маркетингит хэрэглэж болохыг мэдэрсэн. Түүний дараа, вэб сайтын захиалгын систем болон үнэт цаасны арилжаа зэрэг, интернет хэрэглэсэн бизнес ихэссэн. Гэвч, зөвхөн интернет дээр хэрэглэж болох систем зохиовол борлуулат нэмэгдэнэ, гэсэн зүйл биш. Тэр үед, Солонгос улс бас интернет хэрэглэж байвал бизнес сайн явна гэсэн, алдаатай IT boom явагдсан. Интернет худалдааны төв хийж бараа тавибал, дэлхийгээс хэрэглэж цуглаж худалдагдана гэж, бодож байсан. Бодит байдалд, худалдааны төв нь хэдэн жилдээ интернетээс алга болсон. Эцэст нь, интернет нь нэг хэрэгсэлээс хэтрэхгүй гэсэн зүйлд анхаарсан. Бас, [стратеги] дутагдаж байсан гэж бодож байна. Интернет дэхь бараа хэдий өрөвч, яалтачгүй, дэлгэцэн дээр үзүүлж байгаагаас хэтрэхгүй. Бодитоор барааг худалдан авахад, offline-д гараараа барьж үзсэний дараа, гэсэн тохиолдлууд эзэлсэн.

Хоцорч буй Японы аж ахуй нэгж болон дутагдаж буй боловсон хүчин

—— Огцом өөчлөгдөж буй орчны дунд, өнөөгийн дэлхийн бизнесийн талаар хэрхэн харж байна вэ.

Япон болон Солонгос зэрэгт, харамсалтай нь, IT-г хэрэглэсэн нийгмийн худалдааг нэмэгдүүлэх стратегийг хийж чадах боловсон хүчин цөөн байгаа нь бодит байдал юм. Нөгөө тал дээр, аж ахуй нэгж нь IT дэд бүтэцийг бий болгоход ихээхэн хөрөнгө оруулж байгаа учир, аж ахуй нэгжийн асуудал их.
Аж ахуй нэгжид шаардагдаж байгаа нь, нэг үгээр хэлвэл “еБизнес стратеги хийж чадах боловсон хүчин” юм. Өөрөөр хэлвэл IT нөөцийг маркетинг, удирдлагад оролцуулах чадвартай байхгүй бол болохгүй гэсэн үг.
Эхнээсээ Япон болон Солонгосын аж ахуй нэгж дэхь ажилчид, маркетингийн ойлголт бага гэж үзэгддэг. Өдөр тутмын ажлаа хийвэл цалин аван гэсэн, ашиг орлогын тэгш хувиарлалт гэсэн бодол ул сууринд нь байгаа учраас юм.
Нөгөө талд, Америкт өөр юм. Ажиллаж буй ажилын хэмжээ ч гэдиймүү, бодитоор хийсэн ажил нь хэр зэрэг нийгэмд нэмэр болж байгаа вэ, гэдгийг байнга шаардаж байдаг. Америкийн аж ахуй нэгжид маркетингийн мэргэжсэн хэлтэс гэж барг байхгүй. Ажилчид бүгд түүнийг бодож байдаг тул шаардлагагүй гэсэн үг юм.
Америкийн аж ахуй нэгж нь, жишээ нь орлого муудсан ч, хэрхэн зарагдалтыг ихэсгэж явах вэ гэж бодох нь биед нь шингэсэн байдаг тул, байнга урагшлах боломж байдаг. Япон болон Солонгос аж ахуй нэгж нь тэмцэх нь амаргүй юм. Япон болон Солонгост, маркетинг гэдэг нь зөвхөн “танилцуулга”, “зарлал”, “бренд” гэж буруу ойлгож буй аж ахуй нэгж нь том компанийг оруулаад олон бий. Тиймээс, интернетийг бизнест хэрэглэж, IT компани болж амжилт гаргасан нь одоогоор зөвхөн Америк юм. Япон болон Солонгост ч бас дотооддоо тийм үнэлгээ авч буй компани байгаач, бодит байдал дээр, дэд бүтэц нь хөгжиснөөр бий болсон еБизнесын boom-тэй зэрэгцэн, money game-р өссөн, гэдэг нь үнэн. Дашрамд хэлхэд, Ёвропт еБизнес амжилт гаргасан компани байхгүй. Энэ нь, интернетийн тархалт ихээхэн хоцорч байснаас үүдэлтэй.

Азид давамгайлах мэргэжилийн ажилын сургалтын дараахи их сургууль

—— Эдгээрийн дунд, тус сургууль нь ямар онцлог гаргаж, юуг зорьж явах вэ.

IT-р дагнасан сургалтын дараахи их сургууль байхгүй. Дээр нь тус сургуульд, Киото компьютерын сургууль гэсэн түүхийн ар тал байдаг. Энэ нь хамгийн том давуу тал юм.
Мөн, тус сургуульд мэргэжилийн мэдлэг болон технологи бүхий, дээр нь аж ахуй нэгжид бодит ажлын туршлага бүхий багш бүрдсэн байдаг. Би өөрөө бас лекцэн дээрээ, аль болох
өөрөө оролдсон зүйлийн талаар, амжилттай болсон зүйлээс гадна, алдаа гаргасан жишээг бас ярихыг боддог. Алдаа гаргасан жишээ нь илүү олон зүйлийг сурч чадах нь олон байдаг. Ийм байдлаар, тухайн үед жинхэнэ шаардлагатай боловсон хүчинг бэлдэж байна. Гадаадын их сургуультай боловсролын сүлжээ жил бүр тэлж байна. Дэлхий нь Японоор хязгаарлагдахгүй. Азийг талбараа болгож үйл ажиллагаа явуулж чадах боловсон хүчинг бэлдэхэд нэмэр болох мэргэжилийн ажлын сургалтын дараахи их сургууль байна гэж бодож байна.

Урьдчилан бодсон бодлынхоо боол бүү бай. Өөрөөрөө бай, мөрөөдлийнхөө хойноос яв.

Профессор

Цүчимочи Гари Хоүичи

Факультетын хөгжил, харьцуулсан боловсролын судалгаа, дайны дараах боловсролын шинэчлэлийн түүх, соёлын боловсролын мэргэжилтэн

Профессор Цүчимочи түүний сурган хүмүүжүүлэх философи бол "KCGI-ийн оюутнуудтай хичээлээ төлөвлөхөд нь хамтран ажиллах" гэж хэлж байсан. Профессор Цүчимочи нь заах болон сурах хичээлүүдийн сэдвүүдийг сонгохдоо оюутан төвтэй хичээл бий болгохын тулд бүлгийн сургалт бий болгохыг KCG-ын оюутнууддаа сургадаг.

Боловсролын хамгийн чухал зорилго нь суралцагчдын сурч боловсрох үйл ажиллагаанд түлхэц өгөх юм.

—— Та өөрийн заан сургадаг философи тус бүрийнхээ талаар тайлбарлаж өгөхгүй юу?

Бид урьдчилан бодсон бодлынхоо боол байхаас яагаад зайлсхийх ёстой вэ? Яагаад гэвэл ингэснээр бид уян хатан чөлөөтэй сэтгэх чадвараа алддаг. KCGI нь орчин үеийн IT, тухайлбал хиймэл оюун ухаан болон бүтээлч байдлыг бий болгохуйц салбаруудыг судалдаг газар юм.

Сургалт (gakushu) болон тэтгэлэг (gakumon) нь хоорондоо ямар ялгаатай вэ? Саяхныг хүртэл сургуулиуд өөрсдийн заадаг идэвхгүй сургалтанд анхаарсаар ирсэн. Энэ бол заах үйл явц юм. Энэ төрлийн сургалт нь үйл явцыг эрхэмлэдэг. Эрдмийн зэрэг олгох сургууль нь үүнээс ялгаатай. Хэн ч танд заахгүй. Оюутан өөрөө судалгаагаараа сургалтаа удирдан явуулдаг. Энэ нь "тэтгэлэг" гэсэн үгнээс гаралтай. Өөрөө суралцах үйл явц нь ажиллангаа суралцдаг хүмүүст ач холбогдолтой. Энэ төрлийн сургалт нь үр дүнг эрхэмлэдэг.

Асуудлыг олж илрүүлэхэд чиглэсэн сургалт гэж юу вэ? Асуудлыг олж илрүүлэхэд чиглэсэн сургалт өнөөгийн нийгэмд цаашид улам эрэлт хэрэгцээтэй болох хандлагатай байна. Шинэ зүйлийг бий болгох нь эрэл хайгуул шаардаг. Эрэл хайгуул хийхэд судалгаа зайлшгүй шаардлагатай. Гэвч бие даан ганцаараа явуулсан судалгаа нь зөвхөн тухайн үедээ л ахицтай дэвшилтэй байх боломжтой. Оюутнууд бүлгээр биш багаараа суралцах ёстой. Энэхүү аргачлал бүюу багт суурилсан сургалт (TBL) нь асуудалд суурилсан сургалт (PBL)-ын халаат авч байна.

Суралцах орчин гэж юу вэ? Энэ төрлийн сургалт нь суралцах орчноос хамаардаг. Багшийн ажил бол заах биш юм. Харин багш чиглүүлэх ёстой. Энэ нь Японы боловсролын хэв маяг болон Америкийн боловсролын хэв маяг хоорондох ялгаа юм. Эхнийх нь Японых, дараагийнх нь Америкийн арга барил юм.

Либерал урлаг гэж юу вэ? Либерал урлаг гэдэг нь их сургуулийн боловсролын чухал хүчин зүйл юм. Уламжлалаар бол либерал урлаг нь хүмүүнлэгийн ухаантай холбоотой. Гэвч өнөө үед либерал урлаг нь мөн шинжлэх ухаанд чухал болсныг онцлох нь зүйтэй. Тухайлбал Токиогийн Технологи йн Дээд Сургуулийн дэргэд дөнгөж байгуулагдсан Либерал урлагийн төвийг авч үзье. Тэндхийн профессоруудын нэг нь NHK-ийн сурвалжлагч байсан Акира Икегами юм. Тэндхийн нөхцөл байдал АНУ-ын зүүн эрэг дээр оршдог MIT-тэй адилхан юм. АНУ-ын Төрийн нарийн бичгийн дарга байсан Хиллари Клинтоны суралцаж байсан, мөн Мона Лиза Инээмсэглэл киноны зураг авалт хийгдэж байсан Уэллсли коллеж үүний нэг жишээ юм. Уэллсли коллеж нь АНУ-ын хамгийн алдартай эмэгтэйчүүдэд шинжлэх ухааны коллежуудын нэг бөгөөд либерал урлагийн коллеж гэдгээрээ алдартай. Би тус коллежийн "1-р курсын семинар"-ыг Японд нэвтрүүлсэн.

Ажиллангаа суралцаж буй насанд хүрэгчдын гол давуу талууд юу вэ? "Ажиллангаа суралцаж буй насанд хүрэгчдийн үндсэн давуу тал" (shakaijin kisoryoku) гэдэг нь Японы их дээд сургууль болон компаниуд дээр байнга яригдаж байдаг хэллэг юм. Энэ тухай ном хүртэл гарч байсан. Эдгээр номнуудын нэгэнд либерал урлагийн давуу талуудын нэг болох шүүмжлэлт сэтгэлгээг ажиллангаа суралцаж буй насанд хүрэгчдийн гол давуу тал гэж зааж байсан миний хичээл багтсан байдаг.

Хүмүүс хиймэл оюун ухаантай зэрэгцэн оршиж чадах уу? 2045 он гэхэд хиймэл оюун ухаан хүн төрөлхтнөөс давж гарна гэсэн дүгнэлт гаргах үед энэ нь шүүмжлэх мэдрэмж төрүүлсэн. Харин ихэнх хүмүүс хиймэл оюун ухаан хүмүүсийн ажлыг булаах болов уу яах бол гэж гайхаж байв. Миний бие Японы Компьютерийн Боловсролын Их Сургуулиудын Холбоо (JUCE)-ны дадлага-сургалтын хамтарсан төсөл болох "Их сургуулийн факультетын аж ахуй нэгж-үйлдвэрийн сургалт" -ын хүрээнд электроникийн томоохон үйлдвэрлэгчийн дотоод сургалтын хөтөлбөрт оролцож байсан. Тус компани нь хиймэл оюун ухааны технологийн тэргүүлэгч компани юм. Физикийн ухааны докторын зэрэг хамгаалсан Германы Канцлер Ангела Меркель тус компанид хааяа зочлон ирдэг. Тэр хиймэл оюун ухааныг эсэргүүцэх биш харин зэрэгцэн орших шаардлагатай болохыг онцолсон байдаг. Мөн хиймэл оюун ухаан нь шинжлэх ухаан болон технологийг хүний боловсролтой нэгтгэсэн хослол гэж үздэг.

Сурах арга барил ээзэмших гэдэг нь ямар утгатай вэ? MIT болон Уэллсли коллеж нь хүмүүст бие даан сурах арга барилыг ээзэмшүүлэх зэрэг "сурах арга барил"-ын ач холбогдлыг онцлон тэмдэглэдэг. Энэ нь либерал урлагийн коллежийн чухал хүчин зүйл юм.

Их сургууль - аж ахуйн нэгжийн түншлэл гэж юу вэ? Миний бодлоор их дээд болон төгсөлтийн дараах сургууль болон нийгэм (аж ахуй нэгж) хоорондох түншлэл нь цааш урагшлахад зайлшгүй шаардлагатай юм. Энэ нь бид яагаад хүмүүсийг биен даан сурахад чиглүүлэх шаардлагатай вэ гэдгийн нэг шалтгаан билээ.

KCG группын боловсролын философи: Бүх их дээд сургуулиуд элсэлтийн бодлого, сургалтын хөтөлбөр, дипломын бодлоготой байдаг. KCGI-ийн толгой компани KCG-ийн боловсролын философи нь: "Компьютер технологийн бүтээлч сэтгэлгээг хөгжүүлэх", "Өргөн хүрээнд бүх чиглэлд сэтгэлгээг хөгжүүлэх" юм. Товчхондоо либерал урлагийг шинжлэх ухаан, хүмүүнлэгийн ухааны нэгдэл гэж болно.

IT-ээр дамжуулан шинэ ертөнцийг эрэлхийлэх сорилтуудыг даван гарах.

—— Танд манай оюутнуудад хэлэх захиас бий юу?

KCGI-ийн оюутны хувиар та бусад сургуулиас илүү тав тухтай, нөөц боломжтой боловсролын орчинд суралцах болно. Тиймээс та IT-ийн мэргэжлийн мэдлэг чадварыг хялбархан ээзэмшихээс гадна шинэ ертөнцийг эрэлхийлэх сорилтуудыг даван гарахад уг мэдлэг чадвараа ашиглаж сурна. Би суралцагч төвтэй сургалт бий болгоход KCGI-ийн оюутнуудтай хамтран ажиллаж, бусад оюутнуудтай харилцах харилцааг эрхэмлэсэн суралцах орчинг бий болгохын мөрөөдөг.Надтай хүч чадлаа хуваалцаач. Тэгвэл бид бид хамтдаа энэ мөрөөдлийг биелүүлж чадна.

Аюулгүй байдлын шаардлагад нийцүүлэн дижиталчлалын үйл ажиллагааг тэнцвэржүүлэх нь

Профессор

Найто Шозо

өмнөх Японы цахилгаан холбоо хувьцаат компани Мэдээлэл дамжуулах platform судалгааны газар хариуцагч судлаач Киотогийн Кибер лабораторийн захирал

Профессор Шозо Найто нь Японы цахилгаан холбоо хувьцаат компани (одоогийн NTT)-ний Мэдээлэл түгээлтийн Платформын лабораторийн ахлах судлаачаар ажиллаж байжээ. Тэр сүлжээний болон мэдээллийн аюулгүй байдлын мэргэжилтэн юм. Профессор Найто COVID-19 цар тахлын улмаас Япон улсын болон дэлхий нийтийн сүлжээ, кибер аюулгүй байдал өнөөдөр ямар байгаа талаар болон түүнтэй холбоотой асуудлуудын талаар бидэнтэй ярилцсан юм.

Япон улс дижиталчлалыг дэмжих чиглэлээр урагшлах ёстой

—— COVID-19 цар тахал нь IT-ийн дижиталжуулалт болон хэрэглээг нийгэмд хүлээн зөвшөөрөхөд түлхэц болсон. 2021 оны 09-р сард төлөвлөгдсөн "дижитал агентлаг"-ийг эхлүүлснээр энэ хандлагыг түргэвчлэх юм.

Бие физиологийн ертөнцийн нэгэн адилаар кибер орон зай нь өдөр бүр шахам шинэ овог бий болж байдаг вирусаар дүүрэн юм. Мэдээж физиологийн ертөнцөд мутаци бий болдог бөгөөд бид амьдралын хэв маягтаа өөрчилж дасан зохицоноор хариу үйлдэл үзүүлж байдаг. Зарим талаараа Япон улсын дижиталчлал дэлхийн бусад орнуудаас хоцрогдсон байна. Гэвч эцэстээ алсын зайнаас ажиллах явдал олон нийтийн дунд дэлгэрч эхэлсэн. Сүүлийн үед дижиталчлалыг шинэ түвшинд гаргах дижитал өөрчлөлт (DX: Дижитал технологи нэвтэрсний улмаас иргэдийн амьдрал өөрчлөгдөх, одоогийн үнэ цэнэ, тогтолцооны ойлголтыг үндсээр нь өөрчлөх радикал шинэчлэл хийгдэх гэх мэт)-үүд төрөл бүрийн арга замаар хурдацтай явагдаж байна. Японы засгийн газар дижитал агентлаг байгуулах чиглэлээр ахиц дэвшил гаргаж байгаа нь харагдаж байна. Энэ нь хувийн хэвшилд маш чухал чиг хандлага гэдэгт би итгэлтэй байна. Бизнесийн салбар COVID-19 цар тахлын улмаас гарч буй эрсдлүүдийг мэдэрч, боломж болгон ашиглах нь зүйтэй.

Гэвч сүлжээнээс хараат байдал нэмэгдэж байгаа нь аюулгүй байдалд учрах эрсдлийг нэмэгдүүлж байна. Сүлжээ болон аюулгүй байдал нь нэг машины хоёр дугуйтай адил бие биенээсээ хамаарч байдаг. Энэ хоёр ойлголтын хоорондох тэнцвэрийг хадгалах нь бидний үргэлж санаж явах ёстой нэгэн үүрэг юм. Боловсролын салбарт бид лекц болон хичээлд Zoom-ийг тогтмол ашигладаг. Хувийн хэвшилд аюулгүй байдлыг илүү сайжруулсан онлайн хурлын системийг нэвтрүүлж байна. Үүний нэгэн адилаар дансны баталгаажуулалтыг хийхэд данс ээзмшигчдийг хэрхэн шалгах вэ гэдэг асуудлыг хувь хүний нууц хадгалах шаардлагатай уялдуулах ёстой. Ингэхдээ бидний хүсч буй зүйл болон бидэнд шаардлагатай байгаа аюулгүй байдал хоорондын тэнцвэрийг хадгалсан шийдлийг сонгох нь чухал юм. Дижиталчлалыг сайжруулахын тулд сүлжээ ба аюулгүй байдал хоорондох тэнцвэрийг үргэлж харгалзан үзэж байх ёстой.

Кибер халдлага гарах үед бид ямар түвшинд сөрөг довтолгоо хийж чадах вэ

—— Кибер халдлага дэлхий дахинд өсөн нэмэгдсээр байна. Мөн улам аюултай болж байна.

Орос улс 2016 оны АНУ-ын Ерөнхийлөгчийн сонгуульд оролцсон хэмээн шуугиж байна. Зарим улсад орон зайн хүчин болон кибер хүчинг байгуулснаар газрын, далайн, агаарын тулааны талбарын дараа орох дөрөв дэхь эсхүл тавь дахь тулааны талбараар орон зайн болон кибер орон зайг авч үзэх болсноор хариу арга хэмжээ авч байна. Цахим халдлагын эсрэг хариу арга хэмжээгээ чангаттах шаардлагатай байгаа нь тодорхой байна. Гэвч бид өөрсдийгөө хамгаалахын тулд хэр хол явах ёстой вэ? Энэ асуудлаар бид олон улсын зөвшилцөлд хүрэх шаардлагатай юм. Өнөөгийн ихээхэн маргаан дагуулж буй асуудлууд: Пуужингийн довтолгоог зогсоохын тулд дайсны пуужингийн баяз руу довтолдгийн адилаар аль нэг улс орон кибер халдлагын эсрэг сөрөг довтолгоонд хэр хол явж чадах вэ? Бидэн рүү халдсан сайтууд руу бид хэр зэрэг хүчтэй халдаж чадах вэ? Пуужингийн бааз магадгүй тухайн улсад дотоодод байрладаг байж болох юм. Гэвч кибер халдлага дэлхийн хаанаас ч хийгдэх боломжтой. Кибер халдлагад ашиглаггдаг серверийг Японоос өөр улсад хялбархан байршуулах боломжтой. Бид энэхүү аюул заналхийлалтай тэмцэх технологитой байх ёстой. Урагш алхахын тулд нийгэм кибер халдлагын эсрэг тэмцэх арга замуудыг тодорхойлох зорилгоор харилцан зөвшилцөх шаардлагатай байна. Кибер халдлага нь зөвхөн төр, засгийн газрын түвшинд төдийгүй хувийн хэвшлийн түвшинд ч мөн тохиолддог. Үнэндээ интернетэд маш олон хөрөнгө байршсан байдаг. Виртуал валютаар гүйлгээг эхэлж, дижитал валют болон дижитал төлбөр тооцооны протоколоор дамжуулах замаар гүйлгээ хийж онлайнаар мөнгөний зарцуулалт хийдэг. Мөн хувьцаа болон үл хөдлөх хөрөнгийн талаарх мэдээллийг цахим дата-аар хүлээн авах боломжтой. Японы компаниуд оюуны өмчийн талаар маш их хэмжээний мэдээлэл ээзэмшдэг бөгөөд өш санасан этгээдүүд үүнийг онилсон байдаг. Том компаниуд кибер халдлагад байнга өртөж байдаг. Төгс аюулгүй байдал гэдэг зүйл байдаггүй тул эдгээр компаниуд ийм аюул заналхийлэлтэй тэмцэх бэлтгэлтэй байх ёстой.

Сүлжээний талаарх мэдээлэл нь үндсэндээ ил тод байдаг

—— Энгийн иргэд бид ч гэсэн кибер халдлага болон кибер хулгайн аюул заналхийлэлд байнга өртөж байдаг.

Хэрэглэхэд хялбар учраас бид цахим төлбөр тооцоо, цахим мөнгө зэргийг илүүд үздэг боловч хакердахад хялбар байдаг тул бид байнга сонор сэрэмжтэй байх шаардлагатай. Апп-уудын хэрэглэхэд хялбар онцлог шинжийг харгалзан үзэхээс гадна аюулгүй байдлын урхи болон далд аюул эрсдлийг байнга харгалзан үзэх шаардлагатай. Онлайн байхын тулд ойролцоох үнэгүй WiFi холболтыг ашиглах нь биднийг нууцаар чагнах, хакердах гэх мэт аюулд өртүүлдэг. Үндсэндээ сүлжээний талаарх бүх мэдээлэл нь ил тод байдаг тул нууцаар чагнах болон тагнах боломж бүрдүүлдэг. Та мэдээлэл илгээх үедээ хэн нэгэн нь харж байж болзошгүй гэж тооцоолж байх хэрэгтэй. Өөрийн санхүүгийн дансандаа хандах эсхүл хувийн мэдээллээ оруулах замаар сүлжээнд нэвтрэх үедээ "Хэрэв хэн нэгэн үүнийг харж байвал би зүгээр байх болов уу?" гэдэг асуултыг үргэлж санаж байх хэрэгтэй. Жишээлбэл, та мэдээлэл илгээхээсээ өмнө үүнийг зөв шифрлэсэн эсэхээ дахин шалгаж нягтлаарай. Энэ нь тийм ч амар биш, гэхдээ энэ алхамыг хийх бүрдээ санаж байх нь чухал юм. Мэдээжийн хэрэг эдгээр аюулгүй байдлын арга хэмжээнд технологи чухал үүрэг гүйцэтгэдэг боловч эцэст нь ухамсар, ухаалаг байдлыг орлож чадахгүй.

Оюутны хот Киото

Байгуулагдсанаас хойш 1200 гаруй жилийн түүхтэй Киото хот нь эртний үеэс эхлээд Японы соёлын төв газар, олон улсын хот байсан ба орчин үеийн олон залуучуудын амьдрах дуртай оюутнууд хот ч юм.

KCG-н оюутны кампус нь зам тээврийн сүлжээнд ойрхон, Киото хот дотроо түүнчлэн Осака, Нара болон Кобе Оцу зэрэг Кансай бүс нутгуудад чөлөөтэй явж болох тээврийн сүлжээтэй юм.

Киотогийн төв сургууль, KCGI Хякүманбэн кампусын эргэн тойрон

Мүромачи соёлын бэлэг тэмдэг Гинкакү сүм, Киотогийн гурван том наадмын нэг Юкаригийн энх тайвны хийд, интоорын модоороо нэрд гарсан гүн ухааны зам, япондоо хамгийн хуучнаараа хоёрт ордог амьтны хүрээлэн, Киото хотын амьтны хүрээлэн, Киото хотын дүрслэх урлагын музей зэрэг олон үзвэрийн газруудтай, Киотогийн олон түүх, соёлын газруудыг үзэх боломжтой.

Үзэх газар

- Гинкакү мөнгөн сүм
- Гүн ухааны зам
- Нанзэн сүм
- Киото хот KYOCERA урлагийн музей
- Киото хотын амьтны хүрээлэн
- Хэйанжингү хийд
- Эйкандо хийд
- Чион сүм
- Улсын нэрэмжит орчин үеийн урлагын музей

KCG Ракүхокү сургуулийн эргэн тойрон

Китаожи метроны буудал, автобусны терминал, Ракүхокү бүсийн Киотогийн төвөөр нэвтрэн Киото буудал руу холбогдсон тээврийн сүлжээ сайтай. Орчин үеийн өндөр барилгуудтай Китаяма гудамжийн ойролцоо, Aoi Yukari-н, Камигамо хийд байдаг ба ургамлын хүрээлэн, Мидоро цөөрөм, Камо гол үзэрэг байгальтай ойрхон газарт оршино.

Үзэх газар

- Камигамо хийд
- Мидоро цөөрөм (Мөн Мизорога-Икэ цөөрөм гэж нэрлэдэг)
- Киото мужийн Ботаникийн цэцэрлэг
- Китаяма гудамж

KCGI Киото Экимаэ хиймэл дагуулын кампусын эргэн тойрон

JR, Кинтэцү, метроны шугмаар холбогддог Киотогийн буудал бол бүх улс орны өнцөг булан бүрээс олон хүн ирж очдог Киотогийн үүд хаалга юм. Буудлын ойролцоо орчин үеийн барилга байгууламжууд түүхэн барилгатай зэрэгцэн оршдог ба эрс ялгаатай уур амьсгалыг та мэдрэх болно.

Үзэх газар

- Тожи сүм
- Хигаши Хонган сүм, Ниши Хонган сүм
- Тофүкү сүм
- Киотогийн цамхаг
- Санжюүсангэндо хийд
- Улсын нэрэмжит Киото музей
- Киото буудлын барилга
- Киотогийн аквариум

KCG Камогава сургуулийн эргэн тойрон

Киотогийн гурван том наадмын нэг Aoi Yukari-н дор Шимогамо хийд болон Kyotogyoen зэрэгт ойрхон байдаг байгалийн үзэсгэлэнт газраар баялаг хэсэг юм.

Үзэх газар

- Шимокамо хийд
- Киото гёэн
- Тадасүгийн ой
- Киото хотын түүхийн музей

kcg.edu боловсролын сүлжээ

Киотогийн мэдээлэл технологийн эрдмийн зэрэг олгох их сургууль нь KCG группын боловсролын бусад байгууллагатай нягт холбоотой сүлжээгээр холбогдон, гадаад улсын засгийн газар, их дээд сургуультай хамтран ажиллаж, боловсролын байгууллагаар дамжуулан, мэдээллийн технологийг манлайлан, дэлхийн өндөр түвшний мэдээллийн технологийн боловсролыг түгээхийг зорьж байна.

1963 онд үүсгэн байгуулагдсан Японы анхны компьютерын боловсролын байгууллага болж 55-с илүү жилийн уламжлал, амжилтаараа бахархан, 50,000 орчим төгсөгчид нь Японы мэдээллийн үйлдвэрлэлийн хамгийн том хүний сүлжээг бүрдүүлж байна.

Мэдээллийн технологийн чиглэлийн тэнхимийг АНУ-д хамгийн эхэнд (1991 он) нээгдсэнээр алдартай, 1829 онд байгуулагдсан инженерийн их сургууль. Бид компьютер график, тоглоом, IT-ийн салбарт АНУ-ын топ байр суурийг даван гарах болно. Киото компьютерийн Гакүинтай 1996 онд шифийн харилцаа тогтоосон.

Киото компьютерийн Гакүин
kcg.edu
Kyoto Computer Gakuin
KCG

RIT
Рочестерийн технологийн их сургууль

Киото автомашины мэргэжилийн сургууль
kcg.edu
Kyoto Computer Gakuin Automobile School
KCGM

Киотогийн мэдээлэл технологийн эрдмийн зэрэг олгох их сургууль
kcg.edu
The Kyoto College of Graduate Studies for Informatics
KCGI

Дараа үеийн автомашины технологит тохируулсан өндөр түвшиний IT, сүлжээний технологи мэдлэгийг эзэмшсэн автомашины техникчийг бэлтгэнэ.

Киото япон хэл сургалтын төв
kcg.edu
Kyoto Japanese Language Training Center
KJLTC

Япон хэлний боловсролын байгууллага болох тус төв нь, хууль зүйн яамны заасан Япон хэлний боловсролын байгууллага бөгөөд, соёлын яамны бэлтгэл боловсролын зааврыг хүртсэн.

kcg.edu
Kyoto Computer Gakuin - U.S.A.
Нью Йоркын оффис

kcg.edu
Kyoto Computer Gakuin - China
Бээжин оффис
Далянь оффис
Шанхай оффис

kcg.edu
Kyoto Computer Gakuin - Vietnam
Ханой дахь оффис

KCG группын эрхэлдэг хилийн чанад дахь үйл ажиллагааны суурь болгон 2000 онд Нью Йоркын дэлхийн гадаад худалдааны төв (WTC)-д нээгдсэн. Америкийн террорист халдлагад өртөж хохирол амссан боловч Рокфеллер төв байранд албан конторoо нээж, үйл ажиллагаагаа явуулж байна.

Хятадын их сургуулиудтай өргөн цар хүрээтэй харилцаж буй харилцаа холбооны нэгэн суурь болж, 2002 онд Бээжин хотын Үндэсний номын санд KCG Бээжин оффис нээгдсэн билээ. Түүнчлэн 2008 онд KCG Далянь оффис, 2018 онд Шанхай дахь салбар оффисийг нээн Хятадын их, дээд сургуулиудад МТ-ийн боловсрол олгох үйл ажиллагааг эхлүүлсэн.

2019 онд KCG нь Вьетнам дахь KCG-ийн анхны бааз болох Ханой дахь оффисоо нээсэн.

KCGI-н товч танилцуулга

Нэр: The Kyoto College of Graduate Studies for Informatics
(Киотогийн мэдээлэл технологийн эрдмийн зэрэг олгох их сургууль)
Бүтэц: Киото мэдээллийн гакүэн сургууль
Байршил: 7 Tanakamonzen-cho, Sakyo-ku, Kyoto 606-8225, Japan
Судалгааны тэнхим: Мэдээлэл технологийн инженерчлэл, судалгааны тэнхим
Мэргэшсэн анги: Вэб бизнесийн технологийн мэргэшсэн анги
Төгсөлтийн кредит цаг: 44 кредит цаг
Элсэн суралцах сурагчдын тоо: 600 хүн
(Нийт боловсон хүчин 1,200 хүн.)
Суралцах жил: 2 жил
Зэрэг цол: Master of Science in Information Technology (M.S. in IT)
(Мэдээллийн технологийн шинжлэх ухааны мастер (IT-MS))

URL: https://www.kcg.edu/

KYOTO

Киото хот нь японы уламжлалт соёл урлагын төв газар бөгөөд Rohm болон Мурата үйлдвэрлэл ХХК, Nintendo, Нориба, Кёосэра, Nidec, Omron зэрэг японы аж үйлдвэрийн салбарыг тэргүүлдэг мэдээллийн технологийн чиглэлийн олон алдартай компануд энд оршдог. Мөн олон Нобелийн шагналтанууд Киотогоос төрж гарсаар байна. Тус сургууль Киотогийн хөрс шороонооc гарах энергиэс хүртэн, сургуульдаа тахидаг.

Киотогийн төв сургууль, Хякүманбэн кампус



Хаяг: 7 Tanakamonzen-cho, Sakyo-ku, Kyoto, 606-8225, Japan
Тээврийн хэрэгсэл:
Хякүманбэнгийн замын уулзвараас хойд зүг рүү алхаад 1 минут
"Дэмачи янаги" буудлаас алхаад 8 минут Кэйхан галт тэрэг / Эйзан галт тэрэг
Киото буудлаас 17 тоот хотын автобусанд сууж "Хякүманбэн"-д бууна, 206 тоот хотын автобусанд сууж "Асүкай мачи"-д буухад ойрхон

Киотогийн төв сургууль, Киото Экимаэ хиймэл дагуул



Хаяг: 10-5 Nishikujoteranomae-cho, Minami-ku, Kyoto, 601-8407, Japan
Тээврийн хэрэгсэл:
"Киото" буудал Хачижёонишигүчи баруун зүг рүү алхаад 7 минут

Саппоро хиймэл дагуул

Хаяг: Daigo Building 7th floor (inside dGIC Inc.), 5-11 Odorinishi, Chuo-ku, Sapporo, 060-0042, Japan
Тээврийн хэрэгсэл:
Метроны Одори буудлаас 2 номерын гарах хаалгаар хойд зүг рүү алхаад 1 минут

Токио хиймэл дагуул



Хаяг: VORT Мотоазабу 4 давхар (ХК) Hitomedia, 3-1-35 Motoazabu, Minato-Ku, Tokyo
Тээврийн хэрэгсэл:
Токио метроны Хибия шугам "Роппонги" буудал 1а хаалгаар гараад 8 минут алхана
Тоэй Оэдо метроны шугам "Роппонги" буудал 3 хаалгаар гараад 10 минут алхана